



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-9
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	10-115

---

<b>1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/</b>	10-21 41-42
<b>2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/</b>	21-30 43
<b>3.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан</b>	30-40 43-115

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
3 дугаар сарын 31-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнхтуяа, Г.Хосбаяр;

Чөлөөтэй: Ч.Анар, Х.Баттулга, Ц.Даваасүрэн, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Батцэцэг, Ж.Ганбаатар, А.Ундраа, С.Цэнгүүн, Л.Энхнасан;

Тасалсан: Ц.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, Б.Энхбаяр;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-06 минут, Н.Алтаншагай-01 минут, Д.Амарбаясгалан-3 цаг 35 минут, С.Амарсайхан-2 цаг 54 минут, О.Амгаланбаатар-52 минут, Э.Батшугар-02 минут, Ж.Баярмаа-11 минут, Х.Болормаа-09 минут, Х.Булгантуяа-29 минут, Ж.Галбадрах-01 минут, А.Ганбаатар-1 цаг 58 минут, С.Ганбаатар-10 минут, Д.Ганбат-04 минут, Т.Доржханд-54 минут, Б.Жавхлан-28 минут, Б.Заяабал-1 цаг 38 минут, Ч.Лодойсамбуу-07 минут, Г.Лувсанжамц-11 минут, М.Мандхай-29 минут, Т.Мөнхсайхан-03 минут, П.Мөнхтулга-3 цаг 35 минут, З.Мэндсайхан-39 минут, Ч.Номин-3 цаг 12 минут, Н.Номтойбаяр-1 цаг 25 минут, Б.Пунсалмаа-57 минут, П.Сайнзориг-06 минут, О.Саранчулуун-37 минут, Р.Сэддорж-37 минут, Б.Түвшин-07 минут, Г.Тэмүүлэн-12 минут, Н.Учрал-1 цаг 01 минут, Б.Хэрлэн-12 минут, Д.Цогтбаатар-24 минут, Ж.Чинбүрэн-1 цаг 23 минут, Б.Чойжилсүрэн-06 минут, Ж.Энхбаяр-24 минут, М.Энхцэцэг-1 цаг 04 минут.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт** /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан, Цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Г.Очирбат, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:38/

***Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Р.Батрагчаа оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Р.Батрагчаа, Цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Г.Очирбат, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:03/

***Гурав.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дашпүрэв, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баярмагнай, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Түвшинжаргал, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төсөл, хөтөлбөр, гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга Э.Цэнгүүн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Б.Мөнхбаяр, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нарангэрэл, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга, ахлах зөвлөх А.Даваажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Дэд дарга Г.Эрдэнэбат, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх

Ч.Батбямба, референт О.Мөнгөнчавхдас, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, мөн газрын ахлах референт Д.Цэцэгмаа нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, тайланг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороодоос гаргасан хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар тус тус танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хэлэлцэж буй асуудлыг түр хойшлуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэх асуудлуудын санал хураалтыг явуулах горимын санал гаргав./15:35/

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 55

Бүгд: 104

47.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир санал хураалтаас хоцорсон тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 53

Бүгд: 104

49.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 48

Бүгд: 105

54.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 45  
Бүгд: 105  
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийн талаарх санал хураалтыг тус тус явуулав./15:37/

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт**  
*/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/-ийн талаарх санал хураалт*

*Байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлт тус бүрээр санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 40  
Бүгд: 105  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. ..." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 38  
Бүгд: 105  
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн

дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 38  
Бүгд: 105  
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор ... шийдвэрлэнэ." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 38  
Бүгд: 105  
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тул "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийн тухай" Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

*Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.*

***Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай//-ийн талаарх санал хураалт***

*Байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлт тус бүрээр санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд "Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 40  
Бүгд: 105  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 40  
Бүгд: 105  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тул “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

*Уг асуудлыг 15 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.*

***Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг асуулт, хариултаар үргэлжлүүлэн хэлэлцэв.***

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, О.Номинчимэг, Б.Уянга, Г.Очирбат, Д.Энхтүвшин, О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир, О.Батнайрамдал, Ө.Шижир, Л.Гантөмөр, С.Эрдэнэбат, М.Ганхүлэг, Э.Болормаа, Г.Ганбаатар, Ц.Туваан, П.Сайнзориг, Г.Лувсанжамц, Д.Ганмаа, Ж.Галбадрах, Ц.Идэрбат, Ч.Номин нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга, ахлах зөвлөх А.Даваажаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалай, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дашпүрэв, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ чуулганы нэгдсэн хуралдааны цагийг сунган хуралдах тухай мэдэгдэв./18:03/*

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Л.Мөнхбаясгалан, Г.Очирбат, Д.Энхтүвшин, М.Мандхай, Д.Ганмаа, Ч.Номин нар үг хэлэв.

*Уг асуудлыг 19 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 5 цаг 48 минут үргэлжилж, 126 гишүүнээс 110 гишүүн хүрэлцэн ирж, 87.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 50 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг  
Төрийн ордон “Их хуралдай”  
танхим  
14 цаг 02 минут

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд гишүүдийн ирцийг танилцуулъя. 126 гишүүнээс 73 гишүүн ирж, 57.9 хувьтай байна.

Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 3 асуудлыг хэлэлцэнэ.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ. /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

3.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

**1 дүгээр асуудал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт.**

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Мөнхсайхан таныг индэрт урьж байна.

**О.Мөнхсайхан:** Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалагч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, илтгэгч Ц.Цолмон, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Д.Отгонбаяр, С.Номынбаясгалан нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт нь нийт 19 хуудас, түүний үндэслэл хэсэг нь дангаар 15 хуудас учраас дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсоё.

#### Үндэслэл

1.Монгол Улсад 1992 оны Үндсэн хуулиар парламентын тогтолцоог бий болгосон бөгөөд энэ тогтолцоо нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд багтаж хамгаалагдана. Улсын Их Хурал нь ард түмнээс сонгож байгуулагдсан төрийн эрх барих дээд байгууллага тул төрийн гүйцэтгэх дээд байгууллагыг бүрдүүлэх болон түүний үйл ажиллагаа нь шийдвэрлэх нөлөөтэй.

Өөрөөр хэлбэл, Засгийн газар нь легитим шинжээ парламентаас буюу түүний дэмжлэгийг хүлээх чадвараас олж авдаг. Парламентын тогтолцоонд парламент буюу Улсын Их Хурал нь Ерөнхий сайдыг томилох замаар Засгийн газрыг эмхлэн байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Засгийн газар нь Улсын Их Хурлын өмнө хариуцлага хүлээж, түүний олонхын итгэл дээр тулгуурлан орших учраас уг итгэлийг алдвал огцрох боловч, үүнд Улсын Их Хурал хариуцлагатай хандах зохицуулалтыг 2019 онд Үндсэн хуульд тусгасан байна.

Засгийн газар Улсын Их Хурлын өмнө хариуцлага хүлээх хамгийн энгийн хүчтэй хэлбэр нь Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн саналаар, Ерөнхий сайдыг огцруулах эсэхийг шийдвэрлэх санал хураалт юм.

Түүнчлэн Ерөнхий сайдын зүгээс өөрт нь итгэл хүлээж буйгаа албан ёсоор илэрхийлэхийг Улсын Их Хурлаас хүсэж, төсвийн болон бодлогын тодорхой асуудлын шийдлийг Засгийн газрын оршин тогтнох эсэх санал хураалтаар хамтад нь шийдвэрлүүлэх боломжтой.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх Ерөнхий сайдыг огцруулахыг дэмжсэн, эсвэл Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг батлаагүй бол Ерөнхий сайд, Засгийн газар огцорно. Ийнхүү огцруулснаас хойш 30 хоногийн

дотор шинэ Ерөнхий сайдыг томилоогүй бол Улсын Их Хурлыг тараах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана.

Иймээс Улсын Их Хурлын санаачилгаар Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг эсвэл Ерөнхий сайдын санаачилгаар түүнд итгэл хүлээлгэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэх нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын харилцан хяналт тэнцлийн чухал хөшүүрэг мөн.

2.Засгийн газрын бие даасан, тогтвортой, хариуцлагатай байдлыг хангах танхимын зарчмыг бэхжүүлэх зорилгоор Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавивал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол “Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно гэж 2019 онд өөрчлөн найруулжээ.

Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт Улсын Их Хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол “Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцохоор заасан.

Энэ өгүүлбэрийн “уг санал” гэдгийг тус хэсгийн 1 дэх өгүүлбэрт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь албан ёсоор тавьсан Ерөнхий сайдыг огцруулах санал гэж ойлгох бөгөөд уг санал нь Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлбэртэй байхаар байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж зохицуулж, Үндсэн хуулийн тус хэсгийг зөрчсөн байна.

Энэхүү зохицуулалтын гишүүд гэдэг нь Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй гэж шууд ойлгогдохгүй байх төдийгүй улсын Үндсэн хуулийн бичвэрт 3 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж илт тодорхой заасан хугацааг 7 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж 4 хоногоор уртасгаж, улмаар Улсын Их Хурал Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэн шийдвэрлэх 7 хоногийг 3 хоног болгон богиносгосон байна.

3.Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар шийдвэрлэнэ гэж 2019 онд өөрчлөн найруулсан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээх тогтоолын төслийг оруулбал

Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж зохицуулж, Үндсэн хуулийн тус хэсгийг зөрчсөн байна.

Учир нь Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээх тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш 3 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж Үндсэн хуулийн бичвэрт илт тодорхой заасан хугацааг 7 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж 4 хоногоор уртасгажээ. Түүнчлэн уг тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулснаас хойш 10 хоногийн дотор шийдвэрлэхээр Үндсэн хуулийн бичвэрт илт тодорхой заасан хугацааг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор гэж уртасгасан тул уг тогтоолын төслийг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэх. Ийнхүү хэлэлцэж эхэлснээс хойш 10 хоногийн дотор буюу нийт 17 хоногийн дотор шийдвэрлэхээр ойлгогдож байна.

4.Маргаан бүхий зохицуулалттай холбоотой бусад асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Ерөнхий сайдыг огцруулах, эсвэл түүнд итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураахаар тодорхой хуульчилбал зохино.

Маргаан бүхий 2 зохицуулалтад уг асуудал гэж бүрхэг заасныг илүү өргөн, эсвэл салаа утгаар хэрэглэх боломжтой тул Ерөнхий сайдыг огцруулах, эсвэл Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг батлахыг дэмжих агуулгаар санал хураах Үндсэн хуулийн утгыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Ерөнхий сайдыг огцруулах, эсвэл түүнд итгэл хүлээх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлснээс хойш 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэхээр заасан нь уг хугацаанд Улсын Их Хурлын гишүүн бүр уг санал буюу тогтоолын төсөлтэй тэгш эрхтэйгээр танилцах, судлах, асуулт саналаа боловсруулах, Ерөнхий сайд хариу тайлбараа бэлдэх боломж олгох зорилготой тул түүнийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн даруйд Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлэх нь зүйтэй байна.

Гэтэл өргөн мэдүүлсэн даруйд гишүүдэд хүргүүлэхийг үүрэгжүүлсэн зохицуулалтыг хуульчлаагүй байгаа нь Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж Үндсэн хуульд заасан шаардлагыг зөрчих нөхцөлийг бий болгохоор байна.

Ерөнхий сайдыг огцруулах, эсвэл түүнд итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэх хугацааг Үндсэн хуульд заасан тул эдгээр тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр энэ хугацааны дотор удаашралгүй шууд шийдвэрлэхээр зохицуулах нь зүйтэй байна.

Гэтэл ийм зохицуулалтыг хуульчлаагүй нь түүнийг 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэх Үндсэн хуулийн шаардлага зөрчигдөх эрсдэлийг үүсгэхээр байна.

Ерөнхий сайдыг огцруулах, эсвэл түүнд итгэл хүлээлгэх эсэх нь парламентын тогтолцоотой улсын хувьд Байнгын хорооны оролцоогүйгээр нэгдсэн

хуралдаанаар шууд хэлэлцэн шийдвэрлэх төрийн эрх мэдлийн хяналт тэнцлийн асуудал юм.

Байнгын хороо бол хууль тогтоох үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд Ерөнхийлөгч, эсвэл парламентын тогтолцоотой эсэхээс үл хамааран хууль тогтоох үйл ажиллагаанд голлох үүрэгтэй оролцдог байна.

Иймээс Ерөнхий сайдыг огцруулах, эсвэл түүнд итгэл хүлээх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороогоор хэлэлцүүлэх зайлшгүй шаардлагатай эсэхийг нягталж холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

5.Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны Үндсэн зарчим мөн бөгөөд түүний агуулга нь ардчилсан эрх зүйт төрийн үнэт зүйлсийг өргөн хүрээнд хамгаалж, Үндсэн хуульд ёсны суурь үзэл баримтлалыг багтаана.

Тухайлбал, хууль дээдлэх ёс нь эрх зүйн тодорхой байдлыг хангах, аливаа хууль, эрх зүйн акт Үндсэн хуульд нийцсэн байх зэрэг зарчмыг баримтлахыг шаардана. Эрх зүйн тодорхой байдал нь хуулиар юуг зөвшөөрч хориглох ямар эрх эдлүүлж, үүрэг хүлээлгэж байгааг мэдэх, хуулийг сахин биелүүлснээр үүсэх үр дагаврыг урьдчилан таамаглах үүнийхээ Үндсэн дээр үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх боломжийг баталгаажуулдаг.

Маргаан бүхий зохицуулалт нь Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус нийцээгүй төдийгүй уг асуудал зэрэг ойлгомжгүй нэр томъёог хэрэглэж эрх зүйн тодорхой байдлыг хангаагүй байх тул хууль дээдлэх ёсыг зөрчсөн байна.

6.Энэхүү дүгнэлт нь гарсан цагаасаа хойш “Ех пунс” үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай болохыг тэмдэглэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасанд нийцээгүй байна.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны Үндсэн зарчим мөн, 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасанд нийцэхгүй байна.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэж, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш гэж заасныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Ц.Цолмон, Б.Болдбаатар.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Өргөдлийн байнгын хорооны дарга Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Номинчимэг Таныг урьж байна.

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийг холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 12 дугаар дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаан Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар танилцуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс цэцийн дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны Үндсэн зарчим мөн, 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны Үндсэн зарчим мөн, 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дараа шийдвэрлэнэ гэж заасантай тус тус нийцээгүй байна гэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг Монгол

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.2 дахь заалтын дагуу зүйл, хэсэг, заалт бүрээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир таныг урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг 2026 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны журмын дагуу 26 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч миний бие Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101 дэх хэсэгт уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны Үндсэн зарчим мөн, 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасныг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ. Түүнээс хойш гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны Үндсэн зарчим мөн, 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасантай тус тус нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2 дахь хэсэг, заалтын дагуу зүйл, хэсэг, заалт бүрээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

Очирбатаар тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Яах вэ нөгөө их алдартай хэсэг гэдэг шиг л ил нэлээд чухал Дэгийн хуулийн чухал заалтуудыг ярьж байна. Энэ үүнтэй холбоотойгоор 2025 оны 12 дугаар сарын 26-наас эхлээд эдгээр заалтуудыг түдгэлзүүлчихсэн байгаад байгаа юм байна шүү дээ.

Тэгэхээр яг одоогоор Ерөнхий сайдын маргаантай холбоотой энэ заалтууд Ерөнхий сайдыг огцруулах гэдэг юм уу, итгэл үзүүлэхгүй байгаа энэ цаг үед яах вэ гэдэг энэ хуулийн заалтууд түдгэлзүүлчихсэн байхгүй байгаа л гэсэн үг юм байна л даа. Тэгэхээр Улсын Их Хурал энэ цэцийн энэ дүгнэлтийг хүлээж аваад шуурхай энэ заалтуудаа Үндсэн хуульд нийцүүлж буюу энэ 7 гэснийг 10 болгох, 10 хоногийн дотор болгох гэж засах юм байна. Энийгээ энэ шуурхай хийж хэрэгжүүлнэ гэдгийгээ ойлгож бид шуурхайлж ажиллах ёстой.

Тэгээд үүнтэй холбоотойгоор би бас юуг хэлэх гээд байна вэ гэхлээр энэ 10 хоногийн, Үндсэн хуулийн энэ 10 хоног дотор хэлэлцэнэ гэдэг энэ хугацаатай холбоотой. Хэрэвзээ тухайн үеийн чуулганыхаа ирцэд орохгүй байвал яах вэ гэдэг л ийм зохицуулалтыг бид нар энэ Дэгийн хуульдаа бас оруулах ёстой юм болов уу гэсэн ийм гашуун туршлагаас гэдэг шиг ийм л бодолтой байна. Тэгээд энэ саналыг бас тухайн хуулийн өөрчлөлтийг хийхэд бид бас бодолцох ёстой юм байна.

Булгантуяа дэд даргын хувьд энэ хуулийн хугацаандаа багтах гэж л хөөрхий амьтан Пүрэв гаргаас, өглөөний 9 цагаас авхуулаад л ирцийнхээ бүртгэлийг нээж эхлээд л шөнөжингөө гуйгаад л маргааш өглөө нь тэгээд л арай гэж ирц бүрдээд л явсан юм байгаа юм шүү дээ. Бас л яг энэ Үндсэн хуулийн энэ хоногтой холбоотой л байсан байхгүй юу. Хоног нь өнгөрчих гээд. Тэгээд яг энэ Үндсэн хуулийнхаа энэ оноосон хоног дотроо асуудлаа шийдвэрлэж чадахгүй бол бас л энэ Үндсэн хуулиар заасан хоногийг зөрчсөн л асуудалд орох гээд байсан байхгүй юу. Тэгэхээр тухайн үед чуулгандаа ороогүй, ирцдээ ороогүй бойкотлоод байсан гишүүд өөрөөсөө нэхээгүй ёс зүйг өнөөдөр бусдаас нэхээд ичгүүргүй бас элдэв янзын юм яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр ер нь энэ чуулганыхаа ирцэд орохгүй энэ Үндсэн хуулийн хугацаатай ийм асуудалд орохгүй яах вэ гэдэг асуудлыг ч гэсэн бид нар цаашдаа бодох ёстой юм байна шүү гэдэг ийм саналыг зайлшгүй хэлмээр байна. Булгантуяа чуулганы хуралдааныг удирдаж, ирцийг бүхэл бүтэн өдөр шөнөгүй хүлээж нэхэн шаардаж суусныхаа төлөө өнөөдөр гэм буруутай юм шиг, нийгэмд ч тэр тухайн байгууллагуудаар ч тэр хянагдаад шалгагдаад ийм дүгнэлт гаргуулаад явж байгаа нь үнэхээрийн харамсалтай байж боломгүй бүр аймшигтай ёстой жинхэнэ шившиг, шившгийн шившиг гэвэл ёстой тэрийг л хэлнэ байх.

Тэр 95 дугаар тогтоол. 95 дугаар тогтоолыг Цэц хүчингүй болгох ийм шийдвэр гаргасан. Тэгсэн мөртөөсөө дүгнэлт. Тэгээд үүнийг Улсын Их Хурлаар бид нар хэлэлцэж ямар нэгэн байдлаар хүчингүй болгох үйлдлээ хийгээгүй шүү дээ. Тэгээд хэвлэн нийтэлсэн ч асуудал байхгүй. Энийг тэг тэгээд л таг чимээгүй, үг дуугүй ингээд л өнгөрсөн.

Өлзийсайхан даргыг Ерөнхий нарийн бичгийн даргаар томилогдсон хойно нь би бас яг энэ 95 дугаар тогтоолтой холбоотой ямар нэгэн юм хийх хэрэгтэй шүү. Энэ шийдвэр гаргаарай гэж хэлж байсан. Эс үгүй бол тэгээд хүчингүй болсноор нь төрийн хэвлэл мэдээллийн тэр эмхэтгэлдээ хэвлэх ёстой юм уу, эс үгүй бол яг яах ёстой юм? Ямар нэгэн үйлдэл хийж энэ 95 дугаар тогтоолыг бас эцсийн энэ хүчингүй болгох ийм үйлдлийг уг нь хэн нэгэн газар хийх ёстой. Тэр нь бол Цэц биш. Хаа нэгтээ хэвлэгдэж юм уу, хаа нэгтээ юм хийгдэх ёстой. Тэгээд л үг дуугүй ингээд л чимээгүй дараад л суучхаж байгаа байхгүй юу. Тэгэхдээ түүх тэгээд л түүхээрээ үлдэнэ шүү дээ. Хэзээ нэгэн цагт энийг чинь тэгээд л нөхөж хараад л сөхөөд л юу болсон бэ гээд л харах л байлгүй дээ. Тэгээд цаасан дээр энэ чинь үлдэх л ёстой шүү дээ. Энэ агуулгыг нь анхаарах ёстой юм шүү гэдэг л ийм үгсийг протоколд тэмдэглэж үлдээе дээ. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үг хэллээ. Ганбатын Очирбат.

**Г.Очирбат:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт бол маш ноцтой гэсэн агуулгыг хөндөж байгаа. Урьд нь ийм дүгнэлт ер нь бараг гарч байгаагүй байх. Үндсэн хуулийг ноцтойгоор, санаатайгаар зөрчсөн гэж байгаа. Би гайхаад байгаа юм энэ МАН-ынхан 10 жил эрх барилаа. 2024 он 2024 оны энэ дээр чинь 5 сарын хуралдаан байсан бил үү 4 дүгээр сарын 5-ны өдрөөр өргөн мэдүүлсэн энэ хуулийн төслийг бүгдээрээ нийлж байгаад Байнгын хороон дээрээ санал байхгүй, Их Хурал дээрээ санал байхгүй, Үндсэн хууль дээр 3 хоног, 10 хоног гээд шийдчихсэн байхад Дэгийн тухай хуулийг 7 хоног, 10 хоног болгосон. Энэ бол ноцтой зөрчил. Үндсэн хуулийн цэц ч энийг гаргаад ирлээ.

Тэгэхээр энийг энэ хуулийн төслийг тухайн үед хэн өргөн барьсан юм бэ хэн өргөн мэдүүлсэн юм? Энэ процессуудаа хэн ингээд дамжуулаад дэмжээд явсан юм? Энэ нөхдүүд нь Их Хурлын гишүүний тангараг өргөхдөө Үндсэн хуулиа дээдэлнэ гэхчхэн байдаг. Энийгээ тухайн үед санаж байсан юм уу санахгүй байсан юм уу? Одоо бүгд ярьдаг Үндсэн хуульдаа захирагдана гээд байдаг. Үндсэндээ Үндсэн хуулиа өөрсдөө энд зөрчөөд сууж байна шүү дээ Их Хурлын гишүүд нь.

Тэгээд энийгээ Байнгын хороогоор, би энэ Сандаг-Очир даргаас асуумаар байгаа юм. Энэ Байнгын хороон дээр 1 ч хүн асуулт, хариулт Их Хурал дээр асуулт, хариулт явагдаагүй шууд ингээд дэмжигдээд явсан гээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр та тайлбар өгчих. Ер нь ийм байх, зарчмын ийм ийм байх ёстой юм уу үгүй юм уу? Ялангуяа энэ хоногтой, тоотой хар дээр цагаанаар биччихсэн хугацааг 3 хоног, 7 хоног оруулж ирж байгаа нь ямар ийм цаана нь ямар ийм юу үндэслэл гэдэг юм, агуулга гэдэг юм уу ямар ийм юмыг ингэж харсан юм? Үгүй ээ цаашдаа яах юм тэгээд? Үндсэн хууль дээр өгүүлбэр бичээд оруулчихдаг. Тэрийг нь зүгээр ингээд Дэгийн тухай хууль юм уу, Их Хурлын тухай хуулийг өөрчлөөд л тэгээд л хэн ч хариуцлага тооцохгүй, хэн ч хариуцлага үүрэхгүй тэгээд

л сайхан явж байдаг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандаг-Очир дарга та энэ дээр тэр Үндсэн хуулийн цэц дээр очиж энэ тайлбар өгөхдөө хүртэл энэ бүр ичмээр тайлбар өгсөн байна шүү дээ. Хүн уншаад бүр гайхахаар.

Ер нь цаашдаа яаж явах ёстой юм? Энэ дээр Сандаг-Очир даргаас хариулт авмаар байна. Яаж энэ процессуудыг давсан юм энэ хууль ажлын хэсгийнх, Байнгын хороодынх, Их Хурлын чуулган? Ер нь цаашдаа бид нар Үндсэн хуулиа ингээд дээдлэн сахина гэж тангараг өргөхөөд ингээд өөрчлөөд үг, үсэг дээр нь тоглолт хийгээд яваад байх ёстой юм уу? Энэ бол үнэхээр хариуцлагагүй, зарчимгүй асуудал гарч байна шүү дээ. Одоо зарим хуулийн төслүүдийг өргөн барихдаа хүртэл энэ Их Хурлын тухай хууль болон Дэгийн тухай хуулийг хүртэл зөрчөөд л өргөн барьдаг болсон. Тэгээд л юм болонгуут Цэц дээр аваачна. Цэц тэгээд ингээд буруу, зөв гэдгийг нь ингээд шүүгээд гаргангуут нь нээрээ тийм байна гэдэг.

Бид нар алдаа гаргачхаад уул нь энэ чинь Байнгын хороонууд, мэргэжлийн Байнгын хороонууд байгаад ажлын хэсэг гаргаад байгаа чинь битгий алдаа гаргаач, Үндсэн хуульдаа захирагдаач, тухайн нийгэм эдийн засагтаа дэм, нэмэр болох хуулийн төсөл боловсруулаач гэж л наана нь баахан судалгаа хийж ингэж хуулийн төслөө оруулж ирдэг биз дээ? Тэгэхэд бүр Үндсэн хууль дээр 3 хоног гээд заачихсан байгаа юмыг Их Хурлын дэгийн тухай хуулийг оруулж ирэхдээ 7 хоног болгож оруулж ирсэн.

Тэгээд энэ дээр ямар нэгэн байдлаар Их Хурал дээр дахиад ийм танилцуулах шаардлагатай гэж би зүгээр хувь гишүүнийхээ хувьд үзэж байгаа юм. Мэдээж Цэцийн дүгнэлтийг дэмжиж байгаа. Цэц Үндсэн хуулиа хамгаалж байна. Ер нь гишүүд ийм байгаад байх ёстой юм уу? Тэгээд энэ дээр Сандаг-Очир гишүүнээс тайлбар авчихъя. Ер нь яах юм? Таны энэ Цэцэд өгсөн тайлбар дээр чинь бүр ийм үнэхээр инээдтэй хэдэн өгүүлбэр л байлаа шүү дээ. Цаашдаа ингэж явах юм уу? Тэгвэл Үндсэн хуулиа бид нар сахина гэсэн тангаргаасаа бүгд няцаж байна шүү дээ. Их Хурлын гишүүд тухайн үеийн хоёр мянга.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэндийн Сандаг-Очир гишүүн хариулъя.

**Ц.Сандаг-Очир:** Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. Инээдсээд байх тайлбар байхгүй наана чинь. Үнэн, бодит байдлаа л бичсэн. Энэ алдаатай зөрчлийн тухай, Дэгийн тухай хуулийг засаж залруулах гээд Улсын Их Хурал хуулиа боловсруулж байна л гэсэн тайлбар өгсөн. Энэнээс илүү өөр тайлбар байхгүй. Улсын Их Хурал өөрөө алдаагаа хүлээн зөвшөөрөх ёстой.

Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1-тэй илтэд зөрчилдсөн Дэгийн тухай хуулийг тухайн үеийн 20 оны 5 сард баталсан. Тухайн үеийн парламент өөрөө мэдэж байгаа. Хэн хэн байсан, аль аль намынх нь л байсан. Энэ дээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон нь үнэн. Парламент итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байгаа гишүүн парламентынхаа баталсан хуулийг хэдийгээр байр суурь өөр байгаа ч гэсэн парламентынхаа байр суурийг хамгаалж оролцох үүрэгтэй. Тэр үүднээсээ Улсын Их Хурал ийм Үндсэн хуулийн зөрчилтэй дэгийн хуулийг баталсан нь үнэн. Одоо энэ хуулиа боловсруулаад засах гээд боловсруулж байна гэдэг ийм тайлбараа өгсөн. Энд ичээд байх юм, гайхаад байх юм ерөөсөө байхгүй. Одоо бид нар Дэгийн тухай хуулийн 101.1, 102.1-ийг Үндсэн

хуулийн 43.1-д нийцүүлж хуулийн хугацаанд нь засаж залруулж орж ирэх үүрэгтэй. Таны асуугаад байгаа Байнгын хороо, 2 Байнгын хороон дээр 1 ч гишүүн асуугаагүй гээд байгаа чинь гишүүд өөрсдөө асуудлаа мэдээд, ойлгоод, энэ ойлгомжтой юман дээр юу ч асуух шаардлагагүй юм байна гэдэг үүднээс мэргэжлийн Байнгын хороо Хууль зүй, Төрийн байгуулалт дээр 1 ч гишүүн асуултаа асуухгүй байгаа юм. Учир нь энэ.

Хууль илтэд зөрчсөн гэдгээ өөрсдөө хүлээн зөвшөөрч байгаа учраас энд Цэцийн дүгнэлтийг хүлээж авахаас өөр гарцаагүй, гарцгүй. Тийм учраас энд их гайхаад байх юм байхгүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Харин гайхаад байгаа байхгүй юу. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, итгэмжилсэн төлөөлөгч та шүү дээ. Ер нь цаашдаа бид нар энэ Үндсэн хуульдаа тангараг өргөхөөд та ер нь юу яриад байна аа? Энэ парламентын Их Хурлын гишүүд чинь Үндсэн хуульдаа тангараг өргөөд Их Хурлын гишүүн болж байгаа шүү дээ. Тэгээд би парламентаа хамгаалсан гэж юм яриад байх юм. Үгүй тэгж та болохгүй шүү дээ. Та Үндсэн хуульдаа тангараг өргөө биз дээ? Тэгээд энэ чинь Үндсэн хууль чинь зөрчигдчихөөд байна шүү дээ. Тийм биз? Та алдаагаа хүлээ л дээ. Тэгээд тухайн үед би хэллээ шүү дээ 2024 онд энд Их Хурлын гишүүд байсан олон гишүүд байна. Юу хийж байсан юм? Бүгд Үндсэн хуулиа зөрчсөн байна шүү дээ. Бүгд тангаргаасаа няцсан байна шүү дээ. Тийм биз дээ? Тэгээд өөдөөс инээгээд томроод байх юм юм ярихаар. Үгүй харин ойлгомжтой шүү дээ харин тийм. Үгүй харин энэ байдлаа яах юм бэ гээд би танаас процессын юм асуухаар шал өөр.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Үндсэн хуульд тодорхой хэмжээний өөрчлөлт орохоор орж ирж байна. Тэгээд одоо үүгээр чуулганаар хэдүүлээ засаж залруулж байна? Хүрэлбаатарын Булгантуяа.

**Х.Булгантуяа:** Энэ их чухал асуудал хөндөж байгаа. Улсын Их Хурал Улсын Их Хурлынхаа дэгийн тухай хууль дээр Үндсэн хуулийг зөрчсөн зүйл, заалтыг 2020, 2024 оны дэгийн тухай хууль дээр хоёулан дээр нь ижил төстэйгөөр зөрчилтэйгөөр тусгасан байна гэж Цэцийн дүгнэлтэд тусгасан байна лээ бичсэн байна лээ. Тэгэхээр Улсын Их Хурал өөрөө өөрийнхөө дэгийг ч Үндсэн хуульдаа нийцүүлж хийж чадаагүй байна л гэсэн үг байхгүй юу. Очирбат гишүүний яриад байгаа тэр бүхэл бүтэн та хэд ингээд зөв олуулаа суугаад 2 удаа дэгээ батлахдаа 2 удаа Үндсэн хуулийн зөрчилтэй улаан цагаан Үндсэн хууль дээр цаг нартай хэн ч ойлгохоор юмыг бичсэн байхад үүнийгээ ойлгоод зөв тусгачихгүй дээ гэж. Тэгээд үүн дээр тухайн үед ажлын хэсгийн ахлагчаар би үүнийг хар шүүлгэж харсан юм. Ажлын хэсгийн ахлагчаар манай Бямбацогт сайд ажлын хэсгийн ахлагчаар ажилласан байна лээ. Дэгийн тухай хуулийн ажлын хэсгийн ахлагчаар.

Сая Үндсэн хуулийн цэц дээр Үндсэн хуулиа хамгийн сайн мэддэг хүн гэж очиж эсрэг талаас очиж маргасан. Ийм ойлгомжтой юмыг Үндсэн хуультайгаа нийцүүлээд тэгээд Дэгийн тухай хууль дээрээ тусгаж чадаагүй байж байж өнөөдөр Улсын Их Хурал гээд ийм нөхцөл байдалд өнөөдөр хүргэсэн нь үнэн шүү дээ. Тэгээд Үндсэн хуулийн цэцээс өнөөдөр та нар Дэгийн тухай хууль дээрээ маш тодорхой заасан юмыг хуульдаа нийцүүл ээ гэдэг дүгнэлтийг өнөөдөр бүгдээрээ

хүлээж авах гээд хэлэлцээд сууж байгаа нь үнэн. Тухайн үед тэр Улсын Их Хурлын Тамгын газрын даргаар Өлзийсайхан дарга та өөрөө ажиллаж байсан. 24 оныхыг батлахад 19 онд энэ 20 он оны дэгийн тухай хуулийг өөрчлөхөд та Улсын Их Хурлын Тамгын газрын даргаар байсан. Тэгэхэд 19 он энэ Дэгийн тухай хууль дээр, Цэцийн дүгнэлт дээр 20 он, 24 оны дэгийн тухай хууль дээр хоёулан дээр нь ижил зөрчилтэй байна гэж гарсан байна лээ, бичсэн байна. Тэгэхээр өөрөөр хэлбэл бид нар Дэгийн тухай хуулиа ч Үндсэн хуулийн зөрчилгүйгээр хийж чадаагүй байна. Хийж чадаагүй байна. Тэгээд энэ бүгдийгээ бид нар засах нь зөв зүйтэй шүү дээ. Хэрвээ ийм зөрчилтэй байх юм бол Улсын Их Хурал удаа дараа Үндсэн хууль зөрчсөн шийдвэрүүд ингээд дэгээсээ авхуулаад ер нь алдаа гаргах магадлал маш өндөр байна гэсэн ийм дүгнэлтийг л Үндсэн хуулийн цэцээс өгсөн байна шүү дээ.

Энэ удаагийн ялангуяа Үндсэн хуулийн дүгнэлтээс бас хараад энэ Дэгийн тухай хуулиа ер нь улам сайн сайжруулах, ялангуяа Үндсэн хууль дээр нарийн цаг нартай заасан, нарийн зохицуулалттай заасан асуудлуудыг миний бодлоор магадгүй эндээс бүүр ажлын хэсэг гаргаад ажиллах нь зүйтэй байх. Дараа дараагийн Байнгын хорооны хурал даргалагч нарыг, дараа дараагийн хуралдаан даргалагч нарыг Үндсэн хуулийн хувьд ямар нэгэн асуудал болгохгүйн тулд бид нар ингээд зөрчилтэй хуулиар өөрөөр хэлбэл 6 жил, Үндсэн хуулийн хувьд зөрчилтэй хуулиар 6 жил манай Улсын Их Хурал Дэгийнхээ хуулийг хийгээд ингээд явчихсан ийм л харамсалтай нөхцөл байдлыг л сайн өнөөдөр гаргаж ирж тавьсан байна. Тэгээд өмнөх дүгнэлтүүдийг нь ч гэсэн харж байгаад Дэгийн тухай хуулиа сайжруулах ажлын хэсэг гаргаж ажиллах нь зүйтэй байх гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэцийн дүгнэлт орж ирж байгаа. Цэц яах ёстой юм бэ гишүүд бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Улсын Их Хурлаас гарсан хууль хэрвээ Үндсэн хууль зөрчсөн бол Цэц дүгнэлт гаргана. Энэ дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээж авах эсэхээ өөрсдөө мэднэ. Хэрвээ хүлээж авахгүй бол Цэц өөрсдөө шийдээд явчихна. Хүлээж аваад үнэхээр алдаагаа засах хэрэгтэй юм байна гээд хүлээж авахаар чуулганаараа хуралдаад л хүлээж авна. Түүнээс биш Улсын Их Хурал алдаатай Үндсэн хууль зөрчсөн санал, хууль баталлаа гэдгээр Улсын Их Хуралд ял юм уу, хариуцлага үүрүүлж байсан ийм санкц ийм зүйл байхгүй шүү дээ. Энэ бидний энэ танхимд өөрсдөө л бид нар шийдээд явна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлтээр санал хураалт явуулна. Гэхдээ дараагийн Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж байгаад нэг мөр санал хураачих уу гишүүд? Тэгье тэгвэл санал хураалтаа хойшлуулаад явчихъя. Ингээд 2 дахь асуудал руугаа оръё.

14.38 цаг

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт**  
/Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Ингээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцье.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Рагчаагийн Батрагчаа танилцуулна. Батрагчаа таныг индэрт урьж байна.

**Р.Батрагчаа:** Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг танилцуулж байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалагч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Ц.Цолмон, Р.Батрагчаа илтгэгч нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийлээ.

Үндсэн хуулийн дунд суудлын хуралдаанд хүсэлт гаргагч Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин оролцсон.

Энэхүү хуралдаанаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэг дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцлээ.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийн 11 хуудас бүхий үндэслэл хэсгийг товчилж тогтоох эсэхийг нь та бүхэнд уншиж сонсгоё.

Үндэслэл

1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ гэсэн заалтын агуулгыг хэт өргөжүүлж Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэц өөрийн санаачилгаар хянан шийдвэрлэнэ гэсэн нь иргэн өөрийн үндсэн эрх буюу Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн

тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргахаар, мөн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргах агуулгыг илэрхийлжээ.

Харин иргэдийн гаргасан өргөдөл, мэдээллийн дагуу Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргаан үүсэх эсэхийг Үндсэн хуулийн цэц зөвхөн өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ.

Түүнчлэн Үндсэн хуулийн зөрчсөн тухай маргааныг Улсын Их Хурал Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ гэсэн нь дээрх эрх бүхий байгууллага, албан тушаалтан Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасан тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа шууд үүсгэн хянан шийдвэрлэхээс өөрөөр бусад байгууллага албан тушаалтан Үндсэн хуулийн цэцэд хандах эрхийг багтаагаагүй болохыг Үндсэн хуулийн бичвэрийн үгийн шууд утгаар ойлгохоор байна.

Гэтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэх, хүсэлт гаргах эрх бүхий субъект, эдгээр субъектээс гадна төрийн бусад байгууллага, албан тушаалтан, олон нийтийн байгууллага аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор гомдол гаргахыг зөвшөөрч нэмсэн нь Үндсэн хуулийн цэцэд хандах субъектийг хэт өргөжүүлсэн байна. Маргаан бүхий зохицуулалт нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг мөн өргөтгөсөн байна.

Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэц зөвхөн Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх учиртай. Гэтэл Үндсэн хуулийн цэц аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоохоор заасан нь зөвхөн Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар бус бусад хуулиар тодорхойлсон хэргийн харьяаллыг шийдвэрлэх өргөн агуулгатай байна.

Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт иргэний хэргийн харьяаллыг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт захиргааны хэргийн харьяаллыг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт эрүүгийн хэргийн харьяаллыг тус тус хуульчилж холбогдох шүүх нь шийдвэрлэхээр тогтоосон байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох асуудлыг нарийвчлан зохицуулаагүй нь Монгол Улсын Дээд шүүхийн энэ талаарх бүрэн эрхтэй давхцал үүсэхээр байна. Тодруулбал, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд тус зүйлийн 25.7.4 дэх заалтад хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт Улсын дээд шүүхийн танхим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журамд нийцүүлэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд тус зүйлийн 28.1.1 дэх заалтад хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллыг тогтоох гэж тус тус заасан байна.

Үүнээс үзвэл аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох болон хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох зохицуулалт ямар ялгаатай болох нь тодорхойгүй байна. Улсын дээд шүүх хуулиар харьяаллыг нь тогтоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох хүрээнд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох боломжтой байх бөгөөд энэхүү харьяалал тогтоогоогүй нь иргэний үндсэн эрхийг зөрчсөн тухай өргөдөл ирүүлснээс бусад тохиолдолд Үндсэн хуулийн цэц уг асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхгүй.

Улсын дээд шүүх 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд хэргийн харьяалал тогтоох асуудлаар 20 иргэнээс өргөдөл, хүсэлт ирүүлснээс 7 хэргийн харьяаллыг тогтоож шийдвэрлэсэн байна. Тухайлбал, нэр бүхий иргэнээс Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст холбогдуулан гаргасан эцэг тогтоох бүртгэлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай хэргийн харьяалал тогтоолгох хүсэлт гаргасны дагуу 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн Захиргааны танхимын нийт шүүгчийн хуралдааны 156 дугаар тогтоолоор Захиргааны хэргийн шүүхийн харьяалал нь шийдвэрлэх маргаан болохыг тогтоож шийдвэрлэсэн байна.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд холбогдох шүүхэд шилжүүлнэ гэж заасан нь Үндсэн хуулийн цэцээс шүүхтэй харилцах харилцааг хэт өргөжүүлсэн байх тул Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна.

Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын Дээд шүүх шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд тус хэсгийн 3 дахь заалтад хууль түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц Улсын Ерөнхий прокурор шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх гэж Үндсэн хуулийн цэцээс үндсэн эрхийг хамгаалах талаарх асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлэн хянан шийдвэрлүүлэхийг Үндсэн хуулиар зөвшөөрсөн байна.

Харин Улсын дээд шүүхээс бусад шүүх буюу анхан болон давж заалдах шатын шүүхэд үндсэн эрхийг хамгаалах талаарх асуудлыг шууд шилжүүлэн шийдвэрлэх бүрэн эрхийг Үндсэн хуулийн цэцэд олгоогүй байхад маргаан бүхий зохицуулалт бусад шүүхэд шилжүүлж болохоор хуульчилсан нь Үндсэн хуульд нийцэхгүй байна.

Эрх зүйн маргааныг аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаагаас иргэний Үндсэн хуулиар хамгаалсан үндсэн эрх зөрчигдсэн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж шаардлагатай тохиолдолд тухайн маргааны хэргийн харьяаллыг тогтоохоор байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн маргаан аль ч шүүхийн харьяалалтай нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль болон бусад хуульд заасны дагуу Дээд шүүхийн бүрэн эрхэд хамаарах уг маргааныг аль ч шүүх авч хэлэлцээгүйн улмаас иргэний үндсэн эрх зөрчигдсэн тухай өргөдлийг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.

Ингэхдээ иргэний өргөдлийн дагуу үндсэн эрхийн маргаан хянан шийдвэрлэх замаар буюу эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн иргэн холбогдох

шүүхэд, дараа нь Улсын дээд шүүхэд хандах зэргээр хуульд заасан бүхий л арга замыг дуусгасны дараа эрх зүйн маргааныг аль ч шүүх авч хэлэлцээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх учиртай.

Энэ нь хэргийн харьяаллыг тогтоох Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг үгүйсгээгүй. Харин шүүх мэдлийн байгууллагын шийдвэрийн улмаас иргэний үндсэн эрх зөрчигдөхгүй байх, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх замаар Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтын шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх болон бусад эрхийн баталгааг хангах хяналтыг хэрэгжүүлж байгаа юм.

Улсын Дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт Үндсэн хуулийн цэц эрх зүйн маргааныг аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаагаас иргэний Үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэх нь Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний хамгаалал ба иргэн, хуулийн этгээдийн шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгааг хадгалж байна гэжээ.

Иймд Үндсэн хуулийн цэцээс иргэний өргөдлийг дунд суудлын хуралдаанаараа хянан шийдвэрлэж эрх зүйн маргааныг аль ч шүүх авч хэлэлцээгүй нь үндсэн эрхийг зөрчсөн гэж үзвэл Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын дагуу Улсын дээд шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлэхээр байна.

Үндсэн хуулийн цэцээс үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэхдээ холбогдох шүүхийн шийдвэрийг хүчингүй болгохгүй харин Үндсэн эрхийг хамгаалах асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлж хянан шийдвэрлүүлж байгаа учраас энэ нь Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ гэж заасантай харшлахгүй.

Үндсэн хуулийн цэц нь шүүх хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг хянахгүй бөгөөд шүүхийн мэргэжлийн алдааг засах шат дамжлага биш юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиас бусад хуулийн заалтыг тайлбарлах, хэрэглэх, хэргийн үйл баримтыг тогтоох, үнэлэх асуудлыг харьяалах шүүх нь шийдвэрлэнэ. Харин Үндсэн хуулийн цэц шүүхийн хэрэглэсэн ердийн хуулийг бус гагцхүү Үндсэн хуулийг хэмжүүр болгоно.

Иймд Үндсэн хуулийн суурь суурь үзэл баримтлал Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, тус зүйлийн 2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн зохицуулалтыг холбож холбож цогцоор нь авч үзвэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах,

Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд хуульд бүрээ нийцсэн байвал зохино гэж заасантай нийцээгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийн удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргийг гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна. Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасанд нийцээгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийцсэн байна.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд улам уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Ц.Цолмон, Р.Батрагчаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Тэмүүжин гишүүнийг урьж байна.

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 01 дүгээр дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд

заасан журмын дагуу 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцээгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, хууль, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоох, холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, түүний гишүүний үүргийг гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна гэж заасныг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллага, бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн зохино гэсэн заасантай тус тус нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.2 дахь заалтын дагуу Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувиар хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Ариунзаяа гишүүнийг индэрт урьж байна.

**А.Ариунзаяа:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг 26 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх товч танилцуулгыг танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үр дагаврын талаар асуулт асууж, хариулт авсан.

Хүсэлт гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин Үндсэн хуулийн цэцээс шүүх уг асуудалтай холбогдох иргэний гомдлыг хүлээн авч иргэнд шүүхээр шийдвэрлэх маргаан биш болох талаар үндэслэл бүхий хариулт өгөх нь зүйтэй байсан гэж үзсэн талаар болон Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсантай холбогдуулан Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хүчингүй болгох, Улсын дээд шүүх холбогдох маргааны харьяаллыг тогтоох эрх олгосонтой холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, Үндсэн хуулийн цэцэд иргэдийн үндсэн эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэх хууль тогтоомжийг баталж боловсронгуй болгох чиглэлээр Улсын Их Хурлаас санаачилга гаргаж ажиллах шаардлагатай байгаа талаар танилцуулсан болно.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна. Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасанд нийцээгүй байна гэснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү?

Булгантуяа гишүүнээр тасаллаа. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй санал нэг байна. Тэгээд Тэмүүжин гишүүнээс нэг зүйлийг асуух гэсэн юм. Улсын Их Хурлын тогтоол, шийдвэр, Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол, шийдвэр хууль баталж гаргасан хуулийг Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу, Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу дунд суудлаараа хэлэлцээд Улсын Их Хуралд ирүүлдэг. Гэтэл 8 дугаар дүгнэлтийг их суудлаараа авч хэлэлцсэн. Хуульч хүний хувьд ер нь үүнийг та юу гэж дүгнэж харж байна вэ? Цаашид ийм Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлт нь илт Үндсэн хууль зөрчсөн юм шиг ийм нөхцөл байдал үүсгэсэн байна гэж олон хуульчид ярьсан. Тухайн үед даргын дэргэдэх Зөвлөл дээр үүнтэй холбоотойгоор нэлээдгүй маргаан үүсэж байсан. Та өөрөө АН-ын бүлгийн дэд даргын хувьд тус хуралд ирж оролцож байсан. Миний ойлгосноор дараа нь Бат-Эрдэнэ дарга Улсын Их Хурлын дэд дарга бас даргын дэргэдэх

Зөвлөлийг хуралдуулаад үүнтэй холбоотой асуудлыг Үндсэн хуулийн цэцэд хүргүүлье гэсэн байсан. Энэ Улсын Их Хурал гаргасан тогтоолыг их суудлаараа авч хэлэлцсэн нь Үндсэн хуулийн зөрчилтэй байна. Дунд суудлаараа авч хэлэлцэх ёстой байсан. Үүнийг Улсын Их Хурал дунд суудлаараа авч хэлэлцсэн шийдвэрээ, дүгнэлтээ танилцуулдаг гэдэг. Энийг ер нь ингээд цаашид яах ёстой юм бэ? Та хуульч хүний хувьд үүн дээр ямар санал, дүгнэлттэй байна вэ? Энэ бол өмнө нь Улсын Их Хурлын гаргасан албан тушаалтныг чөлөөлсөн Улсын Их Хурлын тогтоолтой холбоотой асуудлыг энэ дүгнэлт дээр авч хэлэлцсэн байна. Тэгэхээр Тэмүүжин гишүүнээс үүнийг тодруулж асуух гэсэн юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Булгантуяа гишүүний асуулт яг энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа Үндсэн хуулийн дүгнэлттэй холбоогүй асуулт байна. Монгол Улсын Үндсэн хууль дээр маш тодорхой заалтууд байгаа. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дээр ямар үг байгаа вэ гэхээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна гэж үг байгаа. Тэгэхлээр Үндсэн хуулийн цэц гаргасан дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулах үүргийг Үндсэн хуулиар олгосон байгаа. Яг тухайн л Булгантуяа гишүүний дурдаж байгаа Улсын Их Хурлын шийдвэртэй холбогдуулан гаргасан Үндсэн хуулийн дүгнэлт одоо хүртэл Улсын Их Хуралд орж ирээгүй байгаа. Үндсэн хуульд Үндсэн хуулийн цэц бага суудал, дунд суудал, их суудлаараа хуралдах тухай ямар ч заалт байхгүй. Энэ ердийн хуулиар зохицуулсан зохицуулалт.

Үндсэн хуульд юу заасан байгаа вэ гэхлээр Үндсэн хуулийн цэц дараах маргаантай асуудлаар гээд 4 зүйлээр дүгнэлт гаргах тухай заалт байгаа. Тэр дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулах тухай заалт байгаа. Үндсэн хуулийн заалт дотор бас ямар үг байгаа вэ гэхээр Улсын Их Хурал оруулсан дүгнэлтээр зөвшөөрөх, эс зөвшөөрөх тухай тухай асуудлаар шийдвэр гаргах тухай заалт байгаа. Тийм учраас Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд дүгнэлтээ оруулж ирээгүйтэйгээ холбоотойгоор Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжихгүй байгаа тохиолдол энэ тохиолдолд гарсан. Ийм учраас бид Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжийг Үндсэн хуулийн нэр томъёо, агуулга, зарчимд нийцүүлж, дахин боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа. Тухайлбал, өнөөдрийн энэ дүгнэлттэй холбоотой ч гэсэн бас Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ энэ дээр гарч байгаа. Үндсэн хуулийн цэцийн хуралдаан дээр ч бас энэ дурдагдсан. Энэ дүгнэлтэд ч гэсэн дурдагдсан байгаа. Өнөөдөр бодит байдал дээр Үндсэн хуулийн цэц буюу Үндсэн хуулийн шүүх иргэний Үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэдэг болсон. Бодит байдал дээр. Энэ Үндсэн хуулийн үг, үсэг, текстээс ч бас гарч ирж байгаа.

Тийм учраас ердийн хууль тогтоомжоор энэ эрхийг нь баталгаажуулж процессыг нь тодорхойлж өгөхгүй бол тэнд ердийн хуулийн зохицуулалтгүйгээр Үндсэн хуулийнхаа агуулгаар ингээд цаашаа Үндсэн хуулийн шүүх бол иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлээд яваад байх нь.

Хууль тогтоогчид ажлаа хийхгүй бол Үндсэн хуулийн шүүх иргэний үндсэн эрхтэй холбоотой маргааныг цаашид ч гэсэн шийдвэрлээд яваад байна. Тэгэхлээр 1 зарчим байгаа. Монгол Улсын парламент бол Үндсэн хуулиараа хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү өөртөө хадгалж байгаа.

Тийм учраас Үндсэн хуулийн шүүх өөрийнхөө үйл ажиллагаанд хууль тогтоох эрх байхгүй. Бид ийм зөрчлийг арилгах зорилгоор нэн даруй энэ.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэмүүжин гишүүд 1 минут.

**Х.Тэмүүжин:** Энэ хаврын чуулганаар Үндсэн хуулийн цэцийн процессын хууль болон Цэцийн өөрийнх нь бүрэн эрхтэй байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгоод дан улс төрийн асуудалд хэрүүл болж орж ирэхээс гадна үндсэн эрхийн асуудлаар иргэнийхээ тал дээр шийдвэр гаргадаг тэр Үндсэн хуулийн шүүхийн зарчим руу нь оруулах чиглэлээр хууль тогтоомжийг нь гаргаж өгөх ёстой. Энэ дүгнэлт дотор ч гэсэн дурдагдсан байгаа.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцийн иргэний Үндсэн эрхийг хянахтай холбоотой, эрх мэдэлтэй холбоотой Үндсэн хуулийн заалтыг энэ зөрчөөгүй байна. Харин зөвхөн Үндсэн хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлж Үндсэн хуульд дагаж мөрдөх ёстой, Үндсэн хуулийг дээдлэх ёстой гэдэг энэ зарчимтай нь зөрчилдөж байна. Яагаад гэвэл ердийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх эрхийг Үндсэн хуулийн цэцэд олгоогүй. Гэтэл ердийн эрх зүйн маргаан шийдвэрлэх маягийн чиг үүрэг олгочихсон байгаа нь Үндсэн хуульд үнэнч байх, Үндсэн хуультай холбоотой маргааныг шийдвэрлэх гэдэг.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтүүдтэй холбоотой санал хураалт явуулна. Гишүүдийг чуулганы танхимд урьж байна. Санал хураалт явуулчхаад нэг асуулт байгаа. Эдийн засгийн байнгын хороо, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо хуралдаж байна уу тээ? Их засаг, Үндсэн хууль танхимуудад. Бүлгийн дарга нар гишүүдээ ямар ч байсан танхимдаа урья.

Санал хураалтыг чуулганы хуралдааны төгсгөл дээр явуулъя. Хэлэлцэх асуудалдаа дараагийн хэлэлцэх асуудалдаа орёё.

15.03 цаг

**Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан.**

Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 25 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал Ерөнхий сайдыг индэрт урьж байна.

**Н.Учрал:** Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц

болон Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт шинжилгээний дүнг танилцуулж байна.

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 16 үр дүнгийн шалгуур үзүүлэлт, үндсэн 4 бодлогын хүрээнд 620 зорилттой батлагдсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь 1396 арга хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн 267 хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлттэй батлагдсан.

Үүнээс мэдээллийн эх сурвалж гарах хугацаа болоогүй хөтөлбөрийн 3 үр дүнгийн шалгуур үзүүлэлт буюу ядуурлын түвшин, бизнесийн орчны ерөнхий үнэлгээ, ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын үнэлгээнээс бусад 13 үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэх 575 зорилт, 1213 арга хэмжээ болон төсвийн ерөнхийлөн захирагчийн 67 үр дүнгийн 76 шалгуур үзүүлэлтээр зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тухайн жилийн болон хөтөлбөр хэрэгжих хугацааны өссөн дүнтэй харьцуулж Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолд заасан хяналт шинжилгээ хийх аргачлалын дагуу хийж боловсрууллаа.

Хяналт шинжилгээний дүнгээр тус хөтөлбөрийн хавсралтаар баталсан бодлогын 13 үр дүнгийн хэрэгжилтийн явцыг 2025 оны зорилтот түвшинтэй харьцуулахад дундаж үзүүлэлт 55.5 хувь, өссөн дүнгээр буюу 2028 оны зорилтот түвшинтэй харьцуулахад 30.7 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн 67 үр дүнгийн хэрэгжилтийн дундаж 64.1 хувь, өссөн дүнгээр 46.4 хувь, үйл ажиллагааны төлөвлөгөөний 575 зорилтын хэрэгжилтийн дундаж нь 66.4 хувь, өссөн дүнгээр 38 хувь, 1213 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 67.9 хувь, өссөн дүнгээр 38.8 хувь байна.

Хуульд заасан хугацаанд буюу 2026 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хурлын Тамгын газар Үндэсний аудитын газарт тайланг хүргүүлсэн өдрөөс хойш бодлогын зарим үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг хэмжих эх сурвалжид өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Үндэсний статистикийн хорооноос 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдөр гаргасан мэдээллээр эдийн засгийн өсөлтийг 2025 оны 12 дугаар сарын байдлаар 6.8 хувь гэж, 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдөр гаргасан мэдээллээр 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 8.6 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

Эдийн засгийн өсөлтөд уул уурхай олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 33.2 хувь, үйлчилгээний салбарынх 4.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн гэж дүгнэж үзэхээр байна.

Инфляцын түвшин 2025 оны 12 дугаар сарын байдлаар 7.5 хувь гэж, 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр гаргасан мэдээллээр 2026 оны 2 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.5 хувь гарсан нь 1 нэгж хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Харин олон улсын “Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 180 орноос 2025 оны 2 дугаар сарын 10-нд гаргасан үзүүлэлтээр 33 оноогоор 114 дүгээр байранд жагсаж байсан бол 2026 оны 2 дугаар сарын 10-нд гаргасан үзүүлэлтээр 31 оноогоор 124-д эрэмбэлэгдсэн

нь 2025 онд гарсан үзүүлэлтээс 10 байр ухарч, 2 оноогоор буурсан үзүүлэлттэй байна.

2.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг зорилтот түвшинтэй харьцуулж, журамд заасан хэрэгжиж дууссан бодлогыг дүгнэх арга зүйг ашиглан хяналт шинжилгээ хийлээ. Хяналт шинжилгээний дүнгээр Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 4 тэргүүлэх чиглэлийн 6 үр дүнгийн дундаж 48.5 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн 29 үр дүнгийн дундаж 59.7 хувь, хөтөлбөрийн 63 үр дүнгийн дундаж 57.1 хувь, нийт 326 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж 61 хувь байна. Өмнөх оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд тэргүүлэх чиглэлийн үр дүн 0.2 нэгж хувиар, хөтөлбөрийн үр дүн 0.14 нэгж хувиар, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 3.8 нэгж хувиар тус тус өссөн эерэг үзүүлэлттэй байгаа бол төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 9.7 нэгж хувиар буурсан нь 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж төсөвт тодотгол хийж хэмнэлт тооцсонтой холбоотой байна гэж дүгнэж байна.

Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө нь агуулгын хувьд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй 24.3 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй 13 хувь тус тус уялдсан байна.

Монгол Улсын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийт 326 төсөл, арга хэмжээ тусгагдсан бөгөөд 39 төсөл, арга хэмжээний эх үүсвэр, санхүүжилтийн дүн тодорхойгүй, 287 төсөл, арга хэмжээг 19.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн ч санхүүжилтийн гүйцэтгэлийн дүнг авч үзвэл 180 төсөл, арга хэмжээнд 9.2 их наяд төгрөг зарцуулахаас 5.4 их наяд төгрөгийг зарцуулж, 107 төсөл, арга хэмжээнд төсөв огт зарцуулаагүй байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт нь 60.1 хувьтай үнэлэгдэх үндсэн шалтгаан болж байна.

Мөн хяналт шинжилгээний дүнгээр 85-аас дээш хувь буюу үр дүнтэй үнэлэгдсэн 161 төсөл, арга хэмжээ, 85-аас доош хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн 165 төсөл, арга хэмжээ байна. Дээрх 165 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 85-аас доош хувьтай байгаа шалтгааныг судлан үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийг хэмнэлтэд тооцож буцаан татсан, удирдлага, зохион байгуулалт нь сул, урьдчилсан шатын бэлтгэл ажлууд буюу судалгаа шинжилгээ хийх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, тендер шалгаруулалт, гэрээ хэлэлцээр хийх ажлууд удаашралтай зэрэг шалтгаанаас шалтгаалсан байна хэмээн дүгнэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.4-д заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Майсүрэн танилцуулна. Майсүрэн аудиторыг урьж байна. Магнайсүрэн шүү уучлаарай. Сандагийн Магнайсүрэн.

**С.Магнайсүрэн:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан сэдвийн хүрээнд Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хуулийн хугацаанд аудитыг хийж гүйцэтгэн Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод хүргүүлж хэлэлцүүлсэн бөгөөд энэ талаараа хураангуйлан танилцуулж байна.

Улсын Их Хурлын 2025 оны 35 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны 29 үр дүнгийн 47 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн 63 үр дүнгийн 91 шалгуур үзүүлэлт, нийт 328 төсөл, арга хэмжээний 373 шалгуур үзүүлэлтийн хүрээнд улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр 19 их наяд 359.1 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тэргүүлэх чиглэл хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны үр дүн, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журамд заасан аргачлалын дагуу үнэлж үзэхэд бодлогын 4 тэргүүлэх чиглэлийн 6 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 20.9 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны 29-ийн үр дүнгийн 47 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 63.7 хувь, хэрэгжүүлэх хөтөлбөрийн 63 үр дүнгийн 91 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 62 хувь, төлөвлөсөн нийт 328 төсөл, арга хэмжээний 373 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 58.1 хувьтай байна.

Улсын хөгжлийн төлөвлөгөөнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шалгуур үзүүлэлтийг тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих, салбар хооронд нэгтгэн удирдах шаардлагыг заасан боловч шалгуур үзүүлэлт оновчгүй, хэмжих нэгж уялдаагүй, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус, алдаатай тодорхойлсон зэрэг төлөвлөлтийн алдаа зөрчлүүд давтагдсаар байна.

Эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 209 үр дүнгийн 248 шалгуур үзүүлэлтээр 83 төсөл, арга хэмжээнд үр дүн гарсан. 160 төсөл, арга хэмжээ нь үр дүнгүй, 5 төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт үнэлэх боломжгүй гэж үнэлэгдсэн бөгөөд 2025 онд эдийн засгийн өсөлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 62 үр дүнг 67 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоогүйгээс үнэлэх боломжгүй, хотын хөгжлийн индекс нь зорилтот түвшинд хүрээгүй тул 43.4 хувиар үнэлэгдсэн байна.

Хүний хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд 81 үр дүнгийн 112 шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд хариуцагч байгууллагын зохион байгуулалттай холбоотой батлагдсан аргачлал, индекс байхгүй, мэдээллийг тархаах хугацаа болоогүй зэрэг шалтгаанаас төсөл, арга хэмжээ үр дүнгүй гэж үнэлэгдсэн байна.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд 72 үр дүнгийн 84 шалгуур үзүүлэлтийг үнэлсэн бөгөөд авлигын индекс, шалгуур

үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй, Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн статистик тоон үзүүлэлт гарах хугацаа болоогүй тул үнэлэх боломжгүй гэж тайлагнагдсан байна.

Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтот түвшний 85 хувиас дээш үр дүн гарсан, 85 хувь хүрээгүй бол үр дүнгүй гэж үнэлсэн дүгнэлтийн тухайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны үр дүнгийн 48.9 хувь нь үр дүн гарсан бөгөөд 40.4 хувь нь үр дүнгүй, 10.6 хувь нь үнэлэх боломжгүй гэж үзсэн. Хэрэгжүүлэх хөтөлбөрийн 40.6 хувь нь үр дүн гарсан бол 52.7 хувь нь үр дүнгүй, 6.5 хувь нь үнэлэх боломжгүй, батлагдсан төсөл, арга хэмжээний 42.6 хувь нь үр дүн гарсан, 56.5 хувь нь үр дүнгүй гэж үнэлэгдлээ.

Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний санхүүжилтийн тухайд нийт төсвийн 7 их наяд 336.4 тэрбум төгрөг буюу 37.9 хувийн санхүүжилт хийгдсэн байх бөгөөд үүний 19.8 хувь буюу 1 их наяд 449.3 тэрбум төгрөгийг улсын болон орон нутгийн төсөв, 19.5 хувь буюу 1 их наяд 429.6 тэрбум төгрөгийг гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр, 21.9 хувь буюу 1 их наяд 605.5 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр, 38.9 хувь буюу 2 их наяд 852 тэрбум төгрөгийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэр байхаар тооцоолсон байна. Тооцоолж тусгасан.

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгэх төсөл, арга хэмжээний 4 их наяд 463.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа дүгнэлт хийж, хөгжлийн төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэхээр арга хэмжээг тусгахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу судалгаа, шинжилгээнд суурилан урьдчилсан үнэлгээ хийж төлөвлөх шаардлагатай байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Эдийн засаг, хөгжлийн сайдад хөгжлийн төлөвлөгөөг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулах чиглэлээр 2 зөвлөмж, Сангийн сайдад улсын төсвийг хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэх талаар 1 зөвлөмж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагналыг сайжруулах чиглэлээр 3 зөвлөмж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх чиглэлээр 1 зөвлөмж, нийт 7 зөвлөмжийг хүргүүлээд байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, тайланг бэлтгэн харилцагч талуудад толилуулсан бөгөөд та бүхэнд аудитын дүнг хураангуйлан үүгээр танилцууллаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Магнайсүрэн аудиторт баярлалаа.

Гишүүд танхимдаа цуглаарай. Бидний баталж, Засгийн газарт баталж өгсөн 2024-2028 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг, 25 оны биелэлтийг хэдүүлээ хэлэлцэж байгаа шүү.

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Ариунзаяа таныг индэрт урьж байна.

**А.Ариунзаяа:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлд заасны дагуу Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийж ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн.

1.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангийн талаар

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд бодлогын тэргүүлэх 20 чиглэлийг 6 шалгуур үзүүлэлтээр, төсвийн ерөнхийлөн захирагчийн 29 үр дүнг 47 шалгуур үзүүлэлтээр, хөтөлбөрийн 63 үр дүнг 91 шалгуур үзүүлэлтээр, 328 төсөл, арга хэмжээг 375 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас тэргүүлэх чиглэлийн үр дүнг 48.5 хувь, төсвийн ерөнхийлөгч захирагчийн үр дүнг 59.7 хувь, хөтөлбөрийн үр дүнг 57.1 хувь, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг 61.0 хувьтай хэрэгжсэн гэж, Үндэсний аудитын газраас тэргүүлэх чиглэлийн үр дүнг 20.9 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг 63.7 хувь, хөтөлбөрийн үр дүнг 62 хувь, төсөл, арга хэмжээний үр дүнг 58.1 хувьтай хэрэгжсэн гэж тус тус үнэлсэн байна.

Харин Улсын Их Хурлын Тамгын газраас хийсэн дүн шинжилгээнд эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийн гүйцэтгэлийг 40 хувь гэж үнэлсэн бөгөөд хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын тэргүүлэх чиглэлийн үр дүнг бүрэн тодорхойлох боломжгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн болон хөтөлбөрийн үр дүнг Засгийн газраас үнэлсэн үнэлгээ нь шинжилгээгээр зөрүүтэй талаар дурджээ.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас төлөвлөгөөнд тусгагдсан нийт 328 төсөл, арга хэмжээнээс агуулгын хувьд давхардаж байгаа 2 арга хэмжээг хасаж, хяналт шинжилгээ, үнэлгээнд хамруулсан нийт 326 төсөл, арга хэмжээний 49.1 хувь буюу 161 төсөл, арга хэмжээ 85 ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй, 165 төсөл, арга хэмжээний буюу 50.3 хувь нь 85-аас доош хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд заасан бодлого тус бүрийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас дараах байдлаар үнэлжээ. Үүнд:

1.Эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 12 үр дүнгийн гүйцэтгэл дунджаар 47 хувьтай, хөтөлбөрийн 30 үр дүнгийн гүйцэтгэл дундаж 57.3 хувийн гүйцэтгэлтэй, 167 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 63.6 хувийн гүйцэтгэлтэй.

2.Бүсчилсэн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 3 үр дүнгийн гүйцэтгэл дунджаар 33.3 хувь, хөтөлбөрийн 6 үр дүнгийн гүйцэтгэл дунджаар 35.3 хувь, 51 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 74.3 хувьтай гэж үнэлэгджээ.

3.Хүний хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 8 үр дүнгийн гүйцэтгэл дунджаар 85 хувь, хөтөлбөрийн 15 үр дүнгийн гүйцэтгэл дунджаар 64.1 хувь, 58 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 64.4 хувь гэж үнэлэгджээ.

4.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 6 үр дүнгийн гүйцэтгэл дунджаар 73.3 хувь, хөтөлбөрийн 12 үр дүнгийн гүйцэтгэл дунджаар 58.8 хувь, 50 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 54.5 хувь байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 326 төсөл, арга хэмжээний 50.3 хувь буюу 165 нь 85-аас доош гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байгаа нь төсөл, арга хэмжээг судалгаа тооцоололд тулгуурлан үндэслэлтэй, боловсруулаагүй, шаардлагатай төсөв, санхүүжилт, батлагдаагүй, бэлтгэл, урьдчилсан шатын ажлын явц хангалтгүй, төлөвлөлтийн алдаатай зэргээс шалтгаалж байна.

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан, Засгийн газрын 2024, 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явц, үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийхэд төлөвлөлтийн алдаа, гүйцэтгэлийн тооцох тооцооллын алдаа, үнэлэх арга зүйн хэрэглээний зөрүүтэй байдал болон албан ёсны статистик мэдээлэл гараагүйтэй холбоотойгоор бодлогын үр дүнгийн үнэлгээ зөрүүтэй болсон гэж дүгнэсэн байна.

2.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, “Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор үндсэн 4 бодлогын хүрээнд 620 зорилт, 1396 арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч болон хөтөлбөрийн үр дүнгийн 219 хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй баталсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнг урьдчилан тодорхойлсон бодлогын 16 шалгуур үзүүлэлт, төсвийн ерөнхийлөн захирагчийн 67 үр дүнгийн 76 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 575 зорилт, 1213 арга хэмжээний биелэлтэд тухайн жилийн буюу 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд тус хөтөлбөрийн хавсралтаар баталсан бодлогын 13 үр дүнгийн биелэлт 55.5 хувьтай, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн биелэлт 64.1 хувьтай, үйл ажиллагааны төлөвлөгөөний 575 зорилтын хэрэгжилтийн дундаж 66.4 хувь 1213 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 67.9 хувьтай байна гэж дүгнэсэн.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үндсэн 4 бодлого тус бүрээр авч үзвэл бүсчилсэн хөгжлийн бодлогын 84 зорилтын тухайн жилийн биелэлт 62.1 хувь, хүний хөгжлийн бодлогын 145 зорилтын тухайн жилийн биелэлт 70.6 хувь, эдийн засгийн бодлогын 208 зорилтын тухайн жилийн биелэлт 61 хувь, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын 143 зорилтын тухайн жилийн биелэлт 72.5 хувьтай байна.

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 2025 онд хэрэгжүүлж эхлэх 1234 төсөл, арга хэмжээнээс 13 хувь нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Энэ нь бодлогын баримт бичгийн уялдаа хангалтгүй, бодлогын баримт бичгийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжиж, зорилтот түвшинд хүрсэн боловч тухайн арга хэмжээ хэрэгжсэнээр иргэдийн амьдралын чанар, орлогын бодит өсөлт, үйлчилгээний хүртээмжид хэрхэн нөлөөлсөн талаар иж бүрэн үнэлгээ хийгдэхгүй, бодлогын үр дүн, үр нөлөөг зөвхөн тоон үзүүлэлтээр хэмжиж байгаа нь учир дутагдалтай.

Иймд цаашид бодлогын хэрэгжилтийг зөвхөн гүйцэтгэлийн түвшинд бус нийгэм эдийн засгийн бодит үр нөлөө, иргэдийн амьдралын чанарт үзүүлсэн өөрчлөлтөөр үнэлэх арга зүйг нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батболд Туулын хурдны замд урьдчилсан аудит хийж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Уянга 80 хувиас дээш үнэлэгдсэн яамд болон холбогдох бусад байгууллагуудын тайланд дурдах хангалтгүй үнэлэгдсэн яамд цаашид ямар арга хэмжээ авч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хоорондын уялдааг хэрхэн хангах, 5 дугаар сарын 1, 31 төсөвт татагддаг байдал болон төлөвлөгөө батлах үйл явцыг дахин харах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тайлагнасан 65.1 хувийн биелэлтийг яг ямар үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр тооцсон талаар, мөн бодлогын хэрэгжилт дотроос эдийн засгийн бодлогын хэрэгжилт, үнэлгээ хангалтгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Туваан Эдийн засгийн өсөлт болон хөгжлийн бодлогын зөрүү,

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Үндэсний аудитын газрын үнэлгээний зөрүү, арьс, ширний цогцолборын ажлын гүйцэтгэл, алт цэвэршүүлэх үйлдвэрийн явц, газар тариаланд олгосон зээлийн үр дүн, газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх хэлэлцээрийн явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал яамдын үйл ажиллагааны хэрэгжилт 22-57 хувьтай гарсан нь хангалттай үзүүлэлт эсэх, үүнийг Эдийн засаг, хөгжлийн сайдын хувьд хэрхэн дүгнэж байгаа талаар, Боловсролын зээлийг чөлөөлсөн шийдвэрийг хүчингүй болгох Авлигатай тэмцэх газрын 2 удаагийн чиглэлийн хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй гарахад нөлөөлсөн 3 гол шалтгаан, цаашид зохион байгуулах арга хэмжээ инфляцыг удирдах зорилгоор авах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин хүний хөгжлийн индекс, дундаж наслалт буурсан, нялхсын эндэгдэл өссөн шалтгаан, агаарын бохирдол, түгжрэлийг бууруулах арга хэмжээний үр нөлөө, ДНБ-д эзлэх төрийн оролцооны хувь өссөн шалтгааны талаар, авлигын индекс ухарсан шалтгаан, Соёл, спорт, аялал жуулчлалтай холбоотой зорилт хэрэгжээгүй мөртөө 100 хувь гэж гарч байгаа нь арга хэмжээг бодитой төлөвлөх шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байгаа компаниудад төсвөөс урьдчилгаа 10-30 хувийн санхүүжилтийг олгох хууль, эрх зүйн боломжийг нээх талаар, мөн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар тайлан, аргачлал жил бүр өөрчлөгдөхгүй хэвээр орж ирдэг нь үр дүн муудаж, төсвийн зарцуулалт үр ашиггүй, хариуцлага хүлээх тогтолцоо сул байгаа тул хариуцлагыг тодорхой болгож, бодит шинэчлэл хийх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа жилийн төлөвлөгөө нь улсын төсөвтэй уялддаггүй, батлагдсан төсөл, арга хэмжээний ихэнх нь санхүүжилтгүй байгаа тул гүйцэтгэл муу гарч байгаа бөгөөд төлөвлөлт, төсөв, хууль, эрх зүйн уялдааг сайжруулах, жилийн төлөвлөгөөний тогтолцоог өөрчлөх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хүчингүй болгох, эс үгүй бол өөрчлөн найруулах, Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлагыг мөн тодорхой болгож илүү сайжруулах талаар саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайланг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд уншиж танилцууллаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн 12<sup>б</sup>, 12<sup>в</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа 13 дугаар сургуулийн 12<sup>б</sup>, 12<sup>в</sup> ангийн багш, сурагчдадаа нийт гишүүдийнхээ өмнөөс сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мягмарсүрэнгийн Баярмагнай Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Баасанжавын Болор-Эрдэнэ Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мянгаагийн Баяраа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бавуужавын Мягмарнаран Цахим, хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрдэнэбаатарын Цэнгүүн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төсөл, хөтөлбөр, гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Сүхбаатарын Түвшинжаргал Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэрнаран Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Даваахүүгийн Нарангэрэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга, ахлах зөвлөх, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Баатарчулууны Золбоо Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын албаны даргыг түр орлон гүйцэтгэгч, Үндэсний аудитын газраас Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүн тэргүүлэх аудитор, Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Ганбатын Эрдэнэбат Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга, Батмөнхийн Алтантуяа Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх, Дашдондовын Цэцэгмаа Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын ахлах референт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас

Түмэндалайн Даваадалай Нийслэлийн Засаг даргын орлогч, Баянмөнхийн Мөнхбаяр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээний газрын дарга гэсэн ажлын хэсэг байна.

Ингээд Ерөнхий сайд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүдийн эрхлэх хүрээнд өөрчлөлт орсон. Тийм болохоор Төрийн нарийн бичгийн дарга нар асуултад хариулаад явна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, аудитын тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

15.35 цаг

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн 12<sup>а</sup>, 12<sup>г</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

13 дугаар сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчдадаа нийт гишүүдийнхээ өмнөөс сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Горимын санал Ариунзаяа гишүүн.

**А:Ариунзаяа:** Улсын Их Хурлын дэд дарга, гишүүдэд горимын санал гаргах гэсэн юм. Энэ одоо хэлэлцэж байгаа асуудалд бид нар санал хураахгүй танилцаад явчих юм. Гэтэл энэний өмнөх 2 асуудал нь цаг хугацаатай учраас ирцтэй байгаа дээрээ бас саналаа хураасан нь зүйтэй болов уу гэсэн ийм горимын санал гаргаж байна. Та өмнөх асуудлуудаар Цэцийн дүгнэлт нь өөрөө цаг хугацаатай асуудал учраас өнөөдөртөө багтаж бас саналуудыг нь хураагаад явсан нь зүйтэй байх гэсэн ийм санал гаргаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сая 2 Байнгын хороо хуралдаад дууссан тул Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналыг хүлээж авах уу? Санал хураачих. Санал хураалтад бэлдье.

Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналын дагуу түрүүний хэлсэн Цэцийн дүгнэлттэй холбоотой, 2 дүгнэлттэй холбоотой санал хураалтыг явуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тэгвэл юу яачихъя сая наадах чинь ажиллаагүй юу? Горимын саналаа гаргачих Бум-Очир гишүүн.

**Д.Бум-Очир:** Сая Байнгын хорооны хурал дөнгөж дуусаад санал хураалтад орж чадсангүй. Дөнгөж гүйж орж ирээд амжсангүй уучлаарай. Тэгээд санал хураалтыг дахиж явуулж өгнө үү гэж хүсэж байна. Хүчингүй болгоод.

**Ж.Бат-Эрдэнэ:** Зарим гишүүдийнх бас ажиллаагүй юм байна. Тийм болохоор саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 104 гишүүнээс 51 гишүүн оролцож, 49 хувиар санал дэмжигдсэнгүй.

Гишүүд өөрсдөө анхаарна биз дээ. Энийг нэгэнт болохгүй байгаа тэгээд л болохгүйгээр л явъя. Айн Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Санал хураалтад бэлдээд тэгээд дараад нь яах ёстой төхөөрөмж ажиллахгүй байн. Тийм болохоор горимын санал гаргаж байна. Энэ санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал явуулж өгөөч. Цаг алдахгүй бас юмнуудаа явуулмаар байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Би сая дэгийн алдаа гаргасан уу тээ санал хураалтад бэлдэлгүй шууд. Тэгвэл санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье гэсэн шүү дээ. Болохгүй байна аа. Төхөөрөмж ажиллахгүй байна. Төхөөрөмжөө бэлдээрэй. Санал хураалтад бэлдье.

Энэ төхөөрөмжөө янзлаадхаач. Төхөөрөмж чинь болохгүй байна. Зарим гишүүд санал хураалтад бэлтгэгдээгүй байна гэж байна. Тийм болохоор санал хураалтад бэлтгэе гэдэг командыг дахиад өгч байна. Санал хураалтад бэлтгэе. Саяын хураасан саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 105 гишүүнээс 57 гишүүн оролцож, 54.3 хувиар санал дэмжигдэж санал хураалт хүчингүй боллоо.

Одоо санал хураалтыг Цэцийн дүгнэлтээр санал хураалт явуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэх бил үү? 2 дүгнэлт байгаа. Шууд явчих уу? Тийм одоо горимын саналаар санал хураана шүү дээ. Шууд явах уу? Санал хураалт явуулъя. Санал хураалт.

105 гишүүнээс 60 гишүүн саналаа өгч, 57. хувиар Ариунзаяа гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулъя. Та бүхэнд танилцуулаадахъя эхнээс нь.

### **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлттэй холбоотойгоор Байнгын хорооны санал.**

Байнгын хороодын саналаар санал хураалтыг явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Баараагүй л хийсэн нь дээр шүү.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн

зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалтад 105 гишүүнээс 65 гишүүн дэмжиж, 61.9 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. ..." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 105 гишүүнээс 67 гишүүн оролцож, 63.8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 105 гишүүнээс 67 гишүүн дэмжиж, 63.8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор ... шийдвэрлэнэ." гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 105 гишүүнээс 67 гишүүн дэмжиж, 63.8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хороодын саналаар санал хурааж, эхний асуудлаар санал хурааж дууслаа.

Байнгын хороодын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийн тухай" Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье. Ингээд дараагийн асуудал.

## **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгнэлтийн талаар санал хураалтыг явуулъя.**

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 105 гишүүнээс 65 гишүүн оролцож, 61.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасанд нийцээгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 105 гишүүнээс 65 гишүүн оролцон дэмжиж, 61.9 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хороодын саналаар санал хурааж дууслаа.

Байнгын хороодын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье. Ингээд дараагийнхаа асуудалд оръё. Асуудалдаа оръё.

15:51 цаг

***Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг асуулт, хариултаар үргэлжлүүлэн хэлэлцэв.***

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, аудитын тайлантай холбогдуулан гишүүдийн өгсөн нэрсийн дагуу асуулт, хариултаа явуулъя.

Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Энэ өдрийн амрыг эрье. Тэгэхээр энэ 2025 оны Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой тайлангийн дүгнэлтийг Үндэсний аудитын газар ч уншлаа. Холбогдох Байнгын хороонууд нь хэлэлцээд дүгнэлтүүдээ уншлаа. Тэгээд маш олон асуудлууд бас ярьж болохоор байна. Өнөөдөр би яг замын чөлөөт бүстэй холбоотой асуудал хөндмөөр байна. Шадар сайдын хариуцаж байгаа хэсэгтэй холбоотой. Тухайлбал энэ тайланд дурдсанаар эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүд яг зорьсон зорилгодоо хүрэхгүй, санхүүжилт дутуугаас төлөвлөсөн ажлууд хэрэгжихгүй байна гэсэн ийм дүгнэлт гарсан байна. Монгол, Хятадын хооронд 2019 онд буюу 7 жилийн өмнө Замын-Үүд-Эрэний хоорондын ийм эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулагдсан. Хятадын Засгийн газрын зээлээр, 50 сая долларын зээлээр цэвэрлэх байгууламж, цахилгаан станц баригдсан боловч одоог хүртэл хэрэглээгүй. Нэмээд бас 30 сая долларын Азийн хөгжлийн банкны зээлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн боловч үр дүн нь тодорхойгүй ийм байдалтай байна.

Тэгээд бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Энэ чөлөөт бүс, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс гээд байгуулаад байдаг. Сүүлд Хөшигтийн хөндий гэж бас яригдаж байна. Өчигдөр бас Учрал Ерөнхий сайд хэлэхдээ нэмээд 2 аймгийг бас чөлөөт бүс болгон хөгжүүлнэ гэх зэргээр ярьж байна. Тэгэхээр яг бодит байдал дээр хэрхэн яаж чөлөөт бүс болгож чадах вэ? Өмнөх түүхүүд, сургамжууд зөндөө байна. Энэ тал дээр тодорхой хариулт авъя. Өнөө өглөө бас эдийн засаг, банк санхүү, бизнесийн сектороор үүссэн ажлын хэсэг Энхтүвшин гишүүн, Соронзонболд гишүүн, Түвшин гишүүн бид бизнесийн секторынхонтой, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимынхантай бас уулзсан. Бизнесийн салбарынхан томоохон аж ахуйн нэгжийн удирдлагууд бас сэтгэл хангалуун бус байгаагаа хэлсэн. Тэгэхээр бид нар үнэхээр бизнесийн сектороо дэмжиж чадна, янз бүрийн механизмаар энэ эдийн засаг, хувийн секторыг дэмжинэ гэдэг энэ үйл ажиллагаа мөрийн хөтөлбөр, Засгийн газрын хөтөлбөрүүдээ хэзээ, яг чухам, хэрхэн хэрэгжүүлэх вэ? Зөвхөн Шадар сайд Ганхуягаас гадна бусад холбогдох Эдийн засаг, хөгжлийн яамны үрэг гүйцэтгэгч гэх үү, Төрийн нарийн бичгийн дарга гэх үү бүгдээс нь хариулт нэхэж байна. Энэ гишүү, би Улсын Их Хурлын даргын үүргийг гүйцэтгэх үү яах вэ анхаарлаа хандуулъя чухал ажилдаа манайхан.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд жоохон дуугаа аядъя. Учрал Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Засгийн газрын гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа. Тэгэхээр өчигдөр би томилогдсон учраас бас гүйцэтгэл ярих нь бас зохимжгүй байна. Шинэ Ерөнхий сайд томилогдсоноор Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ чөлөөлөгддөг. Тэгэхээр манай Төрийн нарийн бичгийн дарга нар ажлын хэсгийнхэн бас гүйцэтгэлээ тайлагнах хэрэгтэй. Төрийн ажил тасралтгүй явах ёстой. Та бүхэн бас нэг зүйлийг ойлгоорой. 6 дугаар сарын гүйцэтгэлийг гарсны дараа тодотгол хийх

эсэх асуудлыг шийднэ. Одоогоор би Сангийн сайдгүй байна. 5 дугаар сарын 31-нд зарлагдаагүй тендерүүд татагдана.

Ингэснээр бид цаашдаа тодотголоор тэр хөрөнгө оруулалтын зардлыг хаашаа яаж шилжүүлэх вэ гэдэг асуудлыг шийдвэрлэх шаардлага үүсэж байгаа. Одоо бүтцийг хөндөөд 2 яамыг хооронд нь нийлүүлээд явахаар тодотгол хийх асуудал, шаардлага үүсэж байна. Ингээд дахиад 6 дугаар сарын гүйцэтгэлийн дараа буюу сар хүрэхгүй хугацааны дараа дахиад тодотгол хийгээд эхлэхээр энэ бол маш хүндрэлтэй нөхцөл байдалд орж байгаа. Тэр Мөнхсоёл гишүүний асуултад хариулахад өчигдөр шинэ Засгийн газар хувийн хэвшлээ дэмждэг, баялаг бүтээгчдийгээ дэмждэг, эдийн засгийн эрх чөлөөний төлөө, бизнесийнхэнд саад тотгор учруулаад байгаа бүх саад бэрхшээл, хүнд суртлуудыг чөлөөлдөг Засгийн газар байна гэдгээ илэрхийлсэн учраас Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг дагалдуулсан 20 гаруй хуулийг тухайн үед бэлдсэн байсан. Энэ хуулиудаа нэгтгэж дахиж өргөн барина.

Татварын хуулийг өнөөдөр эргүүлэн татлаа. Ингээд Их Хурлын гишүүн Соронзонболдоор ахлуулсан ажлын хэсгээс гарсан өнгөрсөн хугацааны хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэж байгаад Засгийн газар дахиад өргөн мэдүүлье. 5 дугаар сарын 1-нээс өмнө төсвийн хүрээ өргөн мэдүүлэх ёстой. Төсвийн хүрээнд жилийн төлөвлөгөө уялдаж байж бүтэц, бүрэлдэхүүн, цомхотголын асуудал яригдана. Ерөнхий сайдаар ажиллаад энэ чинь өчигдөр шөнө л томилогдлоо шүү дээ. Тэгэхээр өнөөдрөөс би ажилтайгаа илүү танилцаж байна. Юутай ч 2400 гаруй орон тоо бол төрийн албан хаагч нарын дотор томилогдоогүй ингээд илүү орон тоонууд байгаа юм байна.

Хэмнэлтийг сайн хийнэ. Тэгэхдээ долоо хэмжиж нэг огтлох ёстой. Тэрнээс биш нөгөө төрийн албан хаагчдыг 9 хувь цомхотгоно гэж хэлээд бүх шатад цомхотгол хийгээд энгийн ажлаа хийгээд явж байгаа төрийн албан хаагч нар хэлмэгдүүлэхгүй. Тийм учраас сэтгэл хөдлөлөөр биш, шинжлэх ухаанч байдлаар хандана. Тэгээд Мөнхсоёл гишүүнтэйгээ энэ эдийн засгийн эрх чөлөө, хувийн хэвшил, бизнесийг дэмжих чиглэлээр цаашид Их Хурлын дарга байхдаа ажиллаж байснаараа гүйцэтгэх засаглалын тэргүүний хувиар хамтарч ажиллахдаа таатай байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэмж ажлын хэсгийнхнээс хариулах хүн байна уу? 4 дүгээр микрофон.

**А.Даваажаргал:** Шадар сайдын ахлах зөвлөх, ажлын албаны дарга Даваажаргал байна. Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. 2001 онд Чөлөөт бүсийн хууль анх батлагдсанаар Замын-Үүд-Эрээний чөлөөт бүсийн эдийн засгийн тусгай бүс байгуулагдсан түүхтэй. 60 сая долларын асуудлыг Мөнхсоёл гишүүн асууж байна. 60 сая долларын Хятадын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр Замын-Үүдийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхээр нийтдээ 4 багц ажил хийгдсэн. Одоо эдгээр 4 багц ажлаас яг одоо бид нар ашиглагдаад явж байгаа нь дулааны станцын ажил эрчим хүчний ажил. Харамсалтай нь бохирын асуудал болон цэвэр усны асуудал өнөөдөр хүртэл ашиглалтад ороогүй. Ашиглалтад орсныхоо дараа бас тодорхой хэмжээнд тоногдсон, хэрэглэх боломжгүй ийм нөхцөл байдлууд яг Замын-Үүд сум дээр одоо үүссэн байгаа.

Чөлөөт бүс нийтдээ 900 га газрыг хамарсан Улсын Их Хурлаас хилийн цэсийн тогтоосон ийм чөлөөт бүс үйл ажиллагаагаа явуулж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мөнхсоёл гишүүн тодруулъя.

**Б.Мөнхсоёл:** Энэ маягаар ганц асуулт асуугаад хариулт аваад мөд бүтэхгүй. Байнгын хороод дээр ч гэсэн зөндөө хэлэлцэж байгаа. Өнгөрсөн жилүүдэд ч гэсэн энэ гүйцэтгэл зөндөө ярьсан. Хаа хаанаа асуудал байгаа. Их Хурал дээр ч асуудал байгааг бид нар бүгд мэдэж байгаа.

Тэгэхээр нөгөө долоо хэмжиж нэг огтол гэдэгчлэн төлөвлөөгүй бол бид нар үр дүнд хүрэхгүй гэдэгчлэн, ер нь бие биеийгээ хуурахгүй явах асар их шаардлагатай байгаа юм. Сая Ерөнхий сайд болсон манай Учрал сайд хэлж байна өмнө нь Эдийн засаг, хөгжлийн яамны сайд байсан. Тэр үед бас хамтраад ажлын хэсэг байсан учраас үргэлжлээд даргаас даргад явж байгаа шүү дээ өөрөө. Тэгэхээр гэнэтийн биш шүү. Юмаа мэдэж байгаа, бүрэн хариулах ёстой байгаа. Өөрийн чинь энэ лидершип, манлайлал асар чухал цаг үе ирж байна шүү. 2 жил бараг дууслаа, үр дүн иргэд хүлээж байна, аж ахуйн нэгж Хувийн хэвшил бид нарыг шахаж байна шүү дээ. Зөвхөн таны, зөвхөн МАН-ын биш 126 гишүүдийн хариуцлагын асуудал яригдаж байна шүү. Энэ төсөв, гүйцэтгэл энэ Засгийн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Үг хэллээ. Аюушийн Ариунзаяа.

**А.Ариунзаяа:** Мөнхсоёл гишүүнтэй санал нэг байна. Үнэн үнэн одоо ямар би цоо шинэ мэдэхгүй гэж хариулттай нь биш. Бүгдээрээ л таны үүх түүх, намтрыг мэдэж байгаа учраас асуултуудаа бас асуугаад, үг хэлээд дамжуулаад хэлсэн нь зүйтэй байх.

Учрал сайд аа одоо ийм юман дээр анхаармаар байгаа байхгүй юу. Би өчигдөр Байнгын хороон дээр ч гэсэн бас хэлсэн. Хэмнэлтийн тухай хуулиа хүчингүй болгочихмоор байгаа юм. Яагаад гэвэл алаг цоог үйлчлээд байгаа байхгүй юу. Тэгээд төсвөөрөө, төсвийн бодлогоороо энийгээ яг бодлогоо аваад явахгүй л бол Хэмнэлтийн тухай хууль чинь нэгдүгээрт төсвийн үр ашгийг маш их бууруулж байгаа. Хөдөө орон нутагт агентлагууд, хөдөө орон нутгийн төрийн байгууллагуудад маш их хүндрэлийг учруулж байгаа. Тэгээд үйлчлэх хүндээ үйлчлээд үйлчлэхгүй хүндээ үйлчилдэггүй ийм алаг цоог хууль болчхоод байгаа. Өөрийнхөө цаг үедээ, хэрэгцээтэй байх үедээ хэрэгцээгээ хангаад явчихсан. Тэгээд үүнийгээ анхаарах хэрэгтэй.

Хоёр дахь нь болохлоор яг 1 жилийн хөгжлийн төлөвлөгөө гэж гаргадаг нь өөрөө улсын төсөвтэйгөө ердөөсөө уялддаггүй. Тэгэхээр дунд хугацааны буюу богино хугацааны энэ бодлогуудаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гэж 4 жилээр харах юм бол тухайн 1 жилийнх нь уг нь улсын төсөв л баймаар байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол ингээд хөгжлийн бодлого гэж гишүүд өөрсдийнхөө мөрөөдлийн жагсаалтаа оруулаад л дараад нь төсөв гэж бас дахиад л дунд нь будилуулаад л ингээд хоорондоо ямар ч уялдаагүй. Эргээд эцэстээ өчигдөр юу гэж яригдсан бэ гэхлээр би энэ Улсын Их Хурлын гишүүд л ингэж баталдаг шүү дээ, Улсын Их Хурлын л буруу шүү дээ гээд эргээд л Улсын Их Хурал руу орж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол Засгийн газраас өөрөөс нь орж ирж

байгаа асуудлууд дээр Улсын Их Хурал дараад нь ингээд л бурууг нь үүрээд л явдаг нь ер нь буруу. Энийг анхаарч өгөөрэй гэж хүсмээр байна.

Хоёр дахь нь болохлоор хүүхдийн хөгжил хамгаалалд онцгой анхаарна гэж өчигдөр хэлсэн. Тэгээд яг энэ асуудалтай холбоотой би бас нэг ийм асуудлыг дэвшүүлэх гэсэн юм. Энэ гишүүдийг буруутгаад нэг зүйл сая сүүлд харагдсан. Тэр дээр би үнэхээрийн бас гайхширал төрөөд энэ төсвийн хэмнэлтийг явуулахдаа эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгааллын салбарыг үлдээнэ гэж ярьсан шүү дээ. Тэгээд хүүхэд хамгааллын зардлаас хасчихсан байх юм. Тэгээд түүнийгээ хасчихсаныгаа эргүүлээд тэр нөгөө хүүхдийн агентлагийн дарга нь Баярсайхан 32 Улсын Их Хурлын эмэгтэй гишүүнтэй болчихоод хүүхэд хамгааллын зардлаа хасуулсан гээд эргээд Улсын Их Хурлыг буруутгаж байгаа байхгүй юу. Үгүй тэр хүн Улсын Их Хурлын гишүүн байхад эсрэгээрээ сайдаар би ажиллаж байхад биднийг ажлаа хийсэнгүй гэдэг байсан. Тэр хүн Улсын Их Хурлын гишүүн байсан. Тэгээд одоо эргээд нөгөө агентлагаа өөрөө ахалж байгаа хүн. Дахиад түүний буруу биш Улсын Их Хурлын гишүүдийн буруу болчихож байгаа байхгүй юу. Юу гэсэн үг юм бэ? Тэгээд хэн, хэзээ, хаана ажлаа хийх юм бэ? Бид нар ямар хассан юм уу? Энэ жилийг ч гэсэн улаан, ногоон лаазаар юу болсныг харсан биз дээ? Хүүхдийн хөгжлийн, Хүүхдийн төлөө сан, Хүүхдийн төлөө сангийн үлдэгдлийг надаас байнга асуудаг. Хэдэн төгрөг одоо байгаа юм, яагаад зарцуулахгүй байгаа юм? Энх-Амгалан сайдаас би бас асууж байсан шүү дээ тухайн үедээ. 22 тэрбум төгрөг байна, энэ жил хэдийг зарцуулах вэ гэсэн 8 тэрбум төгрөг өө гэсэн. Зарцуулаагүй одоо хүртэл тэндээ байгаа. Хүүхдүүдэд ердөөсөө сурталчилгаа хийхгүй байна. Олон улсын тэмцээн, уралдаан, наадамд оролцоод ирсэн хүүхдүүдийг шагнаж чадаж байгаа юу? Хүүхдүүдэд мэдээлэл хүргэсэн юм уу? Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэр спортын уралдаан, тэмцээнд нь бэлтгэхэд нь хүртэл зардал гаргадаг шүү дээ. Тоног төхөөрөмжийг нь авч өгч болно, уралдаан, тэмцээнд нь оролцуулж болно. Юу ч хийхгүй байгаа шүү дээ. Зам, тээврийн сайд уурлах нь аргагүй байхгүй юу. Азын дугаар борлуулсны төлбөрийг өгч байгаа. Тэгээд яг юу хийсэн юм? Одоо яг хэдэн төгрөг байна вэ, яагаад зарцуулахгүй байна вэ? Яагаад сар бүр нийтэд мэдээлэх үүргээ хүлээхгүй байна вэ? Ийм асуултыг л асууя даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал Ерөнхий сайд хариулна. Энэ хэлэлцүүлэг чинь хугацаатай.

**Н.Учрал:** Энэ хуулийн хугацаатай. Нөхөд өө, энэ хуулийн хугацаатай, хуулийн хугацаатай, 4 дүгээр сарын 1-нээс өмнө гүйцэтгэлээ Их Хуралд тайлагнах ёстой. Төрийн ажил тасралтгүй явагдана. Тэгээд сандал суудал улс төржих юун энэ сэдэв л байна даа гээд гаргаж ирээд энд улс төржөөд байх юм байхгүй. Энэ тийм шинэ сэдэв ч биш. Би өмнө нь Эдийн засаг, хөгжлийн сайд байсан. Энэ жилийн төлөвлөгөө, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр би бүгдийг нь өөрөө ахалж бичсэн. Цоо шинэ ажилд оччихоод байгаа юм байхгүй. Тэр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн яригдаж байх үед тэр автомашины сонирхол татахуйц дугааруудаас олсон, нөгөө дуудлага худалдаанаас олсон орлогыг жил бүр Хүүхдийн төлөө санд төвлөрүүлдэг юм шүү дээ. 24 онд хэд төвлөрсөн одоо тэрийгээ яг тоогоор нь хэлээрэй. 25 онд хэд төвлөрсөн? Тэгээд тэрийгээ тоогоор нь хэл. 24 онд хэд байлаа гэдгээ тоогоор нь сүүлийн байдлаар хэлмээр байна. Тэгэхээр цаашдаа хүүхэд хамгааллын асуудлыг би онцгойлон анхаарна. Их Хурлын дарга байхдаа хэлсэн.

Тийм учраас хүүхэд хамгаалал дээр онцгойлон анхаарч ажиллана. Одоо бүгдээрээ эмх замбараатай явна. 5 дугаар сарын 1-нд төсвийн хүрээ өргөн мэдүүлнэ. Төсвийн хүрээ тэгж байж жилийн төлөвлөгөө чинь түүнтэй уялдана. Тэгж байж ирэх оны төсвөө өргөн мэдүүлнэ. Төлөвлөлт, төсөвлөлт гэдэг зүйл чинь системтэй явах ёстой. Тийм учраас ингэж одоо явна. Тэрнээс биш надад амархан байна л даа. Би өчигдөр 12 гээд томилогдсон. Тэгээд шөнө суугаад 5 яамыг нийлүүлчихье, хэдэн агентлагийг нийлүүлчихье гэж өөрөө шийдэж байгаад оруулж ирвэл энэний ард хэн хэлмэгдэх вэ? Зүгээр нөгөө төрийн албан хаагч нарыг л хэлмэгдүүлэх гээд байгаа байхгүй юу. Тэгээд төсвийн тодотгол гээд энд сар хэлэлцэнэ.

Тэгээд төсвийн тодотгол гээд сар хэлэлцээд байж байтал 5 дугаар сарын 31-нд нөгөө тендерүүд чинь зарлагдаагүй бол татагдчихна. Тэгээд араас нь 6 дугаар сарын гүйцэтгэлээр яаж гарахыг мэдэхгүй байна шүү дээ. Энэ чинь биднээс ч зөвхөн хамааралтай биш болчихоод байна. Энэ түүхий эд бүтээгдэхүүний чинь үнэ хэлбэлзэж байна.

Дээрээс нь наад газрын тосны бүтээгдэхүүний чинь үнэ өсчихөөр нөхцөл байдал ийм хүндрэлтэй байгаа учраас гүйцэтгэл ямар байх вэ. Орлого яг тасрах уу үгүй юу? Яг өнөөдрийн байдлаар төсөв тодотгох нөхцөл шаардлага үүсээгүй байна. Гэхдээ 6 дугаар сард юу болох юм мэдэхгүй. Тэгээд сар болгон тодотгол хийдэг болох уу гээд. Тэгэхээр хурдан хугацаанд ажилдаа орох гэхээр өчигдөр Ерөнхий сайдаар томилогдсон өнөөдөр надад яг одоогийн байдлаар сайд байхгүй байна шүү дээ. Ганцаараа ажлаа хийж байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр өнөөдөр бүгдээрээ бас энэ гүйцэтгэлээ энэ төрийн албан хаагч нараасаа асуугаад тэгээд цаашдаа би анхаараад явъя. Тэгээд өөрийнхөө жилийн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Төрийн нарийн бичгийн дарга 4 номер.

**Л.Мөнхзул:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Анх хүүхдийн төлөө санг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагуудын сайн дурын санаачилгын үндсэн дээр байгуулж эхлүүлсэн. Анхны хөрөнгийн эх үүсвэрт 2 тэрбум 77 сая төгрөгийн хандив цугларсан. Уг хандив яг тоо ёсоороо хариуцах байгууллагууд нь акт үйлдэгдэн 2021 онд хүлээлгэж өгч. Ингээд Албан ёсоор сан байгуулагдсан. Өнгөрсөн хугацаанд жил бүр азтай буюу сонирхол татахуйц улсын дугаарын борлуулалтын орлогоос төвлөрсөн 24 онд гэхэд 10 тэрбум 992 сая төгрөг, 25 онд 5.4 тэрбум төгрөг төвлөрсөн. 25 оны эцсийн байдлаар 29.4 тэрбум төгрөг Хүүхдийн төлөө санд гүйцэтгэлээр байна.

Өнгөрсөн хугацаанд 21 оноос хойш 1.8 тэрбум төгрөгийг олон улсын тэмцээн, уралдаанд хүүхдүүд амжилт гаргасан хүүхдүүдийн шагнал, урамшуулалд олгосон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд олон улсын тэмцээн, уралдаанд орохтой холбогдолтой зардлыг гаргасан. Бүтээн байгуулалтын шинж чанартай хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгээгүй.

Харин 25 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хуралдсан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн хурлаар 7.1 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтад зарцуулахаар шийдвэр гарсан. Энэ худалдан авах ажиллагаа нь хийгдэж байгаа. Бүтээн байгуулалтын нэг хэсэг нь 4.6 тэрбум төгрөгийг хүүхдийн өвчлөлт,

хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахад 2.4 тэрбум төгрөгийг олон улсын Найрамдал цогцолборын зуны байшингийн хоолны засвар, шинэчлэл, тоног төхөөрөмжийн шинэчлэл, задгай талбай, хөл бөмбөгийн задгай талбайн засвар шинэчлэлд зарцуулахаар ингэж төсөв нь батлагдаад худалдан авах ажиллагаа нь хийгдээд дуусаж байна. Ингээд он дамжиж хэрэгжих арга хэмжээ байгаа.

26 онд 14 тэрбум зарцуулагдахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна. 4 дүгээр сарын 1-ний дотор аймаг, орон нутгаас ирсэн Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр бүтээн байгуулалт хийх саналыг яам хүлээж авах хуулийн хугацаа, журмын хугацаатай байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ариунзаяа гишүүн тодруулъя.

**А.Ариунзаяа:** Ямар ч байсан ингээд Хүүхдийн төлөө сан Төрийн сангийн дансанд байгаа. Олон нийтэд бас нээлттэй шилэн данс дээр байгаа 24 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаа гэдэг нь ингээд албан ёсны эх үүсвэрээс албан ёсоор хэлэгдлээ.

Ерөнхий сайдаас би энэ хүүхдийн төлөө санг амилуулж өгөхийг бас хүсэж байна гэдгийг хэлээд тэгээд 1 тодруулах зүйл нь сая та намайг загначхав уу, эс үгүй бол өөр хүмүүсийг загначхав уу? Энд шуугиад байсан хүмүүсийг загначхав уу? Би хүүхдийн төлөө асуулт асууснаараа эргээд нөгөө улс төржсөн юм шиг тийм сонин зандрахлаар нь бас гайхаад суучихлаа. Энийгээ бас тодруулж өгч яг одоо энэ хүүхдийн төлөө ажиллах ёстой энэ ажил маань эмэгтэй гишүүдийн асуудал дангаараа биш байхгүй юу даа. Тэгээд өнөөдөр энэ тулгамдсан асуудлыг маш сайн анхаарч үзэхгүй бол хүний хөгжлийн асуудал хүртэл Эдийн засаг, хөгжлийн яаманд байгаа шүү дээ. Эдийн засгийн хөгжил биш, Эдийн засаг, хөгжлийн яаманд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг бас анхаарч үзэхгүй бол ердөөсөө болохгүй гэдгийг л бас дахин.../минут дуусав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал Ерөнхий сайд.

**Н.Учрал:** Ариунзаяа гишүүн бол хүүхэд хамгаалалд анхаараач гэсэн. Харин би хүүхэд хамгаалалд онцгой анхаарна гэсэн. Тийм тэгэхээр таныг загнана гэж юу байх вэ. Харин та бид 2 санал нэг байна. Ер нь чуулганы хуралдаан дээр сая чинь ингээд тэр хариулна, хариулахгүй гээд ингээд түрүүн бас Мөнхсоёл гишүүн ярьж байхад ингээд Их Хурлын гишүүд анхаарахгүй болохоор хэн хэндээ их төвөгтэй байна л даа. Тийм учраас би саналаа хэлээд байгаа юм. Ялангуяа сая жишээ нь Аубакир сайд өөрийнхөө хийж байсан ажлаараа гүйцэтгэлийнхээ талаар мэдээллийг өгмөөр байдаг.

Гэтэл хариулж болохгүй гээд ингээд байхаар их нөхцөл байдал өнөөдөр нөгөө гүйцэтгэл хэлэлцэхэд их төвөгтэй байна шүү дээ. Гэтэл 4 сарын 1 маргааш болчихоод байдаг. Тэгэхээр уг нь хариуцаж байсан сайд нар энэ гүйцэтгэлээ өөрсдөө хариулаад явмаар байгаа юм. Өнгөрсөн хугацаанд хийж байсан ажил нь учраас. Тэгэхээр Ариунзаяа сайдын хэлсэн би хүүхэд хамгаалал дээр болоод Хүүхдийн төлөө зөвлөлийг амилуулах, таны ярьж энэ эхлүүлж байсан энэ дугаараас олох сан.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Сая гишүүдээс бас гарсан огцорсон сайдын хариултыг сонсохгүй гээд бас сая үгээ яриад байна. Яах вэ энэ зүгээр яг үнэн бодитойгоор хариуцлагатайгаар хариулах гэдэг утгаараа магадгүй энэ шаардлага бас зөв байж болох юм. Тийм болохоор төрийн өмнө үүрэг хүлээсэн Төрийн нарийн бичгийн дарга нар хариуцлагатайгаар хариулаад явах нь зүйтэй байх гээд бодож байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

**О.Номинчимэг:** Яах вэ энэ өнөөдөр хэлэлцэж байгаа асуудлыг хараад нэг ийм сэтгэл сэрдэх ийм тоо харсан. Монгол Улсын Засгийн газрын энэ үйл ажиллагааны 2025 оны гүйцэтгэлийн тайлангийн 3 дугаар хуудас, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн 4 дүгээр хуудсан дээр яг адилхан тоо баримт байгаа юм. Энэ нь юу гэхээр хүний хөгжлийн индекс шалгуураараа манай улс 9 байраар ухарсан байна. Тэр дундаа маш улаан дохио өгсөн нэг тоо бол Монгол Улсын хүний хөгжлийн индекс дотор дундаж наслалт 72.7-гоос 1 жилийн дотор 71.7 нас болж буурсан, нас баралтын түвшин, архаг өвчин, осол гэмтэл, амьдралын хэв маягтай холбоотой эрсдэлүүд бодлогын түвшинд бүрэн шийдэгдээгүй байна гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа юм.

Тэгээд тоо бид нарт худлаа хэлэхгүй. Би энэ тоог хараад энэ чинь 2024 онтой харьцуулахад бүхэл бүтэн 1 насаар Монгол Улсын хүн амын дундаж наслалт буурчихсан байгаа нь Нэгдүгээрт, манай улс дайн дажинтай улс биш, Хоёрдугаарт, цар тахал гараагүй ийм нөхцөлд ингэж буурч байгаа нь энэ үнэн үү гээд үнэндээ бас нүдэндээ итгэж чадаагүй. Гэхдээ ялт ч үгүй энэ тайлан дээр 2 ч тайлан дээр орсон байна. Энэ бид нарын хувьд маш том улаан дохио болж байгаа Хөгжлийн бодлогын хувьд энэ зүгээр эрүүл мэндийн статистик тоо биш. Монгол Улсын хөгжлийн бодлого хаашаа явж байна гэдэг дээр улаан том ийм дохио болж байгаа гэдгийг хэлмээр байна.

Тэгээд энэ дээр уг нь бас асуумаар байгаа. Эрүүл мэндийн энэ тусламж, үйлчилгээ чинь үр дүнгүй, хүртээмжгүй байгаад байна уу? Урьдчилсан сэргийлэх бодлого ерөөсөө яахгүй. Өвдсөнийх нь дараа л эмчлэх ийм загвар давамгайлаад байна уу? Архаг өвчний чинь нас баралт нь өндөр байгаад байна уу? Тусламж, үйлчилгээ очихгүй байна уу? Эх нярайн эндэгдэл чинь өссөн байна. Энэ дээрээ яагаад ийм болчихов оо? Улс төрчдийн хувьд бид нар энэ танхимд юу хэлэх ёстой вэ гэхээр энэ ерөөсөө өөрөө Нэгдүгээрт, бид нарын хүний хөгжлийн бодлого чинь байгаа онохгүй явсаар байна. Тэр чинь энэ тоон дээр ингэж гарч байна.

Хоёрдугаарт, эдийн засгийн өсөлт чинь хүн төвтэй биш байна. Чанарт биш тоонд суурилсан өсөлт гараад байна. Ийм болохоор энийгээ бид нар бас маш сайн анхаарах ёстой байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Эрүүл мэндийн яам юм уу, Төрийн нарийн хариулах байх. Энэ Монгол хүний дундаж наслалт бүхэл бүтэн 1 насаар багасчихсан байгаа нь юунаас үүдэж байгаа юм бэ? Би зүгээр тоо баримтуудыг нь жоохон шалгаж үзсэн л дээ.

Тэгэхээр эх нярайн эндэгдэл нэлээн өндөр болчихсон байна. Юунаас болж байна? Бодит байдал яг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үнэхээр хүртээмжгүй байгаа. Санхүүжилтийн буруу загварт орчихсон байгаа. Дээр нь үнэхээр бид нар Монгол Улсын хувьд нийгмийн эрүүл мэндийн бодлого дээрээ урьдчилан сэргийлэх бодлогыг хийж чадахгүй байна. Дандаа өвдсөнийх нь дараа хойноос нь барилга байшин барьж эмчлэх гэж оролддог ийм л загварт байна. Энэ дээр та

бүхэн ер нь дүгнэлт хийв үү? Цаашид бид нар энэ дээрээ яах ёстой вэ? Зүгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ ингээд арга хэмжээний юмнууд бас байна л даа. Тэгээд арга хэмжээ биш бид нар ерөөсөө үр дүн дээр суурилж л бодлого, төлөвлөгөөгөө ярихгүй бол болохгүй байна.

Тэгээд энэ бас тайланд дурдагдсан байгаа төсөвгүй төлөвлөлт, төлөвлөлтгүй төсөвтэй явж байна. Бүхэл бүтэн 327 арга хэмжээг бид нар 2025 оны хөгжлийн төлөвлөгөө дээрээ тавьсан боловчиг төсөв дээр зөвхөн гуравны нэг буюу гуравны хоёр буюу 200 гаруй дээр 107 дээр нь ямар ч төсөл, арга хэмжээн дээр нь санхүүжилт тусгагдаагүй байна. Тэгээд ийм нэгдсэн төсөвгүй төсөвлөлт, төлөвлөлт хийгээд үр дүн ерөөсөө гарахгүй байгаа дээр ард түмэн бухимдах нь аргагүй шүү дээ. Төр ямар ч үр дүнгүй байна, данхайсан байна, ерөөсөө уялдаж үр дүн гарахгүй байна гэдэг дээр. Тэгэхээр энэ цаашид бас энэ төсөв, төлөвлөлт хоёроо нэгтгэж явахгүй бол бид нар хэчнээн жил болгон энд төлөвлөгөө, төсөв яриад үр дүн ерөөсөө гарахгүй хий дэмий цагаа үрсэн л ийм асуудал болоод байна гээд хэлмээр байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга хариулах уу? Өөрийгөө танилцуулаарай.

**Д.Очирбат:** Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат хариулж байна. Хүний амьдрах хугацааг тодорхойлох гол шинжүүр нь дундаж наслалт байдаг. Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2024 онд улсын хэмжээнд 71.8, сүүлийн 10-н жилийн дунджаас 1.2, өмнөх оноос 0.3 жилээр тус тус нэмэгдсэн байгаа. Хүйсээр харьцуулбал эмэгтэйчүүдийн дундаж наслалт 77.1, эмэгтэйчүүдийнх 67.9 болж байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэй дундаж наслалтын зөрүү 9.2 байгаа юм. Дундаж наслалт нь таамаглагдах хэмжигдэхүүн бөгөөд насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тооцсон нь тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогддог. Энэ дундаж наслалтыг зөвхөн Эрүүл мэндийн яаман дээр бас харьяалуулж болохгүй. Амьдралын нөхцөл, нийгмийн нөхцөл байдал олон шалтгаант зүйлээс хамаарна гэж ойлгож байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Номинчимэг гишүүн тод тодруулъя.

**О.Номинчимэг:** Тэгвэл энийг Эдийн засаг, хөгжлийн яам энэ дээр хяналт шалгалт хийж дүгнэлт гаргасан байна яах хариулах юм уу? Дундаж наслалт чинь тэгвэл юу юуны фактороос болоод 1 жилийн дотор 1 насаар багасчхаад байгаа юм бэ энэ чинь? Та бүхэн бол энэ НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн энэ бүүр индексийг 2025 оны тайлангийн дүнг тавьсан байна шүү дээ. Тэгээд энэ Эрүүл мэндийн яам нь болохоор манайх ийм байгаа гээд яриад байдаг. Энэ индексээрээ бид нар буурчхаад байдаг, эрүүл урт нас чинь багасчхаад байна 1 насаар.

Хоёрдугаарт, чанартай боловсрол чинь дахиад бас 1 функт орчмоор буурчхаад байна. Тэгэхээр хүний хөгжлийн бодлого чинь ерөөсөө үр дүн гарахгүй. Харин ч муудаад байна л гэдэг үзүүлэлтийг энэ тайлан дээр угаасаа дурдсан байна шүү дээ. Энэ чинь юунаас болж байгаа юм? Энэ дээрээ дүгнэлт хийж байгаа юм уу?

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ тодорхой асуулт асуугаад байна шүү дээ. Хэн хариулах вэ? 3 номер.

**Б.Батцэцэг:** Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батцэцэг Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ Засгийн газрын 43 дугаар тогтоолоор гаргасан энэ үр дүнг үнэлэх журам байгаад байгаа юм. Тэгээд бид нар яг энэ Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар байгуулагдсанаас хойш 3 жил энэ өмнөх журмаар болон энэ журмаар үнэлж байгаа. Өмнөх журам бол харьцангуй сайжирч орж байсан боловч яг одоо таны асуугаад байгаа энэ факторууд ямар шалтгаан, үр нөлөө үзүүлэв гэдгийг энэ журмаар үнэлэхэд бас учир дутагдалтай юм байна лээ. Энэ журам юуг, яаж үнэлээд байна гэхээр хүрсэн үр түвшнээс суурь түвшнээ хасаад, зорилтот түвшнээсээ суурь түвшнээ хасаад тэрний тэр хоёрыг хооронд нь хуваангуутаа 100 хувиар үржүүлээд л ингээд бид нар тоон үнэлгээ гарч ирээд байгаа байхгүй юу. Гэтэл нөгөө чанарын үнэлгээ, бодлогын үнэлгээ эд нар нь манай дээр одоо хүртэл учир дутагдалтай. Бид нар энэ талаар хүний нөөцөө чадавхжуулах чиглэлээр явж байгаа. Энэ.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номерын микрофоныг дахиад сунгая.

**Б.Батцэцэг:** Дундаж насжилттай холбоотой индексүүдийг бид нар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон улсад үнэлж байгаа индексээр нь авч үзсэн. Яамнууд маань саяхан гаргаж байгаа тоонууд бас дотооддоо хэрэглэдэг тоонууд нь байж магадгүй юм. Тэрийг нөгөө тэр НҮБ-ын хөгжлийн индексийг харж үзсэн тоо байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дундаж наслалт хорогдсон шалтгаан гээд байна шүү дээ тийм үү? Тэр саяын журмыг чинь хаана, хэн баталдаг юм? Сайд чинь баталж байгаа биз дээ? Болдын Уянга асуултаа асууя. Ерөнхий сайд, дэд сайд нараа бас урьсан нь дээр байх аа. Тийм дэд сайд нарыг дуудъя.

**Б.Уянга:** Яг энэ 25 оны Засгийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэлтэй холбоотой төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх үеэр нь яг Монгол Улсад төсөв бүрдүүлж байгаа яамнууд болон байгууллагуудынхаа 25 оны гүйцэтгэлтийг нь дүгнээд асуулт асуугаад хариулт авсан юм. Тэгээд тэрэнтэй холбоотой дүгнээд нэгдсэн чуулган дээрээ нэг дүгнэлтийг хэлээд цаашдаа яах вэ гэдэг дээр нь санал солилцмоор байх юм. Тэгээд боломжтой Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ч юм уу хариулаад өгөөрэй.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамыг асуусан. Яагаад гүйцэтгэл нь 50 хувь хүрэхгүй байна вэ гээд. Тэгэнгүүт үйлдвэр технологийн парк явах тэр явц нь өөрсдийнх нь гүйцэтгэл хэмжих нэгж нь болчихсон байсан учраас энэ нь хувийн хэвшлийн үйл ажиллагаатай холбоотойгоор манай үнэлгээ доош татагдчихлаа гэлээ. Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамныхан болохоор өөрсдийнх нь төлөвлөгөөнд байсан үйл ажиллагаа нь төсөвгүй байсан. Боомтын сэргэлтийн Үндэсний хороог дуудаад дуудаад гарч ирсэнгүй. Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны үйл ажиллагаа ер нь яг юу болж байгаа юм бол? Тэгээд Сангийн яамнаас эцэс төгсгөлд нь хариулахдаа Азийн хөгжлийн банкны төслөөр санхүүжилтээр явуулж байгаа төслүүдийн хэрэгжүүлэгч байгууллага нь өөрчлөгдсөн учраас гээд бүх юм шалтагтай. Тэгээд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрыг асуухаар өөрсдийнх нь хийх ёстой 25 оны үйл ажиллагаа дээр хуулийн төслүүд бичээтэй байсан байгаа юм. Тэгээд буруу нь биш шүү дээ. Муу үнэлгээ

авсан нь хуулийн төсөл нь батлагдаагүй буюу Улсын Их Хуралтай холбоотой болчхож байгаа юм.

Тэгэхээр ер нь ингээд 2024 оны гүйцэтгэл орж ирж байхыг санахад ч тэр 25 оны энэ нөхцөл байдлыг дүгнээд хэлэхэд ер нь дараа 26 оны гүйцэтгэлийг бид нар харахад хүртэл ийм нийтлэг жишиг дахиад ажиглагдах болоод байна. Төсөв тавьж өгөхгүй байна. Хууль батлагдаагүй ээ, төлөвлөлтийн алдаа гарсан, хэмжих нэгж нь буруу байна, шалгуур үзүүлэлт нь тодорхой биш байна гээд. 24 он дээр ч ийм зөвлөмжүүдийн Үндэсний аудитын газар өгсөн. 25 он нь энэ давтагдаад гарсан. Одоо тэгвэл үлдэж байгаа 2 жилдээ яах вэ гэдэг дээр л тийм дүгнээд хэлчихмээр байх юм 27, 28 он. Үндэсний аудитын газар энэ асуудлыг олж харжээ. Хариулж байна л даа бас тээ? Бүх энэ төсөв захиран зарцуулж байгаа субъектүүдэд өөрсдийнхөө зөвлөмжийг өгсөн. Тэгээд гүйцэтгэхгүй бол яах вэ? 26 оны эхний улирал “good” явж байгаа.

Тэгэхээр үлдсэн 9 сардаа яах вэ гэдгийг нь зөвлөмжөө Хэрэг эрхлэх газраасаа гаргаад яг тэр хүрээнд нь эсвэл дүгнэе. Өөрт хамааралгүй зүйлийг нь хэмжих нэгж байдлаар тавьчхаад тэгээд тэр нь угаасаа яамдын гүйцэтгэлийг нь доош нь татна. Энэ бол бодит биш. Тэгэхээр урьдах, өмнөх зүйлүүдээ ингээд дүгнээд базах юм ийм л байгаа юм чинь. 26 оны 9 сар үлдэж байна. 27, 28 оны гүйцэтгэлүүдээ ядаж бодитой хэмжээд цаашаа яах вэ гэдгээ харж явмаар байна. Тэгээд энэ дээрхэн хариулах хариулах юм бол?

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд хариулья.

**Н.Учрал:** Их Хурлаар сая баталсан таван жилийн үндсэн чиглэл яг Уянга гишүүний ярьж байгаатай адилхан хэмжих нэгжтэй. Бид нар ирэх жилийнхээ төсвийн хүрээг ч тэр жилийн төлөвлөгөөг ч тэр оруулж ирэхдээ нөгөө индексүүддээ тавьдаг. Жишээ нь манайх эдийн засгийн эрх чөлөөний индексээр эхний 60 байранд орно гэдэг зорилт тавиад энэ индекст хүрэхэд яамнууд ямар нэгж, хувиар үр дүн үзүүлэх вэ гээд яамнууд дээр нь тавьдаг. Жишээ нь эдийн засгийн эрх чөлөөний индексээр эхний 60 байрт орно гэхээрээ Уул уурхайн яам үүн дээр 2 нэгж хувиар үүрэг гүйцэтгэнэ гэнгүүт Уул уурхайн яаман дээр үүргээ өгөхдөө тэгвэл та нар Оюу толгойтой хэлэлцээр хийнэ.

Тэгвэл одоо шинэ төслөө хэрэгжүүлнэ. Ингэж хийж байж танай энэ индекс урагшлах юм гэд гэдэгтэй яг адилхан. Сая жишээ нь дундаж наслалтын асуудлыг ярихад дундаж наслалт чинь зөвхөн Эрүүл мэндийн яамны ажил биш болчихоод байгаа байхгүй юу. Жишээ нь боловсролын салбар дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд тэр соён гэгээрлийн ажлуудыг яаж хийх вэ? Соёлын яам түүн дээр ямар хувь нэмэр оруулах вэ? Спортын яам жишээ нь тухайн хүнийг урт наслуулахын тулд ямар хувь нэмэр оруулах вэ гэдэг шиг ерөөсөө энэ индекс урагшлуулна гэдэг бол яам болгон дээр нэгж хувиар тавьж байгаагаараа гол онцлогтой.

Тэгэхээр таван жилийн бид нар энэ чиглэлээ батлахдаа ингээд 10 үндэсний үзүүлэлт гээд тавьсан шүү дээ. Тэгээд дахиад салбарын үзүүлэлтүүд. Тэгэхдээ энэ чинь дандаа тоогоор, нэгжээр. Түүн дээр яамнууд ямар ямар хувь нэмрээ оруулах вэ? Жишээ нь ирэх жилийнхээ төсвийг бид нар оруулж ирэхдээ эдийн засгийн өсөлтийг тэдэд хүргэнэ гэж тавих чинь нэг яамны ажил биш байдаг биз дээ.

Энэний тулд Уул уурхайн яам яг ямар ямар төсөл явуулах юм, Зам, тээврийн яам ямар ямар ажлуудыг хийх юм, барилгын яам ямар ажлуудыг хийх юм гээд тэр ажлууд бүгд явж байж тэр эдийн засгийн өсөлт хангагддаг.

Тэгэхээр тэр таван жилийн чиглэлийг би Эдийн засгийн сайд байхдаа өөрөө бас боловсруулчихсан учраас мэдэж байгаа. Тэгэхээр энэ жил тэр таван жилийн үндсэн чиглэлээ барьж байгаад 5 дугаар сарын 1-нд хэдүүлээ төсвийн хүрээгээ өргөн барих ёстой. Тэгээд жилийн төлөвлөгөөгөө өргөн барих ёстой. Тэгээд Уянга гишүүний ярьж байгаатай адилхан бид нар нэгж хувиар дүгнүүлнэ.

Ингээд хэрвээ тухайн тэр ажлыг хариуцаж байгаа хүн, тухайн яам хангалтгүй гэж үнэлэгдэж байвал хариуцлага тооцно. Тэрнээс төрийн байгууллага дээр чинь жил болгон асууж байгаа сая Уянга гишүүний ярьдаг шиг ерөөсөө та нар ямар хариуцлага тооцож байгаа юм, хангалтгүй гэж үнэлчхээд юу хийж байгаа юм. Хуучин бол энэ ажлыг хийхийн тулд тэдэн хурал хийлээ, тэдэн зөвлөгөөн хийлээ гээд 50 хувийг нь хийсэн юм байна гээд дүгнэдэг байсан. Одоо бол зөвхөн индекс тавьж байгаа шүү дээ. Тэр тоонд хүрээгүй бол хангалтгүй. Тэрэнд хүрэх гэж яаж явсан нь сонин биш байхгүй юу. Тэгэхээр бид нар ийм индикаторууд тавиад одоо үнэлээд явъя. Түүний дараа шат шатад хариуцлага тооцъё.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номерын микрофон.

**И.Батхүү:** Уянга гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах явц төсвийн уялдаа бас асуудал байгаа. Яагаад гэвэл улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулсан хөрөнгө оруулалт, бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэх чиглэл улсын төсвийг боловсруулна гэж заадаг байсан байгаа боловч Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явцад төсвийн ерөнхийлөн захирагч нарын хязгаар гараагүй байдаг. Төсвийн хүрээн дээр ерөнхий зарлагын хязгаар тавьчихаад байдаг. Цаашдаа яг төсөв батлагдах үедээ хязгаарыг нь тодотгоод тавьчихаар нөгөө хөрөнгө оруулалтын төлөвлөсөн ажлууд маань төсөв дээрээ бас таардаггүй нэг асуудал байдаг.

Хоёрдугаарт нь яг тухайн тухайн жилийн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах явцад цаг үеийн нөхцөл байдал өөр өөр байдаг. Жишээ нь 25 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах явцад 24 оны 4 сарын 30-нд Улсын Их Хуралд өргөн барьсан бол хаврын чуулганаар батлагдаагүй. Сонгуулийн дүнгээр хамтарсан Засгийн газар байгуулагдсаны дараа 9 сарын 27-нд дахиж шинэчилж барьсан, өргөн барьсан. Энэ.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номерын микрофоныг 1 минут сунгая.

**И.Батхүү:** Энэ хугацаанд хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах, Засгийн газрын хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах гээд олон олон ажил бас намрын хэлэлцүүлэх төсвийн төслийг боловсруулах олон ажил давхцаж байсан. Холбогдох бэлтгэл ажил, хэлэлцүүлгүүд бас хангалттай хэмжээнд хийгдээгүй байж болох талтай. Ийм бодит байдал дээр иймэрхүү нөхцөл байдлууд үүсэж байсан.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганбатын Очирбат.

**Г.Очирбат:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Ингээд төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэл хоорондоо ингээд ямар ч нягт хамааралтай биш явж байгаагийн үр дүн л гарч байгаа юм л даа. 2024 оны гүйцэтгэлийг бид нар 25 онд ярьсан. Бас 50 хэдэн хувь л байсан. Одоо ингээд 25 оны гүйцэтгэлийг 26 онд ярьж байна. Аудитаас 58.1 гээд гаргаад ирсэн. Тэгээд одоо 50 хувьтай ажил хийж байна гэдэг чинь муу шүү дээ. Ажил хийж чадахгүй байна шүү дээ. Одоо Их Хурлын дарга болчихсон өчигдөр Их Хурлын даргаасаа буугаад Ерөнхий сайд хийж байна Учрал дарга Оюун-Эрдэнийн Засгийн газарт ажиллаж байсан та, Занданшатарын Засгийн газарт ажиллаж байсан. Одоо та Ерөнхий сайд болж байна. Бүх зовлон, жаргалыг нь мэдэж байгаа. Тэгээд дараа жил энэ 50 хэдтэй тоо хармааргүй байна. Залуу хүн, залуу гишүүдийн маань сэтгэл найдвар гэж харж байгаа. Монголчуудаараа энийг харж байгаа. Дараа жил 50 хэд гэсэн тоог хармааргүй байна шүү. Энийг 2 жил дараалан ярилаа. Зарчмын 3 асуулт байна.

Нэгдүгээрт, Их Хурлын даргаас асууя. Төсөв, төлөвлөгөө ярих болохоор бол манай Их Хурлын гишүүд чинь бүгд энд тэнд очоод л тойрог дээрээ ч ажиллаад л лоббидоод л янз бүр болж байгаад мөнгө тавиулах гээд төлөвлөгөөнд оруулах гээд дайрдаг. Гүйцэтгэлээ бид нар энэ Дэгийн тухай хуулийн 117.3-аа бариад бүх Байнгын хороонуудаараа хэлэлцүүлж баймаар байна. Хоёрхон Байнгын хороо руу хэлэлцсэн болоод орж ирээд энд боох гэж оролдож байгаа.

Ер нь цаашдаа энийгээ хэдүүлээ болих хэрэгтэй. Төсөв хүрэхгүй байна, хүрч байна гэж ярьдаг. Эдийн засаг тэлж байна гэж ярьдаг. ДНБ 7 мянган доллар руу хүрчихлээ гэж яриад байгаа боловч яг гадагшаа гараад иргэддээ, боловсролын, эрүүл мэндийн аж ахуйн нэгжүүдийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулзахаар тэд нарын амьдрал ахуйд нь орсон мөнгө нэг ч байхгүй. Энд ярихаараа л хамаг юм болоод байна гээд байгаа юм. Тэгээд тоогоороо гарч ирж байгаа юм. Тэгэхээр 1 дэх асуулт Их Хурлын дэд даргаас асууя.

Хоёр дахь асуулт, Ерөнхий сайдаас асууя. Энэ хяналт шалгалт чинь бүр давхардаад утгаа алдлаа бүр. Засгийн газар өөрөө өөрийгөө энэ хянаад ороод ирэх юм. Тэгээд өөрсдийнхөө ажлыг энэ тэргүүлэх чиглэл дээр 48.5 гэж байхад Үндэсний аудитын газар нь тэргүүлэх чиглэл дээр 20.9 хувь ажилласан байна гээд оруулаад ирдэг. Их Хурлын Тамгын газар дахиад хянадаг. Хангалтгүй байна гэдэг. Тэгээд энэ гурвынхаа зааг, ялгааг яах ёстой юм Учрал дарга та Ерөнхий сайд ер нь цаашдаа яах вэ? Энэ дээр та хариулаад өгчхөөрэй.

Үндэсний аудитын газраас жил болгон зөвлөмж гаргадаг. Зөвлөмжийг нь хэрэгжүүлдэггүй. Одоо яах вэ? Их Хуралд ажлаа тайлагнадаг Аудитын газар аа? Жил болгон л 50 хэдэн хүн ажиллаад байна, 50 хэдэн хүн ажиллаад байна, муу байна, муу байна л гээд байдаг, зөвлөмж өгөөд байдаг, зөвлөмж өгөөд байдаг нэмэр байхгүй. Та хэд маань юу гэж бодож байна? Тэгээд энэ 3 асуултдаа хариулт авчхаад тодруулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дэд даргаас юу асуусан гэсэн бэ? Уучлаарай. Саяын Тэр Байнгын хороон дээр ярьсан асуудалтай холбоотойгоор. Дэгийнхээ хуульд хэдүүлээ бас саналаа оруулаад ирэх л хэрэгтэй байна л даа. Тийм яах вэ наадах чинь Дэгийнх нь тухай хуульд хэдүүлээ саналаа л оруулах хэрэгтэй байна.

Саналаа оруулаад ирж болно. Тэгээд хэдүүлээ хэлэлцээд явчихъя. Учрал Ерөнхий сайд.

**Н.Учрал:** Төлөвлөлт, төсөвлөлт, хяналт, мониторинг гэдэг чинь ийм циклээр явах ёстой. Design, monitoring, evaluation гээд. Гэтэл энэ төлөвлөлт, төсөвлөлт 2 үнэхээр зөрүүтэй явж байгааг сая Очирбат гишүүн шүүмжилж байгаа юм. Энэ үнэн. 25 оны гүйцэтгэл өнөөдөр явж байна шүү дээ. Гэтэл энэ чинь 24 оны төлөвлөсөн төлөвлөгөө байхгүй юу. Тэгэхээр цаг үеэсээ шалтгаалаад өөрчлөгддөг. Ялангуяа энэ эдийн засгийн тоонууд ингээд өөрчлөгдөж байгаа. Бид хэт романтик аягүй гоё төлөвлөгөө гаргачихдаг. Тэгээд түүндээ хүрч чадахгүй. Мөрөөдлийн олон жагсаалттай. Тэгээд түүнийгээ гүйцэх гэж явсаар байгаад ийм байдалд хүрчихдэг.

Гэтэл энэ нь өөрөө энэ эдийн засгийн тоонууд дээр өөрчлөгдөөд байдаг, хангалттай нөөц байдаггүй. Тэгэхээр тухайн үед тийм учраас одоо энэ нөгөө хяналт хэрэгжих механизм буюу энэ мониторинг бодлогын баримт бичгүүдийг үнэлж байгаа энэ агентлагийг төлөвлөж байгаа агентлагийнх нь дэргэд, яамных нь дэргэд авчраад ажиллаж байгаа. Дээрээс нь яг таны хэлж байгаа энэ Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, аудит гээд энэ олон ийм хяналтууд хэн хяналт хийгээд байгаа нь ойлгомжгүй. Тэгэхээр би ажлаа эхнээсээ, анхнаасаа юу гэж ойлгож байсан бэ гэхээр төлөвлөлт, төсөвлөлт, хяналт, мониторинг яг ийм циклээр байх ёстой гэж үзэж байсан. Тэгээд таван жилийн чиглэлийг яг ийм индикаторууддаа тавьж та бүхнээр батлуулсан. Одоо би энийгээ хэрэгжүүлэх гэж байна. Тэгэхээр яг таны хэлдгээр би зовлон, жаргалыг нь үзсэн. Хаана ямар асуудал үүсээд байгааг нь бүрэн дүүрэн үзсэн хүн.

Тийм учраас Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Хяналт хэрэгжүүлэх газар, Аудит гэсэн энэ олон давхардсан хяналтуудыг нэг байр байранд нь аваачна, чиг үүрэг дээр нь оновчилно гэдгээ би бас танд хариуцлагатай хэлье.

Дээрээс нь тэр төрийн албаныхны би өчигдөр бас байр сууриа илэрхийлэхдээ хэлж байсан тэр тайлангаас чөлөөл. Хэрэгтэй, хэрэггүй бичиг цаас шиддэг байдлыг зогсооно. Зөвхөн зөвхөн нэг цахим систем дээр бүгд мэдээллүүдээ, үнэлгээгээ, мониторингуудаа, мэдээллүүдээ тавина. Тэгээд бүгдээрээ татаж авна. Сая Их Хурлын дарга байхад нөгөө энэ гишүүдэд бас нөгөө reel time-аар хардаг dashboard Тамгын газраас бид нар боловсруулж өгсөн.

Тэгэхээр та бүхэн ч гэсэн шууд тэрнээс мэдээллийг аваад орох болохоос биш хэдүүлээ энд бичиг шидээд бие биеийнхээ цагийг их үрээд байна л даа. Угаасаа үзчих юмыг чинь л энд статистик тоо ярьдаг. Тэгээд нэг тайлбар тавьдаг. Тэр гишүүдэд ч тэр нь сонирхолтой биш, нөгөө хүмүүс ч нөгөө ярьдаг юмаа ярьдаг. Тийм учраас бол миний хувьд өнгөрсөн хугацаанд Оюун-Эрдэнийн Засгийн газар, Занданшатар даргын Засгийн газар гээд бүх Засгийн газарт ажиллаж байсан учраас зовлонгоо ойлгож байгаа. Тэр танилцаад байх юм байхгүй. Тэгээд шууд шийдэх юм аа ажлаа шийдээд явъя л гэж бодож байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон.

**С.Магнайсүрэн:** Гишүүний асуултад бас хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Төрийн аудитын тухай хуулийн дагуу бид асуудлыг авч үзээд

үнэлээд тэгээд зөвлөмж, албан шаардлага, холбогдох шийдлүүдээ өгдөг. 2023, 2024 оны өгсөн зөвлөмжийн хэрэгжилтээс үзэх юм бол харьцангуй бас ахисан, хэрэгжилт нь ахисан ийм үнэлгээ байгаа. Тухайлах юм бол 24 онд бид нар 18 төсвийн ерөнхийлөн захирагчид зөвлөмж өгч байсан. 1 яаманд албан шаардлага өгч байсан байдаг. Энэний биелэлт өнөөдөр дунджаар 80.2 хувийн ийм биелэлттэй байгаа. 25 оных дээр бид нийтдээ 7 зөвлөмж өгсөн.

Аудитын хуулийн зааснаар бид нар зөвлөмжийнхөө хэрэгжилтийг завсрын болоод дараагийн давтан, тэгээд ирэх жилийнхээ.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон сунгая.

**С.Магнайсүрэн:** Хуулийн дагуу аудитын шийдвэр заавал хэрэгжих ийм хууль зүйн баталгаатай. Энэ утгаараа хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдол дараагийн шатад буюу арга хэмжээ авах хүртэл ингэж явах ийм хуулийн боломж байгаа учраас аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах тал дээр бид нар тал бүрдээ анхаараад ажиллахад энэ үнэлгээний биелэлт сайжрах ийм бүрэн бололцоотой байна гэж харж байгаа. Харьцангуй 23, 24 онтой харьцуулахад харьцангуй өссөн ийм дүн харагдаж байгаа. Бид цаашдаа энэ дээр анхаараад ажиллах ийм бүрэн бололцоо байгаа гэж үзэж байгаа.

Тийм учраас бид нар төсвийн ерөнхийлөн захирагчид болоод бусад захирагч нартай энэ тал дээр хамтарч ажиллах бололцоо байгаа. Энэ тал хөшүүргээ ашиглаж ингэж ажиллана гэж ингэж бодож байгаа. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Баярлалаа. Ерөнхий сайдаас тодорхой үг сонсчихлоо. Энэ хяналт, шалгалтын давхардлыг байхгүй болгох хэрэгтэй. Их Хурлын Тамгын газраас хянаад байдаг. Засгийн газар өөрөө өөрийгөө хянаад байдаг, аудит хянаад байдаг. Хэнд нь итгэхээ больчихсон шүү. 3 өөр тоо явдаг. Их Хурлын гишүүдийг төөрөгдүүлдэг, ард иргэдийг төөрөгдүүлдэг, юунд нь итгэхээ мэдэхээ больдог. Тэгсэн мөртөө индэр дээрээс ярихаараа тоонд итгэ гээд байдаг. Тэгээд 3 өөр тоо яваад байхад тэгээд яах юм? Тэгээд энийг цэгцэлнэ гэж байгаад нь маш их баярлаж байна.

Аудитын газар зарчимч бас ажиллаж байна. Өшөө илүү зарчимтай ажиллаарай. Энэ асуудлуудыг ил тод гаргаж ирээрэй. Тануус тэгээд нийцлийн аудитын тайлан гаргаж ирэхдээ бас дутуу юмнууд гаргаад байдаг шүү. Бүгдийг нь ил болгон сайхан тавиарай. Их Хурлын гишүүд парламентын нүд, чих хяналт шүү. Тэрийгээ хэрэгжүүлээрэй.

Тэгээд дараа жил энэ Дэгийн тухай хуулийн 117.3-аар бүх Байнгын хороонууд энэ гүйцэтгэлээ хянаж баймаар байна. Төлөвлөсөн юм бас.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Ер нь Дэгийн тухай хуулийн 117-гоо бас эргэж хармаар юм байна даа. Тэгээд Очирбат гишүүний гаргасан саналын дагуу Улсын Их Хурлын дэргэдэх аудит дээрээ бид нар ер нь ач холбогдлоо өгч, аудитын гарсан дүгнэлт

хэрэгждэг байх, хариуцлага тооцдог байх энэ зарчмаа л энэ дээр тодруулах хэрэгтэй юм байна шүү. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 4 жилийн хөтөлбөрийн маань талдаа ороод хэлэлцэж байна. Тэгэхээр өөрөөр хэлбэл өнгөрсөн 2 жилийн хугацаанд 2 Ерөнхий сайд солигдсон. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд, Занданшатар гэсэн 2 Ерөнхий сайд болон кабинетын сайд нар энэ ажлуудыг хийжээ. Тэгээд үр дүн нь үнэхээр хангалтгүй байна. 2 жилийн хугацаанд 62 их наяд төгрөг зарсан байна. Тэгээд энэ үзүүлэлтүүдийг нь хэмжих гээд 16 ийм 3 бодлогын үзүүлэлт, 16 үзүүлэлт тавьсан.

Гэтэл одоо эндээс хэмжих бололцоотой 13-ыг нь гээд үзээд байхад энэ 13-аас 9 нь бүгдээр ухарсан байна. Өөрөөр хэлбэл, 30 хувийн үзүүлэлттэй. Тэгээд одоо яг ам ажил хоёр нь алд дэлэм зөрүүтэй байдгийн жишээ энэ байна. Яг Ерөнхий сайд болохдоо ч юм уу сайд болохдоо гоё гоё юм ярьдаг. Үр дүнд ерөөсөө суурилдаггүй. Гарч ирэнгүүтээ шинэ юм ярьдаг, зохиодог. Ерөөсөө энэ буцаагаад яг энэ дээр чинь уул нь юу хийхийг нь биччихсэн байгаа байхгүй юу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр.

Тэгэхээр үр дүн чиглээгүй ийм дүр зургууд харагдаж байна. Энэ 3 бодлогын жишээг авч үзье. Бүгдээрээ дордчихсон. Хүний хөгжлийн бодлого гэж байгаа юм. Энэ хүний хөгжлийн бодлого дээр дундаж наслалтыг 1 насаар багасгачихсан байна. 72.7-гоос 71.7 бууруулчихсан байна. Тоо худлаа хэлдэггүй гэдэг. Нялхсын эндэгдэл 1000 төрөлтөд 12.3 байсныг 9 болгон ингэж зорилт тавьсан. Зорилт нь дүүрч. Ядаж байгаа тэр суурь түвшнээсээ дээрдүүлэхгүй юм гэхэд тэр түвшинд нь хадгалж болдог болохоор. Тэгтэл их мөнгө зарсан мөртөө, 62 их наяд төгрөгийг зарсан мөртөө нялхсын эндэгдэл одоо ингээд 13.7 болчихсон байна. Нэмэгдчихсэн байна.

Тэгэхээр энэ хүний хөгжлийн үзүүлэлт ч энийг дагаад унаж байна. Боловсролын хүртээмж, хүлээгдэж буй суралцах жилийн тоо 14.5 байсныг 13.6 болсон байна. Нийслэлийн түгжрэл утаатай холбоотой асуудал нийт төлөвлөсөн ажлынхаа 30 хувийг хийчихсэн мөртөө үр дүн нь 0. түгжрэл оргил ачааллын үед замын хөдөлгөөний дундаж хурд 12 байсныг 16 болно гэж зорьсон. Зорилтот түвшинд хүрч энийг 11 болгож бууруулсан байна. Бизнесийн эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ, эдийн засагт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ гэдэг эдийн засгийн бодлогын заалт өөр энэ ухарсан байна. 23 онд 76.2 байсныг 77 болгон зорилт дүүрч энийг ухрааж 72.5 болгосон байна. Хүний эрхийг дээдэлсэн энэ засаглалын бодлого явуулна гэж байна. Энэ дотор байгаа авлигын индекс чинь ухарсан байна. 118-аас 114 болж энэ үзүүлэлтээр өгсөн тоогоор. Ёс зүйн үзүүлэлт чинь 10-ыг 35 болгоно гэсэн бол 5 болсон байна.

Тэгээд энэ ямар бид нар энэ улсыг хөгжүүлэх гэж байгаа хүмүүс юм уу энэ сайд дарга нар чинь, Ерөнхий сайд нар, энэ сайд нар чинь энэ танхим чинь яг аль улсын төлөө юуны төлөө ажиллаад байдаг юм? Энэ хөгжлийн бодлого, хүний төлөө, хүний бодлого чинь, эдийн засгийн бодлого чинь, засаглалын бодлого чинь бүгд ухарчихсан байна шүү дээ. Тэгээд нэг л их гоё юм ярьсан хүмүүс. Байж байгаа үр дүн нь ерөөсөө энэ. Угсарсан машин чинь урагшаа явдаг биш хойшоо ухардаг гоё гоё жолооч солиод л байдаг, бензин үүрээд л байдаг, урагшаа биш хойшоо явдаг ийм машин болчихсон байна.

Тэгээд нийслэлтэй холбоотой би зүгээр ганц, нэг асуулт байна. Энэ өмнөх сайд нартай холбоотой учраас Ерөнхий сайдад цаашдаа энэ үр дүнд суурилсан олон юм санаачилдаг биш яг энэ тов тодорхой энэ даалгавраа хэрэгжүүлдэг ийм чиглэл рүү хандуулсан үйл ажиллагаагаа ч гэсэн, сайд нараа ч гэсэн энэ чиглэл рүү нь шахаж ажиллуулаарай гэж хэлмээр байна.

Нийслэлээс нэг асуулт байна. Төвлөрлийг сааруулж түгжрэлийг бууруулах арга хэмжээний 30 хувиа хэрэгжүүлчихсэн байна. Гэтэл үр дүн нь 0. Тэгэхээр энэ чинь өөрөөр хэлбэл байгаа онохгүй байгаа юм биш үү? Одоо саяын тэр Туулын хурдны зам гээд байгаа ч гэсэн бууруулна гэж та бид бодоод байгаа боловч бодит байдалд чинь нийцэхгүй байна шүү дээ. Тэгээд энэ дээр тайлбар хэлээч?

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд, Учрал Ерөнхий сайд.

**Н.Учрал:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгээд Энхтүвшин гишүүн бол манай энэ ажлын хэсгийнхэн бол 24 оны төлөвлөгөөний гүйцэтгэл яриад байна шүү дээ. Тэгээд нэг ёсондоо төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл чинь өөрөө хоорондоо уялдаагүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ хүслийн олон жагсаалтуудаа үнэнээ хэлээд боливол яасан юм бэ? Би тэгж л бодоод байна. Тэрнээс биш яг энэ төлөвлөлтийн дагуу ирэх жил ороод ирэх юм бол Энхтүвшин гишүүн ээ дахиад л нөгөө хангалтгүй гээд л сууж байна. Энэ чинь биелэх боломжгүй мөрөөдлөө хийх жагсаалт хийчхээд тэгээд бие биеэ хуураад ингээд амьдраад байх нь утгагүй байх. Тэгэхээр бид шаардлагатай бол 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ ч гэсэн чадахгүй зүйлээ манай салбарын яамнууд үнэнээ хэлээд хойшлуулахыг нь хойшлуулах хэрэгтэй. Олон мега төслүүдээ эрэмбийг нь хойшлуулах хэрэгтэй. Худлаа өнөө, маргаашаа яая гэж юун тэр том том юм ярих. Тийм л байдалтай байгаа шүү дээ.

Тийм учраас зүгээр эхний ажил бол би энэ олон төлөвлөлтүүд дээр ажиллая. 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээр ажиллая. Ирэх жилийн төлөвлөгөөг амьдралтай хийе. Тэр тэгтэл их гоё сонсогдохгүй байж магадгүй. Гэхдээ тухайн батлагдах үедээ гоё сонсогдоод ирэх жил нь биелээгүй байж байснаас тэгээд үнэнээ ярьчихсан нь дээр гэж ойлгож байна.

Дээрээс нь энэ манай энэ төрийн албан хаагч нарыг та бүхнээс би энийг хүсэхэд бие биеэ ингэж хуурч манай төрийн албаныхан үндсэн ажлаа хийх ямар ч цаггүй. Одоо та нар хар эд нар юу хийж байна гээч? Ажлын хэсэг сууж байна ингээд л байж байна. Байнгын хороо, Их Хурлын гишүүд, Их Хурлын танхим, түмэн ажлын хэсэг, түмэн зөвлөл. Тэгээд ажлын бус цагаараа тайлан бичнэ. Тэгээд тайлангаа дээшээ явуулна. Дээр нь уншдаг хүн байхгүй. Одоо ингээд л ийм тайлан бичсэн хүмүүсээр л дүүрчихлээ.

Тийм учраас одоо бол бүгдээрээ энэ тийм бие биеийнхээ тайланг сонсдог ийм ийм ажлуудыг илүү багасгаж зүгээр ажил руугаа орох хэрэгтэй. Гудамж талбай дээр гарч ард түмний амьдрал дунд орж ажиллахгүй бол ингээд л бие биеэ сонсоод л ямар байна ямар байна гээд ингэсээр байтал. Тийм учраас Их Хурлын гишүүд ч тэр, Засгийн газрын гишүүд ч тэр dashboard-д дээр бүх тайлан, мэдээлэл, тэр geel time-аар бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бүх зүйлийг харж байгаа. Ингээд харж байхад заавал тэрийг цаасаар бичүүлж бие биеэ цаг заваа үрэх

хэрэггүй. Тийм учраас энэ тайлангаас чөлөөлж би та нарыг ажил хийнэ гэж л би Төрийн нарийнуудыг цаашдаа шахна. Тийм учраас энэ тоон үзүүлэлтийг ахиулахад би бодитой төлөвлөгөө хийж ажиллана гэдгийг хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нийслэл, Нийслэлээс хүн байна уу? Түрүүн би зарласан шүү дээ ажлын хэсэг. Энэ Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө Учрал гишүүн, Учрал сайд санаж байгаа бол би ажлын хэсгийг нь ахлаад та бас Хэрэг эрхлэх дээр байсан байх аа, дэд ажлын хэсэг дээр гээд ажилласан. Энэ Засгийн газраас оруулж ирсэн үйл ажиллагааны төлөвлөгөө дээр ямар ч байсан 30 хувийг Улсын Их Хурлын гишүүд нэмсэн шүү дээ тийм биз? Өөрөөр хэлбэл, Засгийн газрын санал болгосон үйл ажиллагааны хөтөлбөрийг эвдсэн гэсэн үг байхгүй юу даа. Тэгэхээр бас Ерөнхий сайд энэ дээр бас дүгнэлт хийгээд шаардлагатай бол бас оруулж ирж тодотгодог юм уу яадаг юм? Иймэрхүү зүйл бас байж болох. Яагаад гэхээр бид өөрсдөө бас энд нэмсэн л асуудал байгаа шүү дээ.

Тодруулах уу? Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Нийслэл Их Хурал дээр ирэхээ больчихсон юм байна, гишүүдийг гараад ир үзье гээд байдаг байсан. Тэгээд одоо энэ байдал Их Хурлыг ер нь бол ямар түвшинд үзэж байгаа нь ойлгомжтой болж байна. Асуулт асуухаар байхгүй. Дарга нар нь өөрсдөө би ирэхгүй Тэнд очиж юу ярьдаг юм гэдэг. Тэгээд ийм байж болохгүй. Тэр орж ирж байгаа мөн үү үгүй юу? Тэгээд энд юутай холбогдуулж ер нь улс төрийн намын мөрийн хөтөлбөр болоод сонгуулийн мөрийн хөтөлбөр болдог энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болж явах ёстой. Энэ өөрчлөгддөггүй бас ер нь хуулиуд дээр өөрчлөлт оруулахгүй бол түрүүчийн зовлон бас гишүүд юм нэмдэг. Тэр нь буцаад хэрэгжүүлэх боломжгүй асуудлууд бий болдог. Энийг бас хуулийн төсөл санаачилъя гэж бодож байгаа. Дээр нь энэ зарим нэг шаардлагагүй жилийн төлөвлөгөө эд нарыг болих хэрэгтэй санагдаж байгаа. Энэ төлөвлөгөө, төсөвтэй давхардсан. Таван жилийн төлөвлөгөөг ч гэсэн бас аягүй тодорхой болгож өгөхгүй бол засаг солигд.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Нийслэлийн Засаг даргын орлогч орж ирсэн үү? Асуулт сонссон уу? Учрал сайд.

**Н.Учрал:** Энэ тодотгол хийхэд жилийн төлөвлөгөө өөрчлөхгүй байгаа чинь яг ийм асуудалд оруулаад байгаа шүү Засгийн газраар. Тэгээд би бол Ерөнхий сайдын хувьд би Төрийн нарийн бичгийн дарга нартаа хэлж байна цаашдаа тодотгол хийж байгаа бол жилийн төлөвлөгөөгөө өөрчил өө. Тэрнээс биш энэ чинь зөрөөд байна. Тодотгол хийнэ гэдэг чинь орлого буураад байна шүү дээ. Тийм учраас тодотгоод байна. Тийм учраас төлөвлөгөөнд чинь байгаа тэр мөрөөдлийн жагсаалтууд чинь бас л өөрчлөгдөх ёстой шүү дээ. Тэгээд эргээд ирэх жил нь оруулаад ирэхээр тодотгол хийгээд мөнгө нь хасагдсан юм чинь тэр төлөвлөлт яаж биелэх юм тийм биз дээ?

Энхтүвшин гишүүн асуулт асуугаад байна нийслэлийнхэн? Чи хаачаад ирж байгаа юм Даваадалай? Энхтүвшин гишүүний асуултад хариул. Одоо жоохон эмх замбараатай байна шүү. Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс шүү. Энэ чинь улс төрийн албан тушаалтан биз дээ хариул л даа. Хотын даргыг өөрийг нь дууд.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

**Т.Даваадалай:** Их Хурлын гишүүний асуултад хариулъя. Сая нойл орchoод ирсэн юм дарга. Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай. Улаанбаатар хотод 2025 оны гол зорилт түгжрэлийн эсрэг богино хэмжээний арга хэмжээ камержуулах, уулзваруудын нэвтрэх чадваруудыг сайжруулах арга хэмжээ хийсэн. Ийм учраас Улаанбаатар хотод 2026 оны 1 сарын 1-нээс 150 уулзвар дээр 2600 камерын хяналтыг хийж, зөрчил болон хувь хүний жолооч нараас гаргаж байгаа Улаанбаатар хотын энэ түгжрэлийн хэмжээг бууруулах богино хэмжээний төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан.

2026 оны 4 дүгээр сарын 1-ний байдлаар Улаанбаатар хотод зөрчил гаргасан 1 сая 271372 зөрчил дээр хариуцлага тооцож ажиллаж байгаа. Энэ нь тодорхой 70-н уулзваруудын нэвтрэх чадваруудыг 15 хувиар нэвтрэх чадварууд дээр сайжруулсан ийм камерын үзүүлэлтүүд ч гарч байгаа. Улаанбаатар хотын өнөөдөр VCR.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон 1 минут сунгая.

**Т.Даваадалай:** VCR үзүүлэлт 2.5-тай. Оргил цагийн ачаалал 16-20 цагийн үед 7-9 цагийн километр хурдтай 80.7км урт ийм түгжрэл үүсэж байгаа ийм үзүүлэлттэй байна. Өнөөдөр Улаанбаатар хотод 2.4 сая зорчилт 1287км урт замаар хэрэгжиж байна.

Дунд хугацааны бодлого болох трамвай, дүүжин тээврийн төслүүд амжилттай хэрэгжээд явж байгаа. Мөн урт хугацааны бодлого болгох метро төслийг бас нээлттэй тендер зарлаад хэрэгжүүлээд явж байна.

Улаанбаатар хотын Туулын авто зам мөн дунд хэмжээний бодлогод орж байгаа. Улаанбаатар хотын түгжрэлд 34 хувь хүртэл нөлөөлөх ийм ач холбогдолтой төсөл өнөөдөр эхлээд зураг, төслийн ажил дуусах үе шатдаа хэрэгжээд явж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхтүвшин гишүүн тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Яах вэ би гол нь энийг асуугаад байгаа юм. Арга хэмжээнийхээ 30 хувийг хийчхээд байгаа байхгүй юу. Гэтэл үзүүлэлт чинь буучхаад байгаа байхгүй юу. Суурь түвшин чинь 12 байсныг зорилт нь 16 гэж 25 онд болгоно гэсэн яах вэ зорилт нь дүүрч. Энэ чинь хийсэн арга хэмжээ чинь байгаа олохгүй байгаа байхгүй юу. Энэ оргил үеийн ачааллын замын дунд дундаж хурд чинь 11 болж буурчихсан байна. Энэ нь оройдоо 5.5 км цаг, өглөөдөө 11 км цаг ажлын өдөр, амралтын өдөр 8, 19 гээд үзүүлэлтүүд чинь буучхаад байгаа байхгүй.

Тэгэхээр миний асуугаад байгаа асуулт болохоор та хэд яах вэ камер хийж байна, зам нэмж байна. Байгаа онохгүй байгаа юм биш үү? Энэ үр дүн гарах ёстой байхгүй юу. Энэ үзүүлэлтүүд чинь буурах ёстой байхгүй юу. Тэрнээс биш ингээд буцаад энэ чинь сайжирдаггүй мууддаг юманд мөнгө зараад байгаа юм биш үү гэж. Тэгэхээр та хэдийн энэ үзүүлэлтүүдийг хэмжиж байгаа ач холбогдлуудыг энэ Туулын хурдны зам ч гэсэн ямар хураамжаар тооцож байгаа эд нарт тооцоход бас

амьдралд нийцгүй харагдаад байгаа байхгүй юу. Секунд нь 3 мянга.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**Т.Даваадалай:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Засаг дарга 1 дүгээр орлогч Даваадалай. 2025 онд үзүүлэлт болсон гол үзүүлэлт дээр нөлөөлсөн нь Улаанбаатар хотын автомашины импорт байсан. Өмнөх жилүүдийг харьцуулбал ойролцоогоор 30-35 мянган машин жил болгон Монгол Улсад Улаанбаатар хотод нэмэгддэг байсан бол 2025 онд 70 мянган машин импортлогдож орж ирж, өмнөх үеийнхээс 2.1 дахин нэмэгдсэн. Энэ нь бас дугаарын хязгаарлалт болон бусад зүйлүүдтэй холбогдож байгаа гэж дүгнэж байгаа. Ийм учраас бол автомашины импорт эрс 2025 онд нэмэгдсэнээс зарим үзүүлэлтүүд хүндэрсэн гэж харж байгаа. Харин камер болон богино хугацааны арга хэмжээнүүдээс уулзваруудын нэгтгэх чадвар сайжирч байгаа буюу замын хэмжээ машинтай харьцуулахад VCR хэмжээ 2.50-тай эргээд машинтайгаа замаа харьцуулахад үзүүлэлтүүд сайжирч байгаа гэж харагдаж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Оюунсайханы Алтангэрэл гишүүн.

**О.Алтангэрэл:** Өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайдыг томилогдоход их сайхан захиас хэлээд л мундаг улс орныхоо асуудалд санаа зовоод байсан гишүүдийн маань дийлэнх нь алга. Засгийн газар ердөө саяхан огцрох хүртэл ажлаа хийж байсан манай сайд нар алга. Нөгөө буцах эхнэрт үнээ тугал нийлэх хамаагүй гэдэг шиг өнөөдрөөс ингээд энэ ажил хамаагүй болж байгаа юм шиг байна. Бодвол Ерөнхий сайд таны кабинетад орчих гээд л таны нүдэнд өртчих гээд л завгүй их гүйлдэж байгаа юм байлгүй. Тэгээд байх ёстой газар нь уг нь энэ танхим. Өнгөрсөн хугацаанд хийсэн ажлынх нь гүйцэтгэлийг яриад сууж байхад ямар ч сэтгэлгүй юм, ямар ч хайхрамжгүй юм. Ингээд бүх сайдынх нь суудал онгорхой ингээд байж байгаад бас харамсаж байна. Та Ерөнхий сайдын хувьд бас энэ байдлыг бас харж байгаа байх гэж ингэж бодож байна.

Өнөөдөр гүйцэтгэлийн асуудал их чухал асуудал яриад байгаа юм. Нөгөө Байнгын хорооны хуралдаан, чуулганы хуралдаан дээр энэ зүйлийг хийгээрэй, энийг анхаараарай гээд захиад гээд захиасыг чинь яаж биелүүлсэн юм, хэдэн хувьтай байсан юм гэдгийг өнөөдөр уг нь ярих гээд байгаа юм шүү дээ. Тэгээд ингээд байхгүй.

Гэтэл өнгөрсөн жилүүдэд манай улсын хувьд тулгамдсан асуудлууд зөндөө байна лээ. Би нэг зүйл дээр нь бас онцгойлон ач холбогдол өгч яримаар байна. Манай улс авлигын индексээр ухарлаа. Манай Ерөнхий сайдыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан хамтарсан Засгийн газрын үед бид нар сайн ч, муу ч энэ авлигын индекс 7 байраар урагшилсан юм. Сая тэгээд өчнөөн байраар ухарчихлаа л даа. Тэгээд өнгөрсөн хугацаанд энэ авлигын индексийг яаж урагшлуулах вэ гэдэг дээр зөвхөн энэ авлигын гэмт хэрэгтэй тэмцэхээс гадна авлигатай тэмцэх хууль, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох шаардлагатай юм байна гэж үзээд олон төрлийн хууль тогтоомж санаачилж байсан.

Үүнээс гадна “Транспэрэнси Интернэшнл” тэргүүтэй байгууллагуудтай байгууллагуудтай яаж хамтарч ажиллах вэ гэдэг дээр бид нар төлөвлөгөө гараад явж байсан. Харамсалтай нь өнгөрсөн онд бас манай Хууль зүй, дотоод хэргийн салбарт 3 сайд солигдоод энэ үйл ажиллагаа маань нэлээн замхрах шиг боллоо. Ер нь бидний энэ том асуудал энэ авлигатай тэмцэх тэмцэл байнга уриа лоозон болгоод байгаа зүйл маань бол нэг илтгэл, нэг сайхан пресентэйшн, уриа лоозон, нижигнэсэн сайхан алга ташилт энэ юмаар урагшилдаггүй эд л дээ. Яг бодлого боловсруулж сайн чимхлүүр ингэж ажиллаж байж урагшилдаг эд.

Харин би Учрал Ерөнхий сайдыг энэ авлигатай хийх тэмцлийн гол үндэс болоод байгаа гаднын байгууллагуудын тэр зөвлөөд байгаа хууль бус хөрөнгөтэй холбоотой асуудал дээр ахиц дэвшил гаргана, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах нөхөн төлүүлэх тухай хуулийг хэлэлцэнэ, дэмжинэ гэж байгаа байр суурь дээр нь талархалтай хандаж байгаа юм. Энэ чуулганы танхимаас албан ёсоор бас үүнийгээ хэлье.

Тэгэхээр энэ өнгөрсөн жил ингээд авлигын индексийн хувьд бид нар гүйцэтгэл дээр ухарсан. Ингээд ийм таагүй үр дүнтэй байлаа. Тэгээд энэ дээр бол энэ кабинетыг цааш авч явах Монгол Улсын Засгийн газрыг толгойлж явах Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий Засгийн газрыг тэргүүлж байгаа хүний хувьд энэ гүйцэтгэлийн үнэлгээ энэ байдал дээр ямар дүгнэлт хийж байгаа вэ Учрал Ерөнхий сайд аа? Цаашаа ямар арга хэмжээ авч ажиллая гэсэн ийм бодолтой байгаа вэ гэсэн ийм асуулт.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал Ерөнхий сайд.

**Н.Учрал:** Авлигын төсөөллийн индекс 10 байраар ухарсан байгаа дээр бид нар бодитой дүгнэлт хийх ёстой. Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй. Тийм ч учраас нийгмийн энэ хүсэмжлэл болоод байгаа энэ авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааг, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг Засгийн газар манлайлж дэмжиж ажиллах ёстой. Бид бол иргэдтэй бас уулзалтуудыг хийсэн. Алтангэрэл гишүүн бас оролцож байсан. Хангайн бүсүүдээр уулзалт хийхэд иргэдийн зүгээс энэ авлигатай тэмцэх бодитой үйл ажиллагаа явуулаач ээ, та нар авлигын төсөөллийн индексээр 10 байр хойшилчихоод байна гэдгийг хэлээд байгаа.

“Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас бид нар чинь 182 орноос 124 дүгээр байр жагсчхаад 10 байр хойшилчихоод байна шүү дээ. Тэгэхээр энэ “Транспэрэнси Интернэшнл” байгууллага бол манай улсад зөвлөмж өгөхдөө ял завшиж байна, хууль хэрэгжилтгүй байна, эрх зүйн орчноо боловсронгуй болго гэдэг зөвлөмж өгсөн. Тэгэхээр Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын үед Алтангэрэл сайд Хууль зүйн сайд байсан. Бид энэ хөрөнгө хураах хуулийг тухайн үед бас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байсан. Тэгээд би Их Хурлын даргаар ажиллаж байхдаа энэ хөрөнгө хураах энэ хуулийг батлан гаргах нь бас зүйтэй. Гэхдээ энэ хуулийг боловсруулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай уялдуулан өөрчлөх бас шаардлагатай гэдэг бас хуульчдын зөвлөгөөнүүд байдаг.

Тийм учраас Засгийн газрын зүгээс Алтангэрэл гишүүнтэй энэ хуулийн санаачлагчийн хувьд бас ярилцаж байгаад бид нар энэ хууль дээр Эрүүгийн хэрэг

хянан шийдвэрлэх тэр процессын хуультай нь уялдуулаад магадгүй авлигын эсрэг Авлигын хууль дээр нь бас тодорхой бүлэг заалтуудыг оруулаад Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй. Тэгж байж цаашаа бодитой энэ гэмт хэрэгтэй тэмцэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа өрнөнө. Ял завших энэ байдал арилна. Нийтийн албан тушаалтнуудын асуудлыг ярьж байна шүү дээ. Тэгээд иргэний журмаар энэ асуудлыг шийдэх.

Хоёрт, мэдээж Хууль зүйн яаман дээр боловсруулагдчихсан байгаа Шүгэл үлээгч хамгаалах хууль байна. Дээрээс нь Уянгаа гишүүн D-Parliament дээр тавьчихсан байгаа олборлох салбарын ил тод байдлын хууль байна. Ингээд энэ уул уурхайн салбарын ил тод байдлын санаачилга дэмжээд явбал бид энэ индекст урагшилна. Энэ индекст урагшилж байгаа чинь тийм байр урагшлаад байгаадаа биш үүний чинь цаана хөрөнгө оруулалт сайжирдаг. Үүний чинь цаана бусад индексүүдэд эерэг эффект өгдөг. Тийм учраас Алтангэрэл гишүүнийг бас энд хамтарч ажиллаж энэ хууль, эрх зүйн орчиндоо дэвшил гаргахыг би бас таныг урьж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар Улсын Их Хурал жил бүрийн 4 сарын 1-ний дотор энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ гээд хуультай. Тэгээд өнөөдөр дотроо хэлэлцэж дуусгахгүй бол бас хууль зөрчигдөх гээд байгаа юм.

Гэтэл өнөөдрийнх нь цаг хугацааны хувьд бас яг ингээд 5 дахь өдөр Засгийн газар, Ерөнхий сайд огцорчхоод Засгийн газрын тухай хуулиараа Ерөнхий сайд нь огцрохоор Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорно гэсэн ийм хуулийн заалттай. Тэгэхээр энэ сайд нар бүрэн эрхийн хугацаа дуусчхаад байгаа юм. Тэгээд өнөөдөр их сэтгэлгүйдээ орж ирэхгүй биш сайд нар ингээд огцорчихсон учраас хариулахад бас хэцүү байгаа юм. Хариулж болохгүй болчихоод байгаа юм. Тэгээд ийм бас хуулийн ийм асуудал үүсчхээд байна. Цаг хугацааны хувьд үүсчхээд байгаа юм.

Тэгэхээр би Учрал сайдад юу хэлэх гэж байна вэ гэхээр бас 5 дахь өдрөөс хойш яамнууд эзэнгүй байгаа гэж ойлгож болно. Сайдгүй. Амьдрал баян өнөөдрийг хүртэл 3 өдөр, 4 өдөр болж байна. Ахиад цаашдаа хэзээ Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээр болох юм? Энэ хугацаанд бас асуудал гарах вий. Яамнуудыг үүрэгжүүлж, шийдвэр гаргаж, эзэнтэй байлгах, хариуцлагатай байлгах ажил сулруулахгүй байх ийм чиглэлээр бас тодорхой үүрэг, чиглэл өгөхгүй бол энийг дагаад ажил цалгардаж байна шүү. Суларч байна шүү. Асуултад хариулах эзэн биегүй болчихоод байна шүү. Монгол төр 1 мөч, 1 хором бүрд тасралтгүй Монгол төрийн ажил тасралтгүй явах ёстой. 1 хором, мөч бүрд эзэнтэй байх ёстой. Тэгээд ямар ч гэсэн Монгол Улсын Ерөнхий сайд томилогдчихсон байгаа. Бүрэн эрх нь хэрэгж хэрэгжээд эхэлчихсэн. Энэ яамнууд чинь эзэнгүй байна. Тийм учраас энэ дээрээ бас яамнууддаа эзэн биежүүлж, хариуцлагажуулж, албан даалгавар гаргадаг юм уу. Тодорхой шийдвэр гаргаж ингэж ажиллахгүй бол бүх шатад ажил цалгардсан байна гэдгийг нэгд анхаарахгүй болохгүй дээ.

Хоёрт энэ цаглаврын хугацаанууд байгаа юм. Ингээд Засгийн газар 2 сарын 1-ний дотор аудитын байгууллагад энэ гүйцэтгэлийн тайлангуудын биелэлтийг

хүргүүлэх учиртай. Гэтэл 2 сарын 1-нийх нь дотор болохоор бүх тайлан, балансүүд гараагүй байж байдаг. Гараагүй байж байдаг нэгд.

Хоёрт, олон ийм бодлогын баримт бичгүүд байна. Улсын таван жилийн хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан гээд 4 жилд 4 тайлан гаргаж байгаа. Энэ бүх бодлогын баримт бичгүүд, биелэлт, тайлангууд нь дандаа адилхан. Бие биеэсээ сору-доод сору-доод хуулчхаж байгаа юм. Ингээд нөгөө бүх шатны төрийн захиргааны албан хаагчдад төрийн үйлчилгээнийхээ ажлыг иргэдэд үйлчлэх үйлчилгээний ажлаасаа илүүтэйгээр захиргааны цаасны ажилдаа дарагдаад байгаа чинь энэ байхгүй юу.

Тийм учраас би ямар санал хэлэх гэж байгаа вэ гэхээр бас одоо яг энэ цаг үед Хяналт шалгалтын тухай хууль, Дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуулийн төслүүд боловсрогдоод явж байгаа энэ цаг үед бас цаашдаа энэ 4 жилд 4 тайлан гаргадгийг, 3 адилхан тайланг 4 удаа гаргадгийг больж, ядаж 2 жилд 1 удаа тайлан гаргаад бүрэн эрхийн хугацаа өнгөрөөд 2 жилийн дотор явцыг нь үнэлж дүгнэж, дараа нь эцсийн байдлаар 4 дэх жилд нь үнэлгээг нь үздэг ийм байдлаар 4 тайлан гаргадгийг нь 2 тайлан гаргадаг болж, ядаж энэ тайлангуудыг цөөлөх асуудлыг цаашдаа энэ хууль юмандаа өөрчлөлт оруулаад явбал яасан юм бэ? Яасан юм? Тэгэхгүй бол баахан адилхан тайлангуудыг баахан адилхан сору-дож гаргадаг, Хэрэг эрхлэх газар нь яамнудаасаа нэхдэг, яам нь агентлагаасаа нэхдэг, агентлаг нь аймаг, нийслэлээсээ нэхдэг, аймаг, нийслэл нь сум, дүүргээсээ нэхдэг. Ингээд л ерөөсөө энэ тайлангаас тайлан. Энэнээс гадна баахан үндэсний хөтөлбөрүүдийн тайланг гаргадаг. Тийм учраас энэ нөгөө төрийн албан хаагчдыг тайлангаас.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүн, Учрал сайд.

**Н.Учрал:** Сандаг-Очир гишүүн ажлын хэсгийг нь ахлаад Их Хурлын тухай хууль түүнийг дагалдаад Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж дууссан байгаа. Энэ хууль дээр төрийн албан хаагчаас 1 тайланг 1 л удаа нэхнэ. Өөр төрлийн хэлбэрээр нэхэхийг хориглох гэж байгаа. Төрийн албаны хуульд энэ үгийг бичиж өгөхгүй бол нөгөө хуулиа л хэрэглэдэг байхгүй юу төрийн албан хаагч нар чинь. Тэгэхээр бид нар бас энийг хэдэн төрийн албан хаагчаа хайрламаар байгаа юм. Энэ төрийн албан хаагч нар нээрээ үнэхээр нуруугаа авхуулчихна шүү. Монгол төрд ажиллах залуучууд ховордлоо. Тэгээд ингээд бүх юм болохгүй юм шиг төрийн алба руугаа дайрдаг давшдаг. Энд чинь болж байгаа бүтэж байгаа маш олон сайн мэргэжилтнүүд байна. Тэгэхээр би Ерөнхий сайдын хувьд төрийн албан хаагч нарыг хамгаална. Төрд тангаргаа өргөсөн төрийн албан хаагч нарыг хамгаална.

Дээрээс нь ажлын бус цагаар ажиллуулдаг чиг үүргийнх нь биш ажлыг хийлгэдэг энэ хүмүүс чинь ер нь бараг 40 хувь бараг өөрийнхөө үндсэн чиг үүргээс өөр ажил хийж байна шүү дээ. Тэгээд орой, шөнө дөл хүртэл тайлан бичиж байна. Төрийн албан хаагч нар жилд зөвхөн төлөвлөгөөт 37 тайлан гаргаж байна. Төлөвлөгөөт. Төлөвлөгөөт бус дийлдэхгүй шүү дээ. Бүх шатны дарга нар юм илгээ илгээ гээд ингээд тэгээд энэ хүмүүс чинь үндсэн ажлаа хийж чадахгүй ийм байдалтай байна. Тийм учраас энэ хуулийг гаргаж өгөхөд анхаараасай гэж би Сандаг-Очир гишүүнээс хүсэж байна. Засгийн газар “The once-only” гэдэг зарчим

хэрэгжүүлнэ гээд би өчигдөр Ерөнхий сайдын илтгэл дээрээ хэлсэн. 1 тайланг би 1 л шаардана. Ажлын бус цагаар ажиллахыг хориглох хэрэгтэй. Хагас, бүтэн сайнаар хүмүүст дайчилдгаа болих хэрэгтэй. Ажлын цагаар ажлаа хариуцлагатай хий. Тэгээд чадахгүй бол ингээд дараа дараагийнхаа арга хэмжээнүүдийг аваад л явдаг л болъё л доо. Тийм биз дээ? Тийм учраас ийм саналтай байгаа. Тэгэхээр энэ тайлангаас би чөлөөлнө өө.

Дээрээс нь төрийн албанд 2400 орчим сул орон тоо байгаа юм байна лээ. Энийг би чөлөөлнө өө. Яамнуудын дэргэд байгаа би хөгжлийн төвүүдийг үе шаттай буулгана. Мэргэжлийн холбооны хуулийг нөгөө Цэцийн дүгнэлт ирчихсэн байгаа. Тэгээд бүртгэлийг нь тэр Хууль зүйн яаман дээр аваачиж байгаад бүртгэлийг нь хийгээд мэргэжлийн холбоонуудад шилжүүлнэ. Бүтээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн хэмнэлтийн хуулийг бүтээмжийн хууль болгох хэрэгтэй. Бүтээмжээрээ л ярина. Ингээд явахгүй бол болохгүй нь.

Тийм учраас таны бас саналыг би ойлгож байна. Одоо хурдан хугацаанд сайд нараа томилоод ажилдаа орох хэрэгтэй байна. Тэгээд Засгийн газар бол сайд нараа орвол танилцуулаад тэгээд Их Хуралд танилцуулснаар тэгээд захирамж гаргаад явна. Одоо бол яам нийлүүлбэл дахиад сарын дараа тодотгол явах ийм эрсдэл байна. Тийм учраас Монгол төр тасралтгүй ажиллах ёстой.

**Ж.Бат-Эрдэнэ:** Отгоншарын Батнайрамдал.

**О.Батнайрамдал:** Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Энэ нэг зүйл дээр төвлөрч асуултаа асууя. Боловсролын яам бэлдээрэй. Хүний хөгжлийн бодлого тэр дундаа эрдэм боловсролтой Монгол хүн бодлогын хүрээнд биелэлт 82 хувьтай гэж гарчээ. Одоо бараг энэ дотор байгаа хамгийн өндөр хувь юм шиг байна. Энийг би яг энийг үзэж байгаа аав, ээж нараас асуумаар байгаа юм. Оюутан суралцагчдаас асуумаар байна. Та нарын эрдэм боловсролтой Монгол хүн бэлтгэж байгаа энэ хөтөлбөр 82 хувьтай биелсэн гэж та бүхэн үзэх үү? Бид бүхэн ингээд л анги танхимын хүртээмж ярьж байтал дэлхий даяараа боловсролын салбарын хиймэл оюун тэр чигээр нь өөрчиллөө шүү дээ. Өнөөдөр бид нар зүгээр ChatGPT-гээр төсөөлөөд байх шиг байна. Энэ оюутан, суралцагчдын боловсрол авах үйл процесс энэ систем тэр чигээрээ 2030 он гэхэд бид нарын танихгүй болтол өөрчлөгдөнө. Тэгээд бид нар яах вэ? Анги танхимынхаа суралцагчдын хүртээмж ярьсаар л байгаа. Ийм том өөрчлөлт явж байхад бид нар яах вэ тэр татвар төлөгчдийн мөнгийг захиран зарцуулсан дээрээ 82 хувьтай гээд л өөрсдийгөө онгиороогоод л явж байх шиг байна. Асуудлууд их байна тээ?

Боловсролын зээлийн сантай холбоотой асуулт асууна дахиад. 2025 онд 158.4 тэрбум төгрөгийг баталж өгсөн. Энэ бол тухайн үедээ түүхэн хэмжээний том төсөв. 158 тэрбум төгрөгийг бид нар хүүхэд, залуучууддаа боловсролын боломж олгож төсөвлөсөн парламентаас баталж өгсөн. 33.6 тэрбум нь эргэн төлөлтөөр явах байсан тээ? Энэ сэдвийг хангалттай улс төржүүлж олон нийтийн хараан дор авчирч өгсөн.

Тэгэхээр парламент энэ дээр Засгийн газарт маш том дэмжлэг болсон шүү. Энэ эргэн төлөлт сүүлийн 3 жилд 42 тэрбум болсон. Урьд өмнө нь бол жилд 2, 3-хан тэрбум эргэн төлөгддөг байсан. Хэн ч эргэн төлөлтийн ардаас хөөцөлддөггүй. Бүгдээрээ тэтгэлэг гээд ойлгочихсон. Энийг тухайн үедээ гаргаж ирснээс хойш 42

тэрбум эргэн төлөгдөж болдог юм байна. Энэ 42 тэрбум бол тухайн жилүүддээ дандаа хүүхдүүдэд боловсролын боломж болоод очсон. Монголбанканд зээлийн мэдээллийн санд мэдээлэл ялгаатай очдог байсан. Ардын хүүхдүүдийн мэдээлэл оччихоод дарга, цэрэг нарын хүүхдүүдийн мэдээлэл явдаггүй байсан шүү дээ. 10 хэдэн жил, 20 жил тэгж явж ирсэн. 14 мянган хүүхдийн мэдээлэл очсоноос хойш эргэн төлөлт огцом сайжирчээ.

Гэтэл одоо ямар асуудлууд над дээр гомдол болж ирж байна гэсэн чинь нөгөө Монголбанкны зээлийн мэдээллийн санд явж байгаа зарим хүүхдүүдийн мэдээлэл дундаасаа алдагдах. Ийм нэг жишээ л гаргаж ирэх юм бол би 154 мянган суралцагч аав, ээжтэй нь хамт гарна шүү дээ. Өнөөдөр бүгдээрээ ёс зүй ярьж байгаа. Татвар төлөгчдийн мөнгөнөөс хамгийн ёс зүйтэй хөрөнгө оруулалт боловсролын боломж байдаг юм шүү. Тэгэхээр энэ дээр хатуу ярина шүү. Монголбанк руу хүүхэд ялгахгүйгээр Зээлийн мэдээллийн санд бүгдээрээ очих ёстой. Энэ дээр хариулт авъя.

Энэ эргэн төлөлт сайжрахгүй бол 2026 оны төсөв дээр 145 тэрбум төгрөгийн эргэн төлөлтөөр боловсролын боломж болж очно шүү дээ. 145 тэрбум. Энийг энэ эргэн төлөлтийг хэрхэн хийхээр төлөвлөж байгаа вэ? Надад ирээд салдаггүй нэг гомдол байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний үр хүүхдүүд, татвар төлөгчдийн мөнгөнөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Боловсролын зээлийн сангаар дамжуулж буцалтгүй тусламжаар боловсролын боломж болж очдог. Дарга аа 1 минутаа сунгаад авчихъя тэгэх үү?

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 минут сунгая.

**О.Батнайрамдал:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын төл.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 минут сунгая.

**О.Батнайрамдал:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролтой хүн болохын төлөө илүү урт замыг туулдаг юм шүү дээ. Үеэс ирсэн асуултын хариу дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2025 онд ердөө 6-хан хүүхэд л авч 158 тэрбум төгрөгөөс 24 сая төгрөг л очсон байна. Өмнөх жил нь ерөөсөө 2-хон хүүхэд авч, 6-хан сая төгрөг. Аав, ээж нар нь хүртэл авч чадахгүй байна гээд надад хандаад. Сүүлдээ шүүхдээд явж байгаа юм. Ийм байлгамааргүй байгаа юм. Тэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд энэ чинь буцалтгүй тусламж болж очдог юм шүү дээ. Энэ дээр квот гэж байхгүй шүү. Шинэ журмаар квотгүй. Энийг хэл ам болголгүйгээр хэдэн хүүхдүүдэд яагаад өгчхөж болдоггүй юм бэ? Тэр хүүхдүүд энд сууж байгаа бүх хүнээс урт зам туулж боловсролтой болох гэж хичээж яваа шүү. Энэ дээр маш тодорхой хариулт авъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерын микрофон.

**Х.Батжаргал:** Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал. 3 асуулт асуулаа.

Эхний, таны хэлсэн хиймэл оюун дэлхий ертөнцийн энэ хувьсан өөрчлөгдөж байгаа нөхцөл байдал, түүний дагуу бас зохион байгуулалт бодлогын хариу арга

хэмжээний таны санаа зовж санал хэлж байгаатай бүрэн санал нэг байгаа. Тэр ч утгаараа багшлахуйгаас суралцахуйд чиглэсэн хиймэл оюунд багш нарыг нэн тэргүүнд бас ачааллаа, багш нарын ачааллыг бууруулах чиглэлээр бас “Google” компани, “Gemini” хиймэл оюунд суурилсан сургагч багш нарыг бэлдээд ялангуяа хүүхдүүдтэйгээ илүү их ажилладаг, хүүхдүүддээ зориулах цагийг нь нэмэгдүүлэх, цаастай буюу төлөвлөгөө, тайлантай харилцах энэ цаг хугацааг богиносгох чиглэлээр эхний ээлжид зохион байгуулалт хийж байгаа.

Хоёрдугаарт нь хиймэл оюунд чиглэсэн үндсэн суралцахуйд чиглэх энэ арга барил, технологийн энэ өөрчлөлтийн дагуу хөтөлбөрийн шинэчлэлийг бас хийж байгаа. Бага боловсролоос эхлээд компьютерын ухааны хичээлийг шинэчилсэн хөтөлбөрөөр оруулахаар бэлтгэл ажил хангагдаж байна.

Хоёрдугаарх, Боловсролын зээлийн сантай холбоотой асуудал яах аргагүй таны бас оролцоо, Боловсролын зээлийн сангийн манай албан хаагчидтай хамтран ажилласан энэ цаг хугацаанд бас эргэн төлөлтийн хувьд бас ахиц гарсан. 2025 онд 17.6 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэний 14.2 тэрбум нь дотоодын зээл байгаа юм. Үүнээс 2.2 тэрбум төгрөгийн зээл нь Зээлийн мэдээллийн санд Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нэмж оруулснаар, бүрдүүлснээр 2.2 тэрбум төлөгдсөн байгаа. Гадаад зээлээс 3.4 тэрбум төлөгдсөн байгаа.

2025 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 301 тэрбум төгрөгийн авлага байгаа. Дотоодынх бол 60 тэрбум. Гадаад зээлийнх 241 тэрбумын энэ авлага байгаа. Энэ авлагыг бас Монголбанкны зээлийн мэдээллийн энэ санд ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй байгаа. Завсар зайгаар таны хэлсэн санаа зовж байгаачлан өөрчлөлт орсон нь иргэн бас гомдол гаргаад, шүүхэд гомдол гаргаад шүүхийн шийдвэрийг биелүүлэх энэ хүрээнд Зээлийн мэдээллийн сангаас өөрчлөлт орсон ийм асуудал бас байгаа гэдгийг бас танд хэлье.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд Боловсролын зээлийн сангаас санхүүжээд ингээд суралцахад бид бүх талын үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэх бодлого баримталж байгаа. Гагцхүү бидэнд нэг зүйл хязгаарлаж байгаа. Тэр бол төсөв. Төсөв маань өөрөө хязгаарлагдмал. Квотгүй, хязгаарлалтгүйгээр хүсэлт болгоныг бол шийдвэрлэх бас туйлын хязгаарлагдмал нөхцөл байдал байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15.3 дээр ямарваа нэгэн шаардлага, шалгуур тухайлан тавилгүйгээр хүсэлт ирүүлсэн их, дээд сургуулиудын урилга авсан болгонд санхүүжилт олгох энэ боломж.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Бас нэг маш тодорхой асуулт асуучихъя. Боловсон зээлийн сангийн энэ угаасаа хэл ам дагуулдаг. Бид нар хэл ам дагуулж байгаад энийг эргэн төлүүлнэ. Парламентын зүгээс бүх төрлийн арга хэмжээг авч дахиж хөөцөлдөнө өө. Боловсон зээлийн сангийн захирлыг сая 12 сарын 30-нд чөлөөлсөн. Энд Боловсролын сайд туслахаа Боловсролын сангийн сангийн даргаар тавьсан уу? Туслах нь байсан хүн мөн үү? Та энд тийм, үгүй гэж байгаад хариулах хэрэгтэй байна. Боловсролын сайдад туслахаас нь өөр боловсон хүчин

олдсонгүй юу? Татвар төлөгчдийн 158 тэрбум төгрөгийн асуудал ярьж байгаа юм. Энэ бол хамгийн том сангуудын нэг шүү дээ.

Хоёрдугаарт, АТГ-аас танай яаманд удаа дараа 4 удаа шүү мэдэгдэл ирүүлсэн. Тэр яагаад шийдэгдэхгүй байгаа вэ? Маш тодорхой хариулчих.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**Х.Батжаргал:** Гишүүний асуултад нэмж тодруулъя. АТГ-аас ирүүлсэн албан бичигт нийт Боловсролын зээлийн сангийн зээлийн чөлөөлөлтөд оролцож гаргасан шийдвэрүүдийг Засгийн газрын 2 тогтоол, Засгийн газрын гишүүн, сайдын 17 тушаалаар нийт 1035 иргэний асуудал байдаг. Үүний 832-ыг хүчингүй болгож чөлөөлөхийг Боловсролын яам болоод Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт АТГ мөрдөгчийн дүгнэлтээр ирүүлсэн байгаа. Бид энийг бас судалж үзсэн. Энд 832 энэ алба чөлөөлөгдсөн иргэний 815-аас дээш жил Боловсролын зээлийн сантай хийсэн гэрээнийхээ үүргийг биелүүлсэн гэж үзээд 5-аас дээс жил төрийн албанд ажиллаад ингээд гэрээний биелэлт хангагдсан гэсэн ийм дүгнэлттэй байдаг. 10 иргэн хөдөлмөрийн чадвараа алдсан байдаг Энэ дотор. 5 иргэн нас бар.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 минут сунгая.

**Х.Батжаргал:** Ийм асуудал бас байдаг учраас үүний дотор бас гэмт хэргийн нөхцөл байдал үүссэн байж болзошгүй гээд АТГ бас шалгаж байгаа. Энэ хууль, шүүхийн үйл ажиллагаа эцэслэн дүгнэгдсэний дараагаар бид энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэх боломжтой. Түүнээс наана бид бас иргэдийн эрх зарим байдлаар зөрчигдөхөд эргээд бас нөгөө талд хууль, шүүхийн асуудал өрнөх ийм боломж байгаа.

Боловсролын зээлийн сангийн даргаар ажиллаж байсан энэ удирдлагыг солих асуудал гарсан. Үнэхээр бас сайн тал бас байгаа, анхаарах асуудал бас байгаа. Сайн тал нь юу вэ гэхээр Боловсролын зээлийн сангийн эргэн төлөлтөд бас ахиц гарсан.

Нөгөө талд нь Боловсролын зээлийн сан иргэдэд үйлчилгээ үзүүлдэг, төрийн үйлчилгээг үзүүлж байгаа ямар нэгэн хүнд сурталгүйгээр, саадгүйгээр тэгээд дээр нь шуурхай үзүүлэх ийм үүрэгтэй. Энэ хугацаанд бас иргэдийн гомдлын дагуу 6 төрийн 6.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин сунгая.

**Х.Батжаргал:** Би тийм гээд бас танд нэмж мэдээлэл өгөхгүй бол бас болохгүй болов уу гэж бодож байна. Тэгээд энэ удирдлагаар ажиллаж байсан иргэнийг тийм ээ өөрчилсөн. Боловсролын сайдын тушаалаар Боловсролын сайд бас өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд чөлөөлсөн байдаг. Эргээд нээлттэй сонгон шалгаруулалт явах боломж нь Боловсролын зээлийн сангийн удирдлага дээр хаалттай байдаг. Яагаад гэвэл өмнөх ажиллаж байсан алба, удирдлагын хяналт шалгалтын ажил хуулийн байгууллага дээр явагдаж байгаа учраас төрийн албанаас түдгэлзүүлчихсэн учраас оронд нь нээлттэй сонгон шалгаруулалт явагдаж болдоггүй. Тэр одоо ажиллаж байгаа, удирдлагаар ажиллаж байгаа залуу

бол бас Америкт боловсрол судлалаар боловсрол эзэмшсэн, багш мэргэжилтэй. Боловсролын сайдын туслахаар ажиллаж байсан нь үнэн. Үүрэг гүйцэтгэж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Өлзийхүүгийн Шижир гишүүн.

**Ө.Шижир:** Өдрийн мэнд. Сайд байхгүй, дэд сайд байхгүй, Ерөнхий сайдаас гараад явчхаж. Одоо ингээд энэ сайд нарыг яаралтай томилохгүй бол Монголын бүх яамнууд чинь сайдгүй болчихлоо. Магадгүй Үндсэн хуульд байгаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөх 7 хоногийг хүлээгээд 7 хоногийн хугацаанд хүлээгдэх юм бол Монгол Улсын бүх яамд 8 дахь хоног дээрээ сайдгүй болох ийм эрсдэл байна. Энэ бол өөрөө Үндсэн хуулийн цоорхой байгаад байна. Тэгэхээр манай хуульч гишүүд бас энэ Үндсэн хуулийнхаа юун дээр илүү анхаараад энийг цааш нь засах юм хийхгүй яг бол үндсэндээ сайд нар бүрэн эрхгүй, дэд сайд нар бүрэн эрхгүй. Ганцхан Ерөнхий сайд бүрэн эрхтэй ийм болчихоод байна шүү. Энийг бас анхаараарай.

Ер нь Монгол Улсын Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2025 онд хөгжлийн хөтөлбөр зэргээ Засгийн газраас анх өргөн барихдаа хүрч чадахуйц, хэрэгжихүйц, боломжтой энэ зорилгоо тодорхой тавих хэрэгтэй байна. Хүрэх зорилгоо ингээд зөв төлөвлөхгүй болохоор гарах үр дүн чинь ийм муу байгаа байхгүй юу яг бодитойгоор. Бид нар ингээд хүслээ мөрөөдлөө бүгдийг нь биччихдэг. Тэгээд жагсаагаад тавьчихдаг. Тэгээд яг тэр хөтөлбөрүүдээ харахаар хэдхэн жилийн дараа Япон, Солонгосын хөгжлийн үр хэмжээгээр гүйцэх гэж байгаа юм шиг ийм гоё гоё ойлголтуудыг тавьчихдаг. Бодит үр дүнд нь ингээд хэрэгждэггүй. Тэгээд энэ дээр бодвол Эдийн засаг, хөгжлийн яам хариуцах байх гэж бодож байна.

Ер нь энэ их тийм одоо байгаад байгаа энэ аваад байгаа энэ муу дүнгүүд чинь их тийм тайлагнаж байгаа асуудал дээр биш төлөвлөж байгаа асуудал дээр л байгаа. Буруу төлөвлөөд байгаа юм. Энгийнээр ярих юм бол бүх энэ дүгнэлтүүд чинь 60 хувь хүрэхгүй байна гэдэг чинь ерөнхий боловсролын хичээлээр ярих юм бол Засгийн газар шалгалтдаа уначхаад байна шүү дээ. “F” дүн авчхаад байна. Түүнийг дагасан төрийн бүх байгууллагууд дагаж унаад байна гэсэн үг. Тэгэхээр бид нар ерөөсөө төлөвлөлтөө анхнаасаа зөв хийх ийм шаардлагатай байгаад байгаа юм.

Тэр дуусдаггүй яриа гэдэг шиг дуусдаггүй баахан төслүүд байдаг. Нөгөө зэс хайлуулах үйлдвэр, алт цэвэршүүлэх үйлдвэр, V цахилгаан станц ингээд өчнөөн төсөл хөтөлбөр ярьдаг. Тэгээд энэ тарааж өгсөн материалаас “0” буюу үр дүнгүй бүр “0” гэсэн үнэлгээтэй хэдэн юмнуудаас асуух гэсэн юм. Эндээс ингээд харахаар нийтдээ 81 төсөл, хөтөлбөр байна. Түүний 5 нь хүнсний салбарт, уул уурхайн салбарт 7 нь, боомт болон төмөр замын салбарт 6 нь, авто замын салбарт 10 нь, эрчим хүчний салбарт 12 нь. Ингээд нийтдээ 40 төсөл нь яг эдийн засгийн тэлэх, эдийн засгийнхаа үйл ажиллагаанд буюу аж үйлдвэрийн төслүүдийг дандаа “0” үнэлгээтэй байгаад байгаа юм.

Тэгээд нөгөө аж үйлдвэржсэн улс болно, эдийн засгийн хүчирхэг улс болно, ДНБ-ийг бид нар 2028 он гэхэд 10 мянган долларт хүргэнэ гээд нөгөө 2004 онд баталсан, 2024 онд баталсан сайхан зорилгод чинь энэ хөтөлбөрүүд чинь хэрэгжихгүй байхаар яах юм бэ гэж. Жишээ нь ингээд тайлбар нь аягүй гоё. Зэсийн

баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар барих. Шалтгаан нь 2026 оны төлөвлөгөөнд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Алт цэвэршүүлэх үйлдвэрийг барина. 2026 оны төлөвлөгөөнд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд Ган үйлдвэрийн цогцолбор барина. Дахиад 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ гээд.

Тэгээд 1 жилийн дотор бид нар яг бодитоор бас их том том үйлдвэр барихгүй л дээ. Тэгээд Өмнөговь аймгийн Гурвантэс сумд Шивээхүрэн ачааны терминал барина. Дахиад хойшлуулчихсан 2026 онд хэрэгжүүлнэ гээд. Тэгээд бид ийм төсөл 40 байна. Үгүй энэ 84 байна. Энэ 84-ийн 40 нь уул уурхай, зам тээвэр, эрчим хүч гэсэн ийм төслүүд байгаад байна. Тэгээд хүрч чадахгүй төслүүдээ бид нар ингэж худлаа мөрөөдлийн жагсаалт хэзээ бичихээ болих юм бэ Эдийн засаг, хөгжлийн яамныхан? Эдийн засаг, хөгжлийн яаман дээр базагдаж байгаа биз дээ тээ? Тэгээд ингээд хийж чадахгүй зүйлээ хийж чадах мэтээр ингээд тавьчихдаг. Одоо энгийнээр ярих юм бол 30 гарчхаад сагсан бөмбөгийн ямар ч спортын ойлголтугуй мөртөө NBA-ийн тамирчин болно гээд яриад яваад байх чинь яг адилхан байна шүү дээ. Эхлээд энэ дээр хариулт аваадахъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номерын микрофон.

**И.Батхүү:** Шижир гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа бид батлагдсан аргачлал, журмын дагуу шаардлагыг нь тавиад боловсруулж байгаа. Түрүүн яг 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт дээр гараад байгаа асуудал 2, 3 шалтгаантай.

Нэгдүгээрт нь төсвөөр улсын хөгжлийн төлөвлөгөөгөөр төлөвлөсөн ажлууд маань төсөвт суухдаа Улсын Их Хурлын бүрэн эрх мэдлийн хүрээнд бас тодорхой асуудлууд нь орхигдох, санхүүжилт тавигдахгүй байх нөхцөл байдлууд үүсэж байна.

Хоёрдугаарт нь 2025 оны оны эхнээс эхлээд олон улсын геополитикийн нөхцөл байдал, гадаад худалдаа, тарифын бодлогын зөрчилдөөнөөс үүсээд манай гол экспортлогч экспортын бүтээгдэхүүний нүүрсний үнийн уналт явагдсан 40 хувиар унасан. Энэтэй холбоотой бас төсвийн орлого тасалдах, төсөв тодотгох хэрэгцээ шаардлага үүссэн байгаа. Тэгээд төсвийн тодотголоор 2.2 их наяд төгрөгийн тодотгол явагдсан. Тодотголоос гадна дахиад ТӨК-удын хувьд 3 их наяд гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт урсгал зардлыг бас зогсоож царцаасан ажлууд явагдсан.

Тэгэхээр үүнтэй холбоотой бас хэрэгжилтийн асуудлууд үүссэн. Яг тухайлсан төслүүдийн талаар хариуцсан яамнууд бас хэрэгжилтийн тайлбар хэлэх байх.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

**Б.Дашпүрэв:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Шижир гишүүний асуултад хариулъя. Яг тийм. Энэ томоохон төслүүд шууд 1 жилд хэрэгжих ийм боломж, нөхцөл байхгүй. Төслүүдийн талаар товчхон танилцуулахад зэс боловсруулах үйлдвэрийг Эрдэнэтийн орд дээр түшиглэж хийж

хэрэгжүүлэх ажил стратегийн хөрөнгө оруулагчаа сонгож шалгаруулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр shortlist үүсгээд өнөөдрийн түвшинд явж байна. Ган боловсруулах буюу 1 сая тонн ган үйлдвэр хайлуулах, 200 мянган тонн ширэм боловсруулах энэ үйлдвэрийн ТЭЗҮ нь батлагдсан, ажлын хэсэг нь байгуулагдаад ингээд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу зарлахад бэлэн болсон байгаа.

Алт цэвэршүүлэх үйлдвэрийн тухайд жилдээ 20 сая тонн алт, 30-50 сая тонн мөнгө боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг байгуулахаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлахаар ажлын даалгавар нь бэлэн болсон байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Шижир гишүүн.

**Ө.Шижир:** Тэгэхээр сая асуултад хариулдаг 2 Төрийн нарийн бичгийн дарга санаж байвал 2024 онд 2025 оны улсын төсвийг хэлж байхад, 25 онд хэлж байхад энэ хөгжлийн хөтөлбөрүүд хэлж байхад би яг энийг та нарт хэлж байсан шүү дээ. Та нар 10 мянган долларт яаж хүргэж чадах юм бэ, дэлхийн геополитикийн нөхцөл байдал чинь өөрчлөгдөөд байна, нүүрсний үнэ унах гээд байна, нөгөө 20 тонн алт гэсэн чинь худлаа хэрэгжихгүй байна, та нарын цаасан дээр буулгаж оруулж ирж бүгд худлаа байна. Та нар чадна энэ асуудал байхгүй л гээд байсан. Одоо санаж байна уу? Эдийн засаг, хөгжлийн яамны сайд, Төрийн нарийн надаа яг тэгж хариулж байсан. Энэ ямар ч асуудал байхгүй гээд.

Дэлхийн нөхцөл байдал чинь өөрчлөгдөөд байна шүү. Нүүрсний үнэ чинь унах гээд байна шүү, алтны үнэ өсөх гээд байгаа учраас алт дээрээ та нар ямар бодлого барьж байгаа юм бэ? Геополитикийн нөхцөл байдал чинь ийм өөрчлөгдөж байна. Тийм учраас алт дээрээ илүү анхаарал тавиаач, нүүрс чинь унах гээд байна та нарын энэ төлөвлөгөө чинь хэрэгжихгүй шүү дараа нь хэрэгжихгүй гээд би ам асууна шүү гэж хэлж байсан шүү дээ. 2 жил дараа ч би хэлсэн шүү дээ. Тэгээд та нар болно, манай төлөвлөгөө ёстой онц, сайн төлөвлөгөө байгаа л гээд байсан шүү дээ. Тэгээд үр дүн нь хаана байна? Хариулт авъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ? 3 номерын микрофон. Саяын хариулдаг хүн хэн бэ?

**И.Батхүү:** Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү Шижир гишүүний асуултад нэмэлтээр мэдээлэл өгье. 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 24 оны 4 сард өргөн баригдаад хаврын чуулганаар батлагдаагүй. 25 оныхоо 9 сард дахин 9 сарын хооронд л өргөн барьсан байгаа. Энэ хугацаанд нэлээн их цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн. Нүүрсний үнэ, экспортын биет хэмжээнд эрсдэлүүд гарсан. Засгийн газрын зүгээс экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэг гаргаж ажиллаад уул уурхайн биржийн идэвхжилийг нэмэгдүүлсэн, хил, гааль дээр үүсээд байсан асуудлуудыг цэгцэлсэн байгаа. Үүний үр дүнд 25 онд биет хэмжээгээр нүүрсний хэмжээ 90 сая тонн хүрч, бид экспортоо бас тодорхой хэмжээнд хадгалж чадсан. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангасан.

25 оны байдлаар жилийн эцсийн гүйцэтгэл 6.8 хувийн өсөлттэй гарсан байгаа. Таны хэлж байгаа алтан дээр 16.8 тонн гарсан байгаа гэж үзэж байгаа манайх тоо танилцуулагдаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Шижир гишүүн тодруулъя.

**Ө.Шижир:** Нөгөө хуулийн хугацаатай болохоор л хойшлуулж болохгүй байна гэдэг шиг л юм болчхоод л байна л даа. Одоо яамаар ч юм. Улс төрийн хариуцлага хүлээхгүй хүмүүс нь ингээд тойруулж хариулсаар байгаад ингээд дуусчихдаг. Тухайн үед би яг танд хэлж байна шүү дээ Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаа. 10 мянган долларын зорилт хийхийн тулд та нар жилд 11.7 хувийн эдийн засгийн өсөлт хийж байж 10 мянган долларт хүрнэ шүү. Хамгийн багадаа 95 сая тонн нүүрс экспортолж, хамгийн багадаа 25 тонн алт олж байж энд эдийн засагт хүрнэ. Бид нар чинь гуравхан юм зарж байна шүү дээ. Алт, зэс, нүүрс, жоохон ноолуур.

Тэгээд ингээд яам нь өөрөө эдийн засгийн төлөлтөө буруу хараад байна шүү дээ. Энэ чинь. Айлаар ярих юм бол цаасан дээр олж байгаа орлогоо түрүүлээд бодит байдлаар үрчхээд байна шүү дээ. Олоогүй орлогод түрүүлж үрээд байна шүү дээ энэ чинь. Айлаар ярих юм бол. Тэгээд ийм байдалтай Эдийн засаг, хөгжлийн яамныхан цаашид битгий хандаач. Энэ чинь та нар асуултад хариулсан болоод, цаас баталсан болоод үр дүнд нь эдийн засаг, энэ иргэд чинь хохироод байна шүү дээ. Яг бодитойгоор.

**Ж.Бат-Эрдэнэ:** Лувсанбямбын Мөнхбаясгалан.

**Л.Мөнхбаясгалан:** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 25 оны гүйцэтгэлийн тайланг 16 гишүүн танхимд хэлэлцээд сууж байна. Сайд нар нь байхгүй. Сайд нар нь хариулах ёсгүй гэсэн. Тэгээд нөгөө 1 хоногтой Ерөнхий сайд маань ч байхгүй. Тэгээд одоо энд ийм үйл ажиллагааныхаа тайланг бид нар хэлэлц гээд байгаа байхгүй юу. Нэг ийм инээдтэй ч юм шиг, шоглоомтой ч юм шиг энэ хувь тавилан байна энэ Ардын намынханд. Энэ үйл ажиллагааны тайланг хэлэлцэх үед заавал нэг Засгийн газар нь огцорчихсон байдаг. Өнгөрсөн жил Үндсэн чиглэл баталж байхад мөн л Засгийн газар нь огцорч байсан. 26 оны улсын төсвийг баталж байхад мөн л засаг нь огцорчихсон байсан. Нэг ийм шоглоом яваад байгаа байхгүй юу.

Гэтэл хар аа гол юм чинь энэ дундаж наслалт буурсан байна, нас баралт ихэссэн байна, нялхсын эндэгдэл ихэссэн байна. Дээрээс нь төрөлт багассан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нь буурсан. 25 онд 2 дэд төв нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх 2 дэд төв, 8 нийгмийн Эрүүл мэндийн төв байгуулна гэсэн төсөв мөнгө байхгүй гээд орхисон байна.

Дээрээс нь шинжлэх ухаан технологийн үйл ажиллагааны зардлыг сая төсвийн тодотголоор 51 хувьд хүргээд бүүр 53.1 хувьд хүргээд татчихсан байгаа байхгүй юу. Ийм дампуу болчихсон. Тэгээд өчнөөн олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд байдаг хөдөөгүүр залуу малчид байхгүй болчихсон. Ард түмэн нь ядуурчихсан. Одоо бүүр ингээд төрөлт байхгүй. Энэ ард түмэн чинь нас бараад, өвчинд эзлэгдээд, ядуураад, хүн ам зүйн ямар ч бодлогогүйгээс бүрэн дуусаж байна шүү дээ.

Тэгэхэд энд дахиад л сайдууд нь байхгүй. Одоо бүгдээрээ гялалзчихсан л давхиж яваа шүү дээ. Нэг нэг сайд болчих санаатай цүнхээ үүрээд л өрөө хаалга

онголзуулаад л энэ тэрүүгээр гүйгээд л. Дандаа ийм чухал юм хэлэлцэж байх үед ийм байх юм. Одоо эндээс асуух гэхээр хариуцлага хүлээх хүн нь байхгүй болохоор Төрийн нарийн бичгийн дарга нараас асуугаад яах вэ дээ? Яаж төрөлтийг ихэсгэх вэ гэж асуулт байна биш. Яагаад энэ нас баралт, энэ нялхсын эндэгдэл ихсээд байгаа юм? Энэ дээр чинь хариуцлага хүлээх ёстой шүү дээ. Ямар ч хариуцлага байхгүй.

Тэгээд бид нар ингэж цаг үрж суух хэрэг байгаа юм уу даа? Бүүр урам хугараад байх юм. Сүүлдээ бүүр хугарах ч урамгүй болчихоод байх юм. Энэ үгийг л хэлье гэж бодсон юм. Бүгдээрээ сайд болно гээд л гүйлдээд л байна. Үүгээр нүд, ам нь эргэлдээд л гялалзаад л хөл нь ч хурдан болчихож бүр. 1 хоногтоо Ерөнхий сайдыгаа дуудаж авчрах юм уу дарга аа? Дуудах ёстой тээ? Үгүй юм уу? 16-уулаа энд суугаад байх юм уу айн? Түрүүн 11 байсан юм. Одоо тэгээд 16 болчихоод л байна л даа. Тэгээд Засгийн газраа огцруулах болохоороо бөөнөөрөө гүйж орж ирээд ирцээ бүрдүүлээд гялс огцруулчихна. Тэгээд энэ хариуцлага тооцох, ажлын тайланг нь сонсьё ярья гэхээр бүгдээрээ сайд болно гээд гүйгээд гараад явчихна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мөнхбаясгалан гишүүн ээ түрүүн сайд нар хүрч ирээд хариульа гээд тэгсэн Шижир гишүүн, Пүрэвдорж гишүүд сайд нараас асуухгүй шүү, сайд нар хариулахгүй шүү гээд бүр хатуу хашхирч байгаад гараад явцгаасан шүү дээ. Тэгээд сайд нар нь ч өөрсдөө зарим нэг нь гараад явчихлаа. Тэгээд шаардлагатай бол бүгдийг нь дуудъя л даа. Ерөнхий сайдыг дуудаарай. Дэд сайд нарыг дууд. Түрүүн орж ирсэн сайд нарыг бүгдийг нь хөөгөөд явуулчихсан шүү дээ бараг л тийм.

Гэхдээ битгий наад хүмүүсээсээ хариул. Та нар хариулах эрхгүй шүү гээд загнаж загнаж байгаад гарч явсан шүү. 2 хүн хэлсэн, 2 хүн хэлсэн. Үгүй харин тэгээд тэд нартаа хэлээд хэдүүлээ байлгах л хэрэгтэй л байсан байхгүй юу даа. Төрийн нарийн бичгийн дарга нар хариулаад яв л даа. Жаахан тодорхой хариул л даа. Бүхэл бүтэн энэ чинь Төрийн нарийн бичгийн дарга ямар ч холигдож солигдохгүйгээр энэ чинь төрийнхөө бодлогыг бариад явж байгаа хүмүүс шүү дээ. Хариуцлага үүрэх ёстой.

Мөнхбаясгалан гишүүнд 1 минут сунгая.

**Л.Мөнхбаясгалан:** Таны хэлж байгаа зөв өө. Төрийн нарийнууд нь холигдож солигддоггүй. Яг ачаагаа үүрээд ажлаа хийж байгаа. Тэгж байтал нэг сэнсэрсэн сайд орж ирээд энэ яамыг чинь тэр чигээр нь самраад хаячихдаг байхгүй юу. Одоо дараагийнх нь самраачид бэлэн болчихсон тэрүүгээр гүйлдээд явж байгаа шүү дээ. Одоо энэ Төрийн нарийнууд айж байгаа шүү дээ яг үнэндээ. Одоо ямар сайд ирж бид нарын ажлыг дахиж самрах бол гээд. Пүрэвдорж гишүүний асуудлыг энд яриагүй байна. Энд танай Засгийн газрын тайлан хэлэлцэж байгаа. Одоо бүүр ингээд өмнөөс доог тохуу хийгээд байдаг болчихлоо. Та наад үгээ микрофон дээр хэлээд өг дөө яахаараа та нарыг хариулт өгөхийг хориглодог юм? Хэн хориглосон юм Батбаатар сайд аа?

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэдүүлээ бөөндөө ирээд сая сонссон шүү дээ. Пүрэвдорж гишүүн битгий хариул, та нар хариулах эрхгүй гээд түрүүн загнаж загнаж байгаад гарсан. Шижир гишүүн ч бас тэгж хэлсэн өөрөө. Одоо харин Ерөнхий сайдыг дуудъя.

Лувсаннъямын Гантөмөр гишүүн.

**Л.Гантөмөр:** Ер нь тайлан хэлэлцэнэ гэдэг сахилга батын асуудал Батбаатар аа. Батбаатар энэ тэр хариулах эрхгүй юм байна лээ. Тэр бол тодорхой. Яагаад гэвэл эд нар Ерөнхий сайд огцрохоор дагаад огцорчихдог юм байна. Тийм учраас эд нар чимээгүй тэгээд. Уг нь энд ёс зүйн хувьд энд суугаад хийж байсан ажлаа дүгнүүлээд хүмүүс юу гэж дүгнэх нь вэ гээд ингээд Дэлгэрсайхан сайд шиг ингээд сууж баймаар байхгүй юу. Энэ бол тэгэхдээ сахилга батын асуудал шүү. Үнэндээ бол Хойд Солонгос жишээлбэл ийм тайлан авах юм бол та хэдийг бүгдийг нь цаазална, цаазаар авна. Хятад Улсад хэрвээ ийм тайлан хүлээж авах юм бол та хэдийг шоронд хийнэ. Монгол Улсад ийм тайлан хүлээж авчхаад ингээд элэг доог хийгээд сууж байгаа байхгүй юу. Тийм учраас Монголын ард түмэн ингээд төр засагтаа итгэх итгэл алдраад байгаа юм.

Тэгэхээр би бүх Төрийн нарийн бичгийн дарга нараас нэг юм асуумаар байна. Та нар яг энэ 25 оны хийсэн ажлаа юу гэж дүгнэж байгаа юм бэ? Хийсэн 5 ажлаа хэл, хийж чадаагүй 5 ажлаа хэл. Хийж чадаагүй энэ ажлын хариуцлагыг хэн хүлээх юм бэ? Та хэд хүлээнэ ээ. Батхүү чи хүлээнэ шүү. Тийм учраас одоо цаашид энэ төрийн албаны хамгийн бүх томчуул нь та нар. Монголын төрийг та нар атгаж байгаа. Та хэд жоохон шийдэмгий бай, ухаантай бай, хариуцлагатай бай. Битгий сайд нараар тоглоод бай. Сайд нар ирдэг, явдаг. Бид нар төрийн алба хөдөлдөггүй, ганхдаггүй гэдэг. Тэгвэл та нар ажлаа хий. Одоо яг бүгд босоод би ийм ажил хийсэн 25 онд.

Жишээ нь тэр авлигын индекс ухрааж байгаа Хууль зүйн Төрийн нарийн бичгийн дарга гарч ирээд хэл. Яагаад чи ухраасан юм, яаж энэ авлигын индексийг сайжруулах юм? Одоо үнэнээ хэл. Тэр нялхсын эндэгдлийг нэмэгдүүлсэн гэдэг чинь бүүр аймаар том гэмт хэрэг рүү бид нар явж байна шүү дээ одоо. Эрүүл мэндийн Төрийн нарийн бичгийн дарга энэ дээр өөрөө хариуцлагаа хүлээ. Юу болж байгаа юм бэ? Яахаараа ийм сайхан эрх чөлөөтэй Монгол Улсад хүний дундаж наслалт буурдаг юм бэ? Хэл одоо Очирбат аа. Чи бол насаараа төрд ажилласан. Үнэнээ хэл. Тэр эмийн дамын наймаагаа ярь, тэр эмнэлгийн захирлуудын ажлын хариуцлагыг ярь, тэр даатгалын мөнгийг идэж ууж байгаа асуудлаа ярь. Аймаар сонсогдож байна шүү дээ. Яахаараа энэ инновацын бодлого унадаг юм? Тэр инновац хариуцсан Төрийн нарийн гараад энэ асуудлаа ярь, ажлаа өг, нэр төртэй амьдарцгаа. Батхүү чи маш тодорхой энэ тайлангийн дараа хэрхэн хариуцлага хүлээдэг тухай ямар бодлого гаргаж байгаагаа хэл. Чи тийм үүрэгтэй хүн. Энэ хөгжлийн тайланг 80 хувиас дээшээ хангаагүй бүх төрийн албанд өндөр албан тушаалтнууд хариуцлага хүлээдэг тэр орчныг одоо бүрдүүлэх хэрэгтэй. 27 оны 26 оны тайлан ярихад хэрвээ 80 хувиас доош ажлаа хийсэн сайд нар байвал шууд бүгдийнх нь толгойг авах хэрэгтэй. Огцруулах хэрэгтэй толгой авах биш. Үгүй үгүй толгой авах биш л дээ огцруулах хэрэгтэй үгүй. Энэ чинь тоглоом биш болчихоод байна шүү дээ Сандагаа даргаа. Та чинь.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ Гантөмөр гишүүний ярьж байгаа үнэн шүү. Энэ Төрийн нарийн бичгийн дарга нар сайд нар ирэхээр л тэгээд л тэр тухайн сайддаа тохируулж ажилладаг болчихсон ерөөсөө. Өөрийн гэсэн бодлого байхгүй, яамны бодлого гэж байхгүй. Энэ чинь хэзээ ч халагдахгүй Төрийн нарийн бичгийн дарга нар шүү дээ. Тэгээд сайд сайд хүрч ирэхээр л тэгээд сайд нь очоод салгаад

тоглогчидог тиймэрхүү байдалтай болчихсон байгаа шүү. Ямар ч байсан Батхүү Төрийн нарийн бичгийн дарга, хууль зүй, эрүүл мэнд, боловсрол энэ хэдээс ямар ч байсан асуучихъя тэгэх үү?

**И.Батхүү:** Гантөмөр гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Эдийн засаг, хөгжлийн яамны хувьд тухайн 25 онд олон ажил хэрэгжүүлж, үр дүнгээ гаргасан. Онцолж хэлэх юм бол экспортыг оны эхнээс нүүрсний үнэ унаад бас хил, гааль дээр, тээвэрлэлт дээр олон асуудал гарсныг бас бид ажлын хэсэг гаргаж анхаарч ажилласны үр дүнд 90 сая тонн нүүрс гаргаж чадсан. Өнгөрсөн онд бас зэсийн экспорт, бас төмрийн хүдрийн экспорт төлөвлөсөн дүнгээс өндөр гарсан. Энэ экспорт дээр онцгойлон анхаарч ажилласны дүнд бас үр дүн гарсан гэж үзэж байна.

Хоёрдугаарт нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг өнгөрсөн оны төсвийн тухай хуульд дагалдуулж өөрчилсөн. Үүгээр өнгөрсөн 2, 3 жилийн турш яригдаж байсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хэрэгжүүлэх төслүүд удаашралтай, бэлтгэл ажил дээр их цаг хугацаа зарцуулж байна гэсэн асуудлыг шийдвэрлэсэн. Өнөөдрийн байдлаар Эдийн засаг, хөгжлийн яаман дээр 20 хэдэн төслийн сонгон шалгаруулалтыг зарлахаар урьдчилсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлээд байгаа.

Гуравдугаарт нь Евро Азийн эдийн засгийн холбоотой байгуулсан Чөлөөт худалдааны төр хэлэлцээрийг бас гарын үсэг зурж, бэлтгэл ажлыг хангах ажлыг эхлүүлсэн байгаа. Бас Гантөмөр гишүүний тухайн үед Тэргүүн шадар сайдаар ажиллаж байхдаа өгч байсан үүрэг даалгаврын дагуу зөвхөн дотооддоо төдийгүй нөгөө талын улс орнуудтай хамтарсан замын зураглалыг бас боловсруулаад бэлтгэл ажлын хэрэгжилтийг хангаад ажиллаж байна.

Үүний үр дүнд 367 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээс 97 хувь нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүн. Ноос, ноолуур, арьс шир, мах, махан бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх, хөдөө орон нутгийн малчин өрхүүдийн өрхийн орлого нэмэгдэх боломж үүсэх юм.

Дээр нь бас хөрөнгө оруулагчдыг эрх ашгийг нь хамгаалах асуудал их цогц хүрээнд нь асуудлыг шийдвэрлэх ёстой. Шүүх засаглал, хууль, эрх зүйн орчин, шат шатын хүнд суртлыг арилгах. Энэ чиглэлээр тодорхой хуулийн төслүүдийг бэлтгээд, боловсруулаад Их Хуралтай хамтарч ажиллаад өргөн бариад бас явж байсан. Үүнийгээ хүлээхгүйгээр Эдийн засаг, хөгжлийн яамны хажууд бас хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах төвийг байгуулаад идэвхтэй ажиллаж байгаа. Хөрөнгө оруулагчдаа мэдээлэл өгөх, зөвлөн туслах, эрх ашиг, гомдлыг нь шууд хүлээж авч шийдвэрлэх талаар онцгойлон анхаарч ажиллаж байгаа.

Энэ нь өмнө нь төрөөс үзүүлдэг 6 төрлийн нийтийн төрийн үйлчилгээнээс гадна өргөн цар хүрээнд хөрөнгө оруулагчдын илүү итгэлийг олж ажиллах, ил тод ажиллах тал дээр анхаарч ажиллаж байгаагийн нэг хэлбэр гэж үзэж болж байна. Товчхондоо хэлбэл ийм байна. Эдийн засгийн өсөлт 8 хувиар гэж төсөөлж байсан. Бодит байдал дээр 6.8 хувь гарсан. Энэ өсөлт маань өөрөө Азидаа болон бусад бүс нутгийн орнуудтай харьцуулалт өндөр байгаа ч гэсэн бид нарын хувьд бас энэ дээр бас анхаарч ажиллах ёстой шаардлага байгаа гэж үзэж байна.

Энэ дээр 2025 онд үүссэн тэр экспорт дээр үүссэн хүндрэлүүд нэлээн их ачаалал өгсөн. Бас оны дунд тодотгол хийсэнтэй холбоотой хөрөнгө оруулалт, эдийн засгийн идэвхжил бас тодорхой хэмжээнд суларсантай холбоотой. Зорьсон түвшиндээ хүрээгүй нэг тал байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дараагийнх Хууль зүй, боловсрол, эрүүл мэнд. 4 номер.

**Н.Мягмар:** Гантөмөр гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар.

Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхлэх асуудлын хүрээнд нэгдүгээрт Монгол Улсын хууль зүйн нэгдсэн бодлогыг барих, түүнд нийцсэн хууль тогтоомжийн төсөл дээр Улсын Их Хурал, Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг өгдөг гол чиг үүрэг, нөгөө талаасаа дотоод хэргийн буюу хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн удирдах зөвлөлөөр хангаж ингэж ажиллаж байгаа Хууль зүй яам байгаа. Ерөнхий чиг үүргийн ийм яам байгаа.

2025 оны хувьд Хууль зүй, дотоод хэргийн яам, сайдаас хуулийн нийтдээ 32 төсөл дээр ажилласан байна. Энэ маань яг үзэл баримтлалаараа тоож байгаа тоо. Тухайлбал өргөн мэдүүлж Улсын Их Хурал дээр анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр шилжүүлчихсэн өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд 9 байна. Тухайлбал.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 минут сунгая.

**Н.Мягмар:** Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, нэр бүхий 22 хуулийн төсөл байна. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл, Дампуурлын буюу төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл гэх мэт. Ийм хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцэх эсэх асуудлыг нь шийдвэрлүүлсэн ажиллаж байна. Хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэх шатдаа Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, Төрийн нууцын тухай хууль зэрэг.

Мөн Засгийн газрын хурлаар хэлэлцүүлээд өргөн мэдүүлэхээр тогтсон 2, саналд буюу эцэслэн боловсруулж санал авахаар гаргасан 6 хууль тогтоомж, ажлын хэсэг гарч боловсруулж байгаа нийтдээ 15 ийм хууль тогтоомжийн төслөөр ажиллаж байна. Хоёрдугаарт, 2005 оны.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Сунгая. 4 номер.

**Н.Мягмар:** 25 оны Үндсэн чиглэлийг хөгжүүлэх болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэхтэй холбоотой дотоод хэргийн салбарт үндсэндээ олон улсын хүний эрхийн байгууллагуудаас өгсөн зөвлөмжүүд болон Хүний эрхийн Үндэсний комиссоос өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хүрээнд гол төлөв манай шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, цагдаагийн байгууллага, Хил хамгаалах ерөнхий газар, мөн Шүүх шинжилгээний үндэсний төв

ч гэдэг юм уу, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар гэх мэт хүмүүст төрийн үйлчилгээг үзүүлдэг энэ байгууллагууд дээр хүний эрхийг хангахад, наад захын стандартыг хангахад ийм ийм стандартуудыг ханга гэдэг зөвлөмжүүдийг өгдөг. Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн зардлууд шаардлагатай болдог. Энэ тоног төхөөрөмжийн зардлууд түрүүнд бас манай Эдийн засаг, хөгжлийн яам болон Ерөнхий сайдын танилцуулгад гарсан төсвийн тодотголд холбоотойгоор энэ салбарын бас төсөв татагдсанаар хэрэгжилт хангалтгүй гарах нөхцөлд хүрсэн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Товчхон товчхон хариулаад явъя. Дараагийнх нь Боловсрол. ганц минут. 4 номер.

**Х.Батжаргал:** Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал Гантөмөр гишүүний асуултад хариулъя.

2025 оны голлох ажлуудыг онцлон тэмдэглэж хэлье. Монгол хүүхдэд мэдлэг, хандлага, чадвараа төлөвшлийг зохицох чадамжийг дээшлүүлэх голлох чухал ажил болгох, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн ажлын хүрээнд бага боловсрол болон сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг шинэчилсэн. Шинэчлэлийн ажил.

Суралцахуйн хувьсал цахимжсан боловсролын энэхүү зорилтын хүрээнд цахим ЕБС-ийг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь шинэ хичээлийн жилд эхлүүлэхэд бэлэн болгож байна. Ажиллангаа суралцаж, суралцангаа ажилладаг ажлын байран дээрээ суралцаж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг нийлүүлэх хэмжээнд мэргэжлийн боловсролын энэ тогтолцоог шинэчлэн бэлэн болгосон байна.

2025 оныг боловсролыг дэмжих жил болгон зарлуулах бэлтгэл зохион байгуулалт, төлөвлөлтийг хийж, боловсролын.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 минут сунгая.

**Х.Батжаргал:** Боловсролын салбарын голлох үзүүлэлтүүд дунд болон урт хугацаанд хийгдэх голлох суурь үзүүлэлтүүдийн суурийг 2026 онд 25 оны төсвийн төлөвлөлтөөр дамжуулж хийж байна. Үүний хүрээнд төр, хувийн хэвшлийн шинэчлэлийн энэ ажлыг бол шинэ шатанд гаргаж тухайлах юм бол алслагдсан хөдөө орон нутгийн багийн бага сургуулийг төр, хувийн хэвшлийн хүрээнд шийдвэрлэх, бүрэн хэмжээгээр их, дээд сургуулиудын бас төр хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэж чадахгүй, улсын төсвөөр шийдвэрлэж чадахгүй байгаа энэ төлөвлөлтүүдийг хийж ТЭЗҮ болоод бэлэн байдлыг хангаж ажилласан байна. Боловсролын.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Гантөмөр гишүүн.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр Батхүү даргаас би нэг юм тодруулах гээд байгаа нь өнгөрсөн жил яг энэ гүйцэтгэл ярьж байхад ялгаа байхгүй гүйцэтгэл болоогүй хүмүүсийг яах юм бэ гэдэг асуудлыг Их Хурал дээр маш их хэмжээгээр ярьсан даа. Тэгээд ажил хийхгүй байгаа хүмүүсийг арга хэмжээ авдаг болно л гээд л би яг энэ сандал дээрээс л баахан хамгаалж хамгаалж л гарсан. Тэгээд огцорчихсон.

Тэгэхдээ та нар ядаж ингээд төлөвлөгөөний тайлан гарна. Тайлан дээр муу дүн авна. Ажил хийгээгүй хүмүүс гарах юм бол ийм шийтгэлтэй болъё гээд юм хийж болдоггүй юм уу? Энэ чинь тэрнээс хойшоогоо өчнөөн сар болчихсон байна шүү дээ. Тэгээд юу ч хийхгүй байна шүү дээ. Одоо энэ авлигын индекс унаад байгаа асуудлыг би хуулийн Төрийн нарийн бичгийн даргаас энэ авлигын индексээ аятайхан болгох ямар бодлого байгаа юм бэ? 1, 2 юм хэлээд өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батхүү хариулъя. Тэгээд больё доо.

**И.Батхүү:** Гантөмөр гишүүний асуултад нэмэлтээр хариулт өгье. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Үнэлгээ хийх журмын 4.2.6 дээр яг энэ асуудлыг зохицуулж өгсөн байгаа. Бодлогын баримт бичгийг үр дүнгүй хэрэгжүүлсэн, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох мэдэгдэл, албан шаардлагыг дээд шатын байгууллага, албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилт хяналт тавих эрхийг Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад өгсөн байгаа. Тэгэхээр энэний дагуу цаашдаа арга хэмжээ авах боломжтой байгаа. 2025 онд батлагдсан журам байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сүхбаатарын Эрдэнэбат. Одоо болох байх аа. Гантөмөр Гантөмөр гишүүн.

**Л.Гантөмөр:** Яах вэ хэдүүлээ ингээд хариуцлага тооцдог юмтай болоод авчихвал амар байхгүй юу даа. Сандагаа дарга яг одоо энэ журмын хэрэгжилтэд та хяналт тавих хэрэгтэй. Та бол сарын хугацаа өгөөд сарын дотор эрүүл мэнд, инновац, соёл, шинжлэх ухаан, авлигал энэ 4, 5-н индекс унагаад байгаа хүний өрсөлдөх Монгол хүний өрсөлдөх чадварын асуудал. Энэ 6 асуудал дээр индекс унагаад байгаа хариуцлагагүй албан тушаалтнуудад хариуцлага тооцож ирүүлэх тухай Байнгын хорооны тогтоол гаргах хэрэгтэй. Засгийн газар журамтай юм байна шүү дээ. Энэ журмын дагуу бид хариуцлага тооцоод явах юм бол ирэх жилийн өдийд, ирэх жилийн 4 сарын 1-нд бүх хүн хариуцлагатайгаар ажлаа хийгээд үр дүнгээ тайлагнаад байж байх нь байна. Тийм учраас энэ хамгийн .../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Сайд нар байхгүй Төрийн нарийнууд. Хэд хэдэн зүйлийг асууя. 9 хувийг нь цомхотгол гээд л байгаа. Одоо тэгээд жил болгон хүмүүсийг цомхотгоно. Төрийн алба данхайлаа л гээд байдаг. Энд манай мэргэжлийн хариулт өгөх ёстой. Төрийн энэ албыг анхан шатад дунд, шатад гүйцэтгэж байгаа албан хаагч нар үнэхээр ихдээд байгаа юм уу? Ажлын үүргийнх нь давхцал хэдэн хувиар нэмэгдээд байгаа юм гэдэг дээр яам яаман дээр маш тодорхой судалгаа хийчихэд болно шүү дээ. Сая хөдөө орон нутгаар явж байхад яг ний нуугүй хэлэхэд сумын Засаг дарга, Иргэдийн Хурлын дарга 2 хажуу талаас суучихсан хөөрхий хэнийг нь халах вэ гээд бүлтэлцүүлээд сууж байна лээ. Дотроо учраа олж байгаад 2 хүнийг ажлаас хал гээд норм өгчихсөн. 9 хувь гэдэг нь энэ 20 хүнээс 2-3-ыг нь хал гэчихсэн байгаа юм байна лээ. Тэгээд цаашдаа ийм бүдүүлэг аргаар явж болохгүй. Зарим хэсэгт нь нэмэх хэрэгтэй байна, заримд нь хасах хэрэгтэй. Ард түмэнд хамгийн их ойр үйлчилдэг хүмүүсийг очиж очиж улс төрийн хамгаалалтгүй гэдэг юм уу ийм хүмүүст наад ажилгүйдэл чинь өртөөд байна. Тэгээд энэнээс чинь болоод яаж байна вэ гэхээр ажилгүйдлийн даатгалын сан чинь оны сүүл рүү

хүрэхээ байчихсан шүү дээ. Тэтгэмжийнхээ мөнгийг өгч чадахаа байчихсан. Энэ тал дээр Ажилгүйдлийн даатгалын сан хэдэн төгрөгийг оны сүүлээр өгч чадаагүй вэ? Маш их гомдол саналууд ирсэн.

Хоёрдугаарх нь боловсрол, эрүүл мэндийн салбарын цалин хөлсний асуудал гээд байсан. Тооцооллоо дутуу хийчихлээ л гээд яриад байна. Тэгээд энэ тал дээр үнэхээр тийм тооцоолол дутуу хийсэн юм яг үнэндээ байгаа юм уу, үгүй юм уу? Яг ижилхэн байж байгаа сургууль дотор байж байгаа хөөрхий үүдээр ороход хүүхдүүдийн шавхай малтай сууж байгаа хүний цалинг нэмэхгүй гэж хэлсэн тийм хэлэлцээр хийгээгүй шүү дээ. Би ч чуулган хаах гэж байгаад хэлж байсан. Цэцэрлэгийн хүүхдийн хоолыг таваглаад сууж байгаа хүний цалинг нэмэхгүй гэдэг. Тийм учраас энэ боловсролын, эрүүл мэндийн цалингийн маргаантай асуудлыг яг яаж шийдэх юм? Хэдэн төгрөг хэрэгтэй байгаа юм? Боловсрол, эрүүл мэндийнхэн хариулт асуумаар байна.

Эрүүл мэндийн даатгалын сан мөн ялгаа байхгүй. Би энэ Эрүүл мэндийн даатгал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийнхөнд хурлаа хааяа нээлттэй хийж байгаарай гээд журмыг нь батлаад өгсөн. Байхгүй хаалттай. Тэгээд яаж байна вэ гэхээр сан хүрэхгүй, эцсийн сүүлдээ сүүлд 11, 12 сард яасан? Иргэд өөрсдөөсөө мөнгөө төлсөн шүү дээ. Эмнэлэгт орохоор ний нуугүй л хэлсэн. Мөнгө байхгүй байна. Эм тариагаа өөрөө гаднаас оруулж ир л гэдэг юм нэхэж байна лээ. Бүх эмнэлгүүд чинь эмийн өртэй байна. Эрүүл мэндийн салбарт сумд нь ЭМД-аар үйлчилгээ үзүүлдэггүй 7 сумын асуудал гээд би зөвхөн Хөвсгөл аймгийг хэлсэн. Нэгийг нь ч шийдээгүй одоо хүртэл байгаад байх юм.

Тэгээд яах юм тэнд чинь хүмүүс эмээ авахын тулд аймгийн төв орж байна. Улаанбаатар хотоос захиж авч байна. Энэ тал дээр Монгол Улсын тархай бутархай байгаа энэ нөхцөлд бол аягүй өндөр стандарт тавьчихсан. Эм зүйч байна, эмч байна, хэдэн метр квадрат талбай байна гээд. 1000-хан хүнд эм зарах гэж байгаа газар шүү дээ. 1000 хүнээс тэгээд тийм өндөр шаардлага тавьчихсан. Энэ тал дээрээ бол та бүгд маань яг ямар арга хэмжээ авах юм бэ гэдэг дээр асуумаар байна.

Ахмадуудын асуудал байж байн. Энэ тэтгэврийн зээлтэй холбоотой. Долоо хэмжиж нэг огтлохгүй бол зээлийг нь битгий олгоорой гэдэг шийдвэр га гарчихсанаас хойш тэгээд энэ асуудал нь дуусахгүй одоо хүртэл явж байна.

Тийм учраас энэ ахмадын архаг өвчтэй гээд хэвтүүлэхгүй байна гэж байна энэ ахмадуудыг. Архаг өвчтэй учраас 5 хоногоос илүү. Ер нь бол энэ найдваргүй гэж хэлэх гээд байгаа юм уу юу гэж байгаа юм. Энэ архаг гэдгийн цаана нэлээн олон асуудал, маш их гомдол ирээд байна. Энэ тал дээр яах юм манай эрүүл мэндийн төрийн нарийн хариулаач.

Хэчнээн хүмүүст ипотекийн зээл олгов? Ипотекийн зээл чинь авлигын хэрэгсэл болчихсон юм уу, үгүй юм уу? Маш олон хүмүүс хэдэн жилээр нь хүлээгээд банкнуудад авлигал өгч байж ипотекийн зээл авч байгаа гэдэг л ийм сураг байгаад байна. Энийг яах юм бэ гэдгийг асуумаар байна.

Хэдэн хүн байнгын ажлын байр бий болгов оо шинээр? Хэдэн иргэнийг байнгын ажлын байр.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хариулъя. Микрофон дээр ирээд зогсоцгоож бай. 3 номер.

**Б.Батцэцэг:** Түүний 9 хувийн цомхотголын үр дүнтэй холбоотой асуултыг хариулъя. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Батцэцэг. 9 хувийн цомхотгол одоо 2025 оны нэгдсэн дүнг бид нар хараад үзэхээр үндсэндээ 6 орчим хувийн бууралт төрийн албан хаагч дээр үзүүлсэн байна. Төрийн албан хаагчдын 9 хувийн хэмнэлттэй холбоотойгоор Засгийн газрын тэргүүний албан даалгавар гарч, энэ албан даалгавар дээр аль болох удирдах албан тушаалтнуудыг цөөлөх, аль болох үндсэн чиг үүргээс бусдаар нийтлэг чиг үүрэг гүйцэтгэж байгаа албан тушаалтнуудыг цөөлөх гэдэг судалгаа гарсан юм байгаа, албан даалгавар өгсөн юм байгаа юм.

Төрийн байгууллагуудын энэ 9 хувийн орон тооны хэмнэлттэй холбоотой зүгээр яг хэрэглээн дээр хэд хэдэн гомдол, мэдээлэл бас зарим нь шүүхийн шатад явж байна. Зарим нь манай дээр бас хянагдаад явсан. Тэгэхээр зүгээр нийтлэг байдлаар юу ажиглагдсан гэхээр удирдах албан тушаалтнууд гэхээсээ гүйцэтгэх албан тушаалтнуудаас илүүтэйгээр цөөрсөн. Юуны хувьд чиг үүргийн шинжилгээнүүдийг байгууллагууд харьцангуй бас хангалтгүй хийсэн гэсэн тоо үзүүлэлтүүд гарсан. Чиг үүргийн шинжилгээний хувьд манай байгууллага зүгээр нийтлэг чиг үүргийн шинжилгээ дээр бас төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагууд дээр нийтлэг чиг үүргийн шинжилгээний дүнг Төрийн албаны зөвлөл, Хэрэг эрхлэх газар, Хяналт хэрэгжүүлэх газар хамтраад хийгээд энэ нийтлэг чиг үүргийнхээ шинжилгээний тайланг танилцуулсан.

Өчигдөр Ерөнхий сайд томилогдохдоо аман хэлбэрээр бид нарт тусгайлсан чиг үүргийн шинжилгээг яаралтай хийж, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн дээр саналаа тусгах гэдэг үүрэг даалгаврыг өгөөд өнөөдрөөс бид нар ажилдаа ороод ажиллаж байна. Нэмэлтээр бусад нь ажлын хэсэг хариулах байх.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**Д.Очирбат:** Эрдэнэбат гишүүний асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат хариулъя. Цалин, хөлсний талаар. Эмч нарын эрүүл мэндийн салбарын цалин, хөлсийг энэ оныхоо хэмжээнд Засгийн газрын тогтоол дээр Эрүүл мэндийн яам Үйлдвэрчний эвлэл 3 талтайгаа гэрээ хэлэлцээр оруулаад 1 сарын 1-нээс 30 хувь, 8 сараас 9 сар, 10 сар, 11 сар, 12 сард уу даа 9, 9-н хувь, нийтдээ 75 хувийн бодит нэмэгдлийг тусган тавиад ажиллуулж байгаа.

Зарим нэг эрүүл мэндийн байгууллагад өөрөө ТУЗ-тэй, гүйцэтгэлийн санхүүжилттэй хамтдаа явдаг. Энэ дээрээ ТУЗ дээрээ юм уу, эсвэл эмнэлгийн удирдлагууд дээрээ цалингийнхаа нэмэгдлийг болон нэмэгдлүүдийнхээ нэмэгдлүүдийг өндөр тавьчихсан. Тэр нь саяын 30 хувийн 1 сарын 1 дээр нэмсэн 30 хувийн нэмэгдлээсээ өндөр тавьчихсан зарим нэг.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номероос сунгая.

**Д.Очирбат:** Цөөхөн эмч нарын асуудал дээр бас энэ зөрүүтэй асуудлууд яригддаг. Үндсэндээ эрүүл мэндийн салбарт 75 хувиар цалингийн нэмэгдлийг өгч байгаа. Эрүүл мэндийн даатгалын сан дээр эмнэлгүүддээ эмийн сангууддаа бүх

өрүүдийг 35 тэрбум төгрөгөөр нэхэн тавьж өгсөн. Гагцхүү зарим нэг эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд нь тэр ЭМД гүйцэтгэлээс тавьж өгсөн мөнгөн дээр эмийнхээ өрийг эмийнхээ үйлдвэрүүдтэй эмийн сангууддаа тавьж өгөхгүй байгаа хэл амтай байгаа газрууд байгаа. Энийг судалгаа гарган бид нар хариуцлага тооцож ажиллаж байгаа.

Архаг өвчтэй ахмадууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй хойшлогдож байна гэж бас асуулт асуулаа. Сая эрүүл мэндийн энэ гүйцэтгэлийн санхүүжилттэйгээ холбогдуулаад Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зарим нэг хязгаарлалтуудыг хийж ажилласан. Сан нь бага ..., сангаа хүрч эрүүл мэндийн гүйцэтгэл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүргэхийн үндсэн дээр архаг өвчлөлтэй гүйцэт төлөвлөгөөт.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номер.

**М.Баяраа:** Энэ өдрийн мэндийг хүргэе. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Баяраа. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 2013 онд Монголбанк, Засгийн газрын хамтран ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байгаа. 2026 оны 3 сарын байдлаар 133700 өрхийн 11.7 их наяд төгрөгийн санхүүжилтийг энэ хөтөлбөрт зориулаад олгочихсон байгаа. Одоогийн байдлаар болохоор банкнууд дээр 5 их наядын хүсэлтүүд ирчихсэн. Нийт энэ 2 жилийн нөгөө очер үүсгэсэн ийм асуудал байгаа. Яамны зүгээс бол Орон сууцжуулалтын банк, орон сууцжуулалтын тухай хуулийг өргөн барихаар 3 дахь хэлэлцүүлгийг нь иргэдийн дунд хийгээд ингээд явж байна. Энэ хууль орсноор орон сууцжуулалтын банк байгуулагдаж, орон сууцжуулалтын банкаар дамжиж.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 3-ыг сунгая.

**М.Баяраа:** Зорилтот бүлгийн иргэд болоод гэр хорооллыг чөлөөлөх, дахин төлөвлөлтийн байршлууд дээр орон сууцжуулах энэ ажлууд хийх юм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 6 цаг 3 минут болж байна. Хурлыг цааш нь сунгая. 4 номер.

**Л.Мөнхзул:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2025 оны эцсээр бүрэн гүйцэт тэтгэмжээ аваагүй өр төлбөр үүссэн асуудлаар асуулт асуусан. 25 оны эцэст 50 тэрбум төгрөгийн өглөг үүссэн. Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага нь орлогоосоо давсан.

Тухайлбал, 25 оны эцэст 162.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 203.3 тэрбум төгрөгийн зарлага гаргасан. Орлого дутагдаж байгаа гол асуудал маань цалингийнхаа ажилтан 0.2 хувийг ажил олгогч, 0.5 хувь буюу 0.7 хувийн шимтгэл төлдөг. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 25 оны эцэст огцом өөрчлөлт харьцангуй гайгүй байсан. Нийтдээ 6 мянган хүнээр нэмэгдсэн. Энэ нэмэх төрийн албан хаагчдын тоог аваад үзэхэд ажилгүйдлийн тэтгэмж аваг.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номерыг сунгая.

**Л.Мөнхзул:** Ажилгүйдлийн тэтгэмж авагдсан төрийн албан хаагчдын тоог байгууллагын ангиллаар аваад үзэхээр төсөвт байгууллага маань 929 хүн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна. Харин төрийн өмчит үйлдвэрүүдийн газраас нэмэгдсэн тоо нь оны эцэс, 24 оны эцэстэй харьцуулахад өссөн дүн 143 байсан. Үндсэндээ өөрөөр хэлбэл 25 оны эцэст тэтгэмж авсан төрийн албан хаагчийн тоо өмнөх онтой харьцуулах 1200 хүнээр нэмэгдсэн. Төрийн албанд орон тоо цомхотгогдсон тохиолдолд өөр төрийн байгууллага руу шилжин ажиллах сул орон тоо хасах гэх мэт арга хэмжээ авсан учраас ажилгүйдлийн тэтгэмжийн даатгалын урсгал зардал нэмэгдэлт нь бага байсан. Ажилгүйдлийн даатгалын сангийн урсгал зардал нэмэгдэж байгаа гол хүчин зүйл нь шимтгэл төлж төлж байгаа дундаж цалин хөлс, нэмж байгаа үзүүлэлтэд 70 хувийн өсөлтийн нөлөөлөл үзүүлж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болсон уу? Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Тэгэхээр наадах чинь нэг юм хэлээд байна юм аа. Жилдээ ер нь энэ манай Ажилгүйдлийн даатгалын сан юмаа дийлэхгүй байна гэж. Тэгэхээр бид нар аливаа нэгэн сэтгэл хөөрлөө шийдвэр гаргахдаа төр хүртэл энд нь нэмэр болчихмооргүй байгаа юм л даа. Магадгүй засаг солигдох болгонд баахан хүнийг ажилгүй болгоод л наашаа цаашаа болгоод байвал наад нөгөө талд нь бид нарын зардал нэмэгдээд байна шүү дээ тийм үү? Энийг хэлмээр байна.

Дээрээс нь би асуусан ажлын байрыг хэчнээн хүнээр нэмсэн бэ? Эргээд бодоход бид нар 5, 10 сая төгрөг л өгөөд л тэн дээрээ хөөрхий тэгээд л 10 жилийн өмнө тапочки үйлдвэрлэдэг байсан хүн яг л хэвээрээ байгаад байгаа юм. Тэгэхээр нийлүүлж байгаад ядаж 100 сая төгрөг гэдэг юм уу нэг жижигхэн хөөрхөн цех хийдэг ч юм уу ийм байдлын юмнуудыг бас хиймээр байгаа юм. Тэгэхээр чанартай ажлын байр гэж би хэлээд байгаа юм. 6 сараас дээш хугацаатай хийх ажлын байруудыг хэчнээнийг бий болгож чадав гэдгийг асууж байна.

Мөн дээрээс нь Хөдөө аж ахуйн яамнаас асууя. Энэ хөдөө орон нутгаар явахаар энэ хонины нэхий хэзээ авах вэ, нөгөө арьс ширний үйлдвэр юу болов гээд байх юм. Тэр хэзээ шийдэх юм бэ ер нь? Хонины нэхий боловсруулдаг, худалдаж авах.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер уу?

**Л.Мөнхзул:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул гишүүн гишүүний асуултад хариулья. 25 онд 30.1 мянган шинэ ажлын байр бий болсон байна. Жилд дунджаар эдийн засагт 70-80 мянган ажлын байр бий болж байдаг. Бий болж байгаа ажлын байрны ихэнх нь сул ажлын байрнууд байдаг. Ялангуяа тогооч, дугуй засвар, мөн энэ улирлын шинж чанартай болон бусад төрлийн ажлуудад ажлын байрны сул орон тоо буюу ажлын байрны эргэлт их байгаад байдаг. Шинээр 25 оноос 30 мянган ажлын байр бий болсон. Дэлхийн банкны хийсэн судалгаагаар Монгол улсын хөдөлмөрийн нийлүүлэлтийн чиг хандлагыг судлаад үзэхэд хөдөлмөрөө нийлүүлэх гэж байгаа хүмүүс ямар ажлын байранд илүү татагдах вэ гэхээр чанартай бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдсан, НДШ төлсөн ийм ажлын байруудыг илүү өгүүлж байна гэдэг ийм дүгнэлт гарсан. Эдгээр ажлын байруудыг нэмэгдүүлэхийн тулд эдийн засаг дахь капиталын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ёстой.

## **Ж.Бат-Эрдэнэ:** Мөнгөнцогийн Ганхүлэг.

**М.Ганхүлэг:** 2025 оны төлөвлөгөө хэлэлцэж байна нийтдээ 326 төсөл, арга хэмжээг бид хэрэгжүүлнэ гэдэг ийм зорилтыг тавьсан. Үүнийхээ 50.3 хувь буюу 165 нь 85-аас доош хувийн гүйцэтгэлтэй байгаа. Ер нь 2025 онд бид хангалтгүй ажилласан гэдэг ийм дүгнэлт гарсан байна. Боловсруулалт дутуу, төсөв санхүүжилт нь батлагдаагүй гэсэн үндсэн шалтгаануудыг бол дурдсан байна. 85-аас дээш үнэлэгдсэн амжилттай ажлуудын тухай ингээд хараад үзэхээр 100 хувийн биелэлттэй гэж үзсэн соёл урлагийн үйлчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ гэсэн заалт 100 хувь хэрэгжсэн гэж үзсэн байна. Тэр дундаа кино үзсэн, тоглолт үзсэн, соёл, музей үзсэн хүмүүсийг үндсэндээ бол тоо нэмэгдсэн учраас болсон байна гэж ингэж үзсэн. Тэгээд энэ иймэрхүү байдлаар дүгнээд явах уу, үгүй юу? Яг орон нутаг, суман дээр хөдөө байгаа малчдын хувьд ер нь соёлын үйлчилгээг бид нар яг үзүүлж чадаж байгаа юу, үгүй юу? Соёлын төвтэй байх уу, үгүй юу гэдэг тухай хүртэл ярьж мэтгэлцэж үндсэндээ ирсэн. Цагаа тулахад бид бүхэн өнгөрсөн 8, 9 сараас хойш сумын соёлын төв өөрсдийн үйл ажиллагаа явуулсан зардлаа буцааж авах боломжгүй байдалтай байгаагаа хэлсэн. Цалин хөлс урсгал зардлаас гадна өөр ямар ч нэмэлт урамшууллуудыг аваагүй. Юун соёлын үйл ажиллагаа явуулах, ажиллах. Энэ бололцоог нь бас хангаагүй. Тэгэхээр энэ ингэж ажиллаж байгаа хэр нь, ийм байгаа хэр нь 100 хувь бид ажилласан гэж ингээд дүгнэх нь зөв юм уу гэдэг эхний асуулт байгаа юм.

Мөн соёлын яаман дээр харьяалагдаж байгаа залуучуудтай холбогдолтой асуудал дээр 1 заалтыг 2024-2028 онд оруулж ирсэн. Энэ 5 заалтын хэрэгжилтүүдийг дахиад задлаад та бүхэн ярь. Энэ залуучуудын яамтай болсны тодорхой үр дүн гаргахын төлөө яг юу хийж байна вэ? Төсөв дээр үндсэндээ 200-хан сая төгрөг тавьсан. Тухайн үед тэгэхдээ коммунистын оронд дуудаад залуучуудаа ойлгохгүй гээд ингээд юу зэмлээд зөвхөн төсвөөс биш бусад байдлаар шийднэ гэж ярьсан. Тэгээд яаж шийдсэн юм? Тэрийгээ тэр тайлангаа танилцуул. Залуучуудын чиглэлээр 5 арга хэмжээ хэрэгжүүлэх ажлууд бүгд хэрэгжээгүй гэдэг ийм тайлан үндсэндээ яг үнэндээ орж ирсэн байна.

Бүсчилсэн хөгжил, Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууя. Зүүн бүс нутгийн хувьд эрчимжсэн хөдөө аж ахуй, түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болно гэдэг ийм зорилтыг тавьсан. Энэ утгаараа бүсчилсэн хөгжлийн гол ажил дээр би танд бүр уншаад өгчихье. Зүүн бүсийг түүхийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх хүрээнд Бурхан Халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтан овоо, түүхэн аялал жуулчлалын газар нутгийг дэд бүтцээр холбох, усан боомт болон олон улсын 4 Си нисэх буудал байгуулна гэдэг зорилтыг бид нар дэвшүүлсэн. 20 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн байгаа. Хийсэн ажил нь Засгийн газраар Буйр нуурыг чухал юм гэдэг тогтоол баталсан. Ингээд 20 хувь гээд дүгнэчихсэн. Тэр тогтоол ямар өндөр хувьд хувь дагуулдаг юм бэ? Өөр ямар ажлууд энэ 20 хувьд чинь бас орж байгаа юм бэ гэдгийг нэмээд юу асууя. Яг үнэндээ зүүн бүс нутаг бүтсэн хөгжлийн хүрээнд хийгдсэн ажил 2025 онд бараг байхгүй.

Хөдөө аж ахуйн яамнаас бас нэмээд дэлгэрүүлээд хариулья. Хүнсний хувьсгалын хөтөлбөр, Шинэ хоршоо хөдөлгөөн нэмээд Цагаан алт нөгөө 4 хөтөлбөрийн маань үр дүнгээ бас танилцуулж жилийн дүнгээ сонсьё.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлийн зээлийн эргэн төлөлтөө бас харъя. Хөдөө аж ахуйн салбарын суурь үзүүлэлтүүд сайжирч байгаа. Евро Азийн хэлэлцээрийн бэлтгэл ажлуудыг бас хэрхэн хангаж байна? 2025 онд юу хийгдэв гэдэг асуултуудыг асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ хөдөө аж ахуйтай холбоотой асуудал? Эдийн, засаг хөгжлийн яам, Хөдөө аж ахуйн яам 4 номер.

**Б.Бат-Эрдэнэ:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Бат-Эрдэнэ. Соёлын энэ хүртээмжтэй холбоотой ер нь 25 онд нийт манай яамны хувьд 83 арга хэмжээ төлөвлөсөн. 83 арга хэмжээнээсээ 43 арга хэмжээ нь 85-100 хувийн үнэлэлттэй. 15 арга хэмжээ 60-аас 70-90 хувийн үнэлэлттэй. 9 арга хэмжээ огт үнэлэгдээгүй байгаа. Энэ төсөв мөнгөтэй холбоотой, төсөв батлагдсантай холбоотой асуудлууд байгаа юм.

Хоёр дахь асуудал нь болохлоор залуучуудтай холбоотой, залуучуудын чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаа бодлоготой холбоотой асуултууд хариулъя.

Мэдээж 25 онд залуучуудын чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ хийж хэрэгжүүлснээс сургалттай холбоотой, залуучуудын хөгжилтэй холбоотой, мөн залуучуудын гэр бүлийн энэ тай холбоотой арга хэмжээнүүдэд нь 70-90 хувьтай одоо ингээд хэрэгжилт нь үнэлэгдсэн байгаа.

Мөн 26 онд төсөв дээр Ганхүлэг гишүүний хэлж байгаагаар яг залуучуудын бодлого дээр 200 сая төгрөг л ер нь тавигдсан байгаа. Тийм болохлоор яг бид нар 26 онд тэр хүрээндээ ажлуудаа төлөвлөөд бусад эх үүсвэрээс болон олон улсын донор байгууллагуудаас ер нь хамтын ажиллагааны хүрээнд хэд хэдэн төсөл, арга хэмжээнүүдийг нэмж хийж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Өөр? Эдийн засаг, хөгжлийн яам 3 номер.

**И.Батхүү:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Евроазийн эдийн засгийн холбоотой байгуулсан чөлөөт худалдааны түр хэлэлцээр Монгол Улсын Их Хурлаас өнгөрсөн оны намрын чуулганаар соёрхон батлагдсан. Нөгөө талын 5 улсаас 4 улс нь дотоод процедураараа соёрхон батлуулах процедур процесс нь дууссан. Ганц Армен Улс үлдсэн байгаа. Тэгэхдээ эдгээр улсуудтай Эдийн засаг, хөгжлийн яамнаас байнга Евроазийн комисстой хамтарч ажиллаад хамтарсан зураглал байгуулах, хамтарсан хороо байгуулах энэ хэлэлцээрийн ач холбогдол үр дүнг үр өгөөжтэй хэрэгжүүлэх талаар мэдээлэл түгээх ажлуудыг хийгээд явж байгаа.

Тухайлбал, нийт 46 заалттай Евро Азийн эдийн засгийн комисстой хамтарч хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргачихсан байгаа. Мөн дотооддоо дотоодын яам, агентлагууд, холбогдох байгууллагуудын бэлэн байдлыг хангах чиглэлээр 11 чиглэлээр 99 зүйл, заалттай төлөвлөгөө бас боловсруулаад батлаад хэрэгжүүлж эхлээд байгаа юм.

Дээр нь нэмээд Эдийн засаг, хөгжлийн яамны хажууд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах төв дээр Арьс ширний үйлдвэрлэгчдийн холбоо.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номер сунгая.

**И.Батхүү:** Мах, махан бүтээгдэхүүн экспортлогчдын холбоотой энэ хэлэлцээрийн бэлтгэл байдлыг хангах, ямар асуудлууд дээр бэлэн байдлаа хангах вэ гэдэг дээр хэлэлцүүлгүүдийг цуврал байдлаар хэлэлцүүлээд уулзалт хийгээд явж байгаа.

Зүүн бүсийн түрүүн бүсчилсэн хөгжлийн асуудал маань Шадар сайдын ажлын албаны Даваажаргал дарга хариулах байх.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ чуулганд нөгөө хурал бойкотлоод байдаг гэдэг хэдэн гишүүд чинь л сууж байна даа уг нь идэвхтэй. Энхбатын Болормаа.

**Э.Болормаа:** Чуулганы завсарлагаагаар Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудад ажиллах үеэр аймаг болон сумуудад иргэдээс хамгийн их олон давтамжтай асуугдсан асуултыг асууя. Өнөөдөр бид 2025 оны тайланг хэлэлцэж байна. Тэгээд 2025 онд хөдөө орон нутагт энэ малчдын хувьд Засгийн газраас 1 сарын 1-нээс авхуулаад хамгийн өндөр хүлээлттэй байсан Малчны тухай хуулийн дагалдах журам хэзээ батлагдах вэ гэсэн энэ асуултыг асууя.

2024 оны 6 сард батлагдсан Малчны тухай хуулийн заалтаар юу гэж заасан байгаа вэ гэхээр малчдын нийгмийн даатгалын нөхөн төлбөрийг хийж болох энэ заалтыг нээгээд энэ хэрэгжихийн тулд дагалдах журмыг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна гэсэн байгаа. Тэгээд 2025 оны 1 сарын 1-нээс эхэлж хэрэгжсэн энэ хуулийн дагалдах журам яагаад өнөөдөр хүртэл батлагдаагүй байгаа вэ? Тэгээд өнөөдрийн асуултад улс төрч нар биш яг Төрийн нарийн бичгийн дарга нар маань яг хариуцаж байгаа албан тушаалтнууд хариулж байгаа учир та бүхэн маань яг энэ хуулийг хэрэгжилтийг хангаж чадахгүй байгаа бодит шалтгаанаа маш тодорхой хэлж өгнө үү гэж асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ? Хөдөө аж ахуйн яам.

**Т.Жамбалсүрэн:** Болормаа гишүүний асуултад хариулъя Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Мөн бас хэд хэдэн гишүүний асуултад бас манай салбарын зарим хариултууд орхигдоод явчих шиг боллоо.

2025 оны эдийн засгийн өсөлтийн дүнгээр Монгол Улсын эдийн засгийн ДНБ-ний 6.8 хувийн өсөлттэй байсан. Энэ дотор хөдөө аж ахуйн салбар нэлээд өндөр өсөлттэй буюу 2.9 хувийн өсөлттэй. Энэ маань өөрөө Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний үр дүн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэх зорилготой “Цагаан алт” хүнсний хөтөлбөр, Атрын-IV аян, Шинэ хоршоо гээд эдгээрийн нөгөө харилцан уялдаа бүхий 4 хөтөлбөрийн үр дүн юм гэж бас хэлэх байна.

Өнгөрсөн онд бас хөдөө аж ахуйн салбарт, махны салбарт бас нэлээдгүй өндөр ахиц гарч, 85.6 мянган тонн мах экспортолж хамгийн өндөр экспортыг хийсэн. Ноолуурын салбарт нэлээд өндөр ахицтай экспортыг хийсэн. Энэ чиглэлээр бас холбогдох дэлгэрэнгүй тайлангуудыг нэр бүхий гишүүдэд бас задалж хүргүүлье. Ялангуяа Хүнсний хөтөлбөр Атрын-IV аян, Цагаан алтны хөтөлбөрүүдийг суурь түвшин, хүрсэн түвшин.

Өнөөдөр байгаа асуултууд дээр Малчны тухай хууль дээр 6 төрлийн журам боловсруулах ажил байгаа.

Нэгдүгээрт нь малчны орон сууцын ипотекийн зээлд хамруулахтай холбоотой, малчны хүүхдийг их, дээд сургуульд сургахтай холбоотой, эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээнд хамрагдах хүсэлт гаргасан малчныг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүр үнэ төлбөргүй хамруулах, малчны ар гэрт нөхөн төлбөр олгохтой холбоотой, гамшигт болон аюулт үзэгдэл нийт мал сүргийнхээ 50-аас доошгүй хувь нь өртсөн малчин өрх, эсвэл хонин толгойд шилжүүлснээр 250 хүртэл малтай, эс үгүй бол 16-40 хүртэлх насны малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулах, нийгмийн даатгалын шимтгэлийг 1 удаа нөхөн төлүүлэх гээд энэ 6 төрлийн журмыг боловсруулахаар тусгагдсан.

Энэтэй холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхтэй холбоотой журмыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас өнгөрсөн онд боловсруулж батлуулахаар ажилласан. Уг журамд салбарын яамнуудаас бас тодорхой саналууд хүргүүлсэн. Энэ чиглэлээр хамруулахтай холбоотой 30-40 тэрбум төгрөг шаардлагатай болсон. Санхүүгийн эх үүсвэр нь төсөвт тусгагдаагүй. Төсөвт тодорхой ачаалал үүсэх эрсдэлтэй гэж тухайн журмыг баталж хэрэгжүүлж чадаагүй. 2026 оны эхний улиралд багтааж боломжийг бүрдүүлнэ гэж ажилласан боловч тухайн Малчны тухай хуулийн 16.1-д зааснаар НДШ-ийг нөхөн төлүүлэх хугацаа 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр дуусгавар болсон байгаа. Тэгэхээр энэ хэрэгжих хугацааг сунгах, эсвэл Улсын Их Хурал дээр хэлэлцэж шийдвэрлэх ийм шаардлага үүсэж байгаа. Тэгээд энэ чиглэлээр манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Болормаа гишүүн.

**Э.Болормаа:** Үндсэн хэлж байгаа хариултад бол санхүүгийн эх үүсвэр байхгүй учир энэ журам батлагдаагүй байгаа гэж ойлголоо. Ихэнх асуудлууд яг энэ дээрээ бас тулгамддаг. Бид нар Улсын Их Хурлаар хэдий сайн хууль баталсан ч гэсэн ингээд дагалдах журмуудыг нь батлахгүй, үүнээсээ болж ингээд ажил гацдаг. Тэгэхээр дараагийн төсвийн тодотголыг ийг магадгүй өнөөдөр бас хариултуудад хэлж байх шиг байна. Эдгээр асуудлуудыг тусгана гэхэд бид нар эндээ бас хариуцлагатай хандмаар байна. Яг энэ дагалдах журмынхаа шаардагдах төсвийг бүгдийг нь та бүхэн маань төсвийн хүрээгээ боловсруулаад эхлээд шат шатдаа боловсруулахдаа үүнийгээ заавал оруулаарай гэж хүсмээр байна.

Одоо энэ геополитикийн нөхцөл байдал өчигдөр бас гишүүд хэлж байсан. Энэ зөвхөн дэлхийн нефтийн асуудал биш болж байгаа. Энэ бордооноос авхуулаад ер нь хүнсний салбарт, хөдөө аж ахуйн салбарт маш том эрсдэл ирэх гэж байгаа. Тэгэхээр бид нар жил, 2 жилийн өмнөх баталсан хуулийнхаа дагалд.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Болормаа гишүүнд 1 минут.

**Э.Болормаа:** Жил, 2 жилийн өмнө баталсан хуулийнхаа дагалдах журмыг нь өнөөдөр хүртэл ингээд баталж чадахгүй байхад энэ эрсдэлтэй үед салбарын яам маань маш хариуцлагатай, бодлоготойгоор өөрсдийнхөө мэргэжлийн дуу хоолойгоо хариуцаж байгаа болон хариуцах гэж байгаа сайд нартаа сайн хурдтай уламжлаарай гэдгийг бас хэлмээр байна.

Тэгээд Улсын Их Хурлын зүгээс энэ баталсан хуулийнхаа дагалдах журмыг та бүхнээс батлахыг шаардана. Өнөөдөр Ерөнхий сайд сууж байгаад гарчихлаа. Би маш тодорхой цаг хугацааг сонсмоор байна. Энэ Засгийн газар эргээд ороод ирсэн байна л даа Ерөнхий сайд. Учрал сайд аа энэ асуулттай холбоотойгоор энэ Малчны тухай хуулийн дагалдах журмыг буюу нийгмийн даатгалынхаа нөхөн төлбөрийг нь нээх та батлалцаж байсан энэ 2024 оны хуулийн хэрэгжилт дээр маш тодорхой цаг хугацааг сонсмоор байна. Хэзээ энийгээ хийх вэ гэдгийг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд Учрал.

**Н.Учрал:** Орон нутагт уулзалт хийсэн. Тэгээд тэр үеэр нөгөө Малчны хууль, Малчин өрхийн эрх зүйн байдлын хууль гээд малчидтай холбоотой дүрэм, журмууд гараагүй талаар бас малчдаас маш олон саналуудыг бас илэрхийлж байсан. Тэгэхээр энэ тухайн үед би бас энэ Малчны хуулийн дүрэм, журмуудыг энэ Засгийн газар гаргаж шаардана гэж бас үгийг хэлсэн. Тэгэхээр Малчны хуулийн холбоотой журмуудыг батлах хэрэгтэй. Тэгээд би энийг сайд нарыгаа томилсны дараа салбарын сайдуудаа шахаж энэ журмуудыг гаргана.

Бас үнэнээ хэлэх хэрэгтэй. Идэрбат гишүүнээр ахлуулаад Малчны хуулийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийг Их Хурал дээр байгуулчихсан байгаа. Тэгэхээр Идэрбат гишүүн та ажлын хэсгээ хуралдуулаад ямар ямар заалт нь хэрэгжээгүй юм бэ гээд.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайдад 1 минут.

**Н.Учрал:** Гаргаад та над руу хүргүүлбэл их сайн байна. Мөн энэ төсөвтэй холбоотой асуудал учраас энэ хууль дээр хэрэгжихгүй байгаа заалтуудыг төсөв мөнгөндөө шаардлагатай өөрчлөлт оруулаад нэг талд нь гаргах хэрэгтэй. Бүх зүйл мэдээж хүслээр болохгүй учраас үүн дээр бид нар дүгнэлт өгнө өө. Тэгээд танд би Болормаа гишүүнд эргээд мэдээлье. Та Идэрбат гишүүн ажлын хэсгээсээ Засгийн газарт яг энэ энэ заалтууд нь хэрэгжихгүй байна гэдгээр илгээчихвэл сайн байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Ерөнхий сайдтай тавигдсан асуудалтай холбогдуулаад ер нь хөдөө орон нутагт ажиллаж байхад энэ малчдын энэ нийгмийн даатгалын нөхөн төлөлтийн асуудал бол маш хурцаар яригдаж, мөн энэ шийдвэр буюу энэ хуулийг хэрэгжүүлэх тэр дагаад гарах тэр журмын хэрэгжилтийг хүлээсэн маш олон хүмүүс байгаа.

Ер нь зүгээр ганц ер нь малчидтай холбоотой ганц энэ заалт биш, тэр хүүхдийг нь сургуульд сургах, ипотекийн зээл, хөнгөлөлттэй зээл гээд маш олон хуулийн заалтууд байгаа боловчиг амьдралд хэрэгжихгүй талаар иргэд олон нийтээс ялангуяа хөдөө орон нутгийн малчдын зүгээс маш их гомдлууд тавьж байгаа. Уулзалт болгон дээр ярьж байгаа.

Тийм учраас Улсын Их Хурлын дарга байхдаа Учрал даргын хувьд ер нь энэ малчдын хууль, малчны ер нь эрх зүйн зохицуулалтын хэчнээн хууль байна тэрийг яаж зохицуулж байгаа талаар судалгаа хий гэсэн. Бид энэ судалгааны ажлыг эхлүүлчихсэн явж байгаа. Удахгүй хариу гарна гэж ингэж үзэж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гомбын Ганбаатар гишүүн.

**Г.Ганбаатар:** Оройн мэнд. Энэ удаагийн улсын хөгжлийн 25 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Засгийн газрын 24-өөс 28 оны энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээ хийсэн мэдээлэл цаг үеэ олсонгүй гэж бодож байна. Яг Засгийн газар огцорчихсон тэгээд нэг хэсэг нөхдүүд шинэ Засгийн газарт орж ажиллах сонирхолтой нөхдүүд тийшээгээ гүйгээд алга болчихсон. Манай, танай гэхгүй янз бүрийн яриа энэ ордон дотор яваад гүйлдээд л байх шиг байна. Ийм үед ингээд тайлан хамгийн чухал юмаа бид нар хэлэлцэж байдаг. Уг нь энэ чинь улсынхаа хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт ямар байгааг л ярих гээд байгаа юм шүү дээ.

Гэтэл одоо байж байгаа царай нь ер нь бараг сүүлдээ хүнгүй боллоо л доо энэ заал. Яах вэ хэдэн Төрийн нарийн юм байна. Өчигдөр шинээр сонгогдсон Ерөнхий сайдад нэгдүгээрт баяр хүргэе.

Хоёрдугаарт нь таныг шинэхэн будаг нь ханхалсан дээр чинь энэ улс орноо энэ авлигад живж байгаа энэ улс орноо яаж аврах бодол, төлөвлөгөө байгаа юм бэ гэдгийг чинь асууя. 15 онд Монгол Улс 175 орноос 72-т орж байсан улс өнөөдөр сая 25 оныхоо индексээр 182 орноос энэ чинь хэдэд орчхов 124-д орчихлоо шүү дээ. Үндсэндээ сүүлийн 10 жил та хэдийгээр өчигдөр шинээр Ерөнхий сайдаар томилогдож байгаа ч гэсэн энэ улс орны удирдах бүрэлдэхүүнд ажиллаж байсан хүмүүсийн нэг.

Сүүлийн 10 жил энэ улс орон чинь авлигын индексээрээ 52 байр ухарчихлаа. Бид энд хэчнээн сайн сайхан юм яриад тэнд ард иргэдийн амьдрал сайжрахгүй, амьдралын чанар сайжрахгүй байгаа нь энэ авлигын индекстэй холбоотой шүү дээ. Та яг энэ тайлан хэлэлцэж байгаа үед энэ байр сууриа ард иргэддээ хэлчих хэрэгтэй байна. Цаашдаа ер нь авлигатай тэмцэнэ гэдэг чинь та өөрийнхөө намтай тэмцэнэ гэсэн үг шүү. Та намын дарга хүн. Энэ сүүлийн 10 жилийн энэ авлигал, хулгай гаарсан. Та нарын тэр ярьж байгаа тоо эд нар бол хэдэн сая доллароор ярьж байна лээ шүү дээ. Энэнтэйгээ яаж тэмцэх юм бэ гэдэг асуудал байна.

Хоёрдугаарт нь тэр өчнөөн юм, хүн болгон л манай гишүүд болгон л асуух шиг боллоо. Үгүй. энэ улсын хөгжлийн төлөвлөгөөнд огт үр дүн байхгүй, дүгнэгдээгүй “0” үнэлгээтэй нь маш ийм олон арга хэмжээ байна. Энэ бүүр ингээд тэгээд ингээд ингээд ийм “0” дүгнэгдсэн өөрөөр хэлбэл огт хэрэгжээгүй арга хэмжээнүүдээ цаашид яах юм энэ тухайн салбарын сайдтай нь хариуцлага ярих

ёстой юм уу, салбарын төрийн нарийнтай нь хариуцлага ёс ярих ёстой юм уу? Ер нь цаашдаа энэ чинь төлөвлөгөөг яах гэж гаргадаг юм? Хэрэгжүүлэх гэж хийх гэж л гаргаж байгаа шүү дээ. Гэтэл ийм их олон ажил, дээрээс нь дөнгөж 48 аравны, энэ чинь үндсэн гол чиглэлүүд чинь 48 аравны, хэдтэй бэ 5.

100 хувь ажил хийхээс дөнгөж 48.5 хувьтай л байж байна. Тэгээд энэ дээр Ерөнхий сайдаас энэ 2 асуудал дээр байр суурийг нь сонсьё гэж бодож байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд Учрал.

**Н.Учрал:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Би юу хийх вэ гэж. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг батлан гаргасан 68 нэр төрлийн мэдээллийг ил болгосон. shilen.gov.mn дээр 820 мянган юнит /unit/мэдээллийг Цахим хөгжлийн сайд байхдаа ил болгож байсан. Одоо энэ 820 мянган мэдээллийг дахиж шахаж шаардаж мэдээллийн ил тод байдлыг хангуулна. Шилэн ажиллагааг үргэлжлүүлнэ гэдгийг хэлье.

Дээрээс нь өчигдөр би хэлсэн зөвшөөрлийг зөвхөн цахимаар олгоно. Хүний оролцоог бууруулна. 110 зөвшөөрлийг мэргэжлийн холбоодод өгөх эрх зүйн орчныг парламент одоо энэ анхны хэлэлцүүлгийг хийгээд батлаад өгчихвөл бүх шатад хүний оролцоогүйгээр энэ зөвшөөрөл гаргах ажлуудыг шийдэж хэрэгжүүлнэ. Төрийн ил тод байдлыг хангуулах ажлуудыг хийнэ. Яагаад вэ гэвэл “Транспэрэнси Интернэшнл” байгууллага манайд зөвлөмж өгсөн. Хараат бус, ил тод байдал, хүртээмжтэй, шударга ёсыг ханга, авлигын хохирогчдыг шударга ёсонд хүрэх боломжоор ханга, шүгэл үлээгчийн хуулийг батлан гарга. Төрийн үйлчилгээгээ зөвхөн төр өөрөө олгодог биш олон талын оролцоотой мэргэжлийн холбоонууд руу шилжүүл, мөн энэ ял завшаад байгаа асуудлыг шийд гэсэн.

Тэгэхээр Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиглэлийнхээ хүрээнд нэгд сая цахимжуулалтын ажлаа явуулна.

Хоёрт, хөрөнгө хураах хуулийг Эрүүгийн процессын хуультай уялдуулаад авлигын хуульд өөрчлөлт оруулаад Засгийн газраас өргөн мэдүүлнэ. Ял завшихаас, ял завших дээр тодорхой үйлдэл хий гэсэн энэ зөвлөмж.

Гуравд, Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн байдлын хуулийг батална. Ингээд “Транспэрэнси”-гийн тавьж байгаа зөвлөмжүүдийг биелүүлнэ. Олборлох салбарын ил тод байдлын хуулийг одоо өргөн барьчихсан байгаа. Хэлэлцүүлнэ. Үүний дараа уул уурхайн салбар дахь ил тод байдлыг бодитой хангуулна. Би бас The Open Government Partnership-ийн хуралд олон удаа оролцсон. Нээлттэй засаглалын түншлэлийн хүрээнд энэ авлигын индексийг бууруулах ажлыг хийнэ гэдгийг танд хэлье. Тэгэхээр бодитой ү үр дүн гарна. Хууль зүй, дотоод хэргийн яамыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудалд онцгой анхаар гэдгийг шахаж шаардана. Хууль, эрх зүйн орчин шинэчлэлээс гадна хуулийн хэрэгжилтийг шаардана. Хууль баталдаг, хэрэгждэггүй. Их Хурлын гишүүд бүгд үүн дээр шүүмжлэлтэй ханддаг.

Тийм учраас Засгийн газар хууль хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй. Хууль хэрэгжилтийг шагна. Биелэхгүй олон хуулиуд байвал би Их Хуралд хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналаа өргөн мэдүүлнэ. Тэгээд өнгөрсөн хугацаанд

манай улс цахим засаглалын индексээр 28 байр урагшиллаа. Дээрээс нь тэр зөөлөн хүчний индексээр урагшилсан. Бусдаар энэ чинь урагшилж дэвшсэн индексүүд алга байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудлууд дээр би онцгой анхаарах болно гэдгийг Ганбаатар гишүүнд бас хариуцлагатай хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганбаатар гишүүн 1 минут.

**Г.Ганбаатар:** Авлигатай тэмцэх асуудал дээр яах вэ нээлттэй, ил тод ойлгож байна. Ер нь ний нуугүй хэлэхэд энэ улс орон танай намын хурган дарга нарын хулгай нүүрлэсэн улс болчихлоо шүү. Өөрсдөө мэдэж байгаа байх. Хэчнээн сая доллароор хэдэн юу яасныгаа ингээд өөрсдөө ил тод та нар сая яриад байна. Өмнөх Ерөнхий сайд чинь би хулгайтай эвлэрэхгүй гээд ил тод зарласан. Та авлигатай эвлэрэхгүй байна гэдгийгээ бас ингээд олон нийтдээ ил тод зарлах хэрэгтэй байна.

Хоёр дахь нь миний энэ “0” дүгнэлт, өөрөөр хэлбэл хэрэгжээгүй энэ олон ажлын жагсаалт байна. Үүнийгээ яах юм бэ? Энэ хэрэгжүүлж чадаагүй салбарын сайд нар нь хэрвээ энэ дотор байгаа бол ахиж сайд болох ёсгүй. Дээрээс нь асуудал нь юундаа байгаа юм? Төсөв мөнгөндөө байгаа юм уу, биелэх боломжгүй юмыг төлөвлөгөөндөө оруулчихсан байгаа юм уу энэ мэтийгээ яах юм бэ гэдэг хоёр дахь асуулт дээрээ би хариулт авсангүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** 24 оны төлөвлөгөөний гүйцэтгэл хэлэлцээд байгаа юм бид нар. Тэрнээс хойшоо хэд хэдэн удаа тодотгол хийчихлээ шүү дээ. Тодотгол хийсэн мөртөө жилийн төлөвлөгөөгөө өөрчилдөггүй. Тодотгол хийсэн мөртөө 4 жилийн үйл ажиллагаагаа, хөтөлбөрөө өөрчилдөггүй. Мөрөөдлийн олон жагсаалттай. Тийм учраас би төрийн албан хаагч нарыг бүгдийг нь бас буруутгаж чадахгүй. Яагаад гэвэл тодотгол хийгээд мөнгө төгрөг нь хүрэхээ болиод, орлого нь багасгаад эхлэхээрээ тодотгол хийдэг.

Гэтэл нөгөө жилийн төлөвлөгөөнд нь мөрөөдлийн жагсаалтууд нь байж байдаг. Тэгээд тодотгол хийж байвал, төсөв хэлэлцэж байвал жилийн төлөвлөгөөгөө заавал хөндөнө. Дээрээс нь таны хэлснээр үнэхээр хариуцлагагүй ажилласан албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг би сонсож байгаад үүрэг даалгавруудыг биелүүлээгүй бол тухай тухайн төрийн албан хаагч болоод улс төрийн албан тушаалтнуудад үе шаттайгаар хариуцлага тооцно. Дээрээс нь би авлигатай эвлэрэхгүй. Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг бол миний тэргүүлэх чиглэлийн ажил байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цэвэгдоржийн Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний тайлан хэлэлцэж байгаа. Тэгээд энэ дээр бас хууль, эрх зүйдээ бид нар бас засаж залруулах, амьдралд нийцүүлэх ийм шаардлагууд зөндөө байна аа. Шалгуурууд нь ч зөрүүтэй, гаргасан дүгнэлт ч зөрүүтэй ийм асуудал байна. Тэгэхээр энийг хэдүүлээ бас дараа жил бас юу юугүй болно. Тийм учраас энэнээс өмнө энэ асуудлуудаа цэгцэлье. Энэ хөгжлийн төлөвлөгөөг бид хэд бас энэ Улсын Их Хурал

ч гэсэн батлахдаа тийм бодитой биш байдлаар, бодитой баталж бас чадахгүй байгаа ийм зүйл анзаарагдаж байна.

Дээрээс нь энэ дээр эдийн засгийн өсөлт өндөр тоо гарч байна. 6.8. 1 хүнд ноогдох ДНБ 7000 доллар гээд ингээд энэ олон тоонууд, өсөлтүүд харагдаад байна. Тэгээд энэ дээр нэг зүйл байхгүй байгаа нь өрхийн хаалгаар энэ өсөлтүүд орж ирэхгүй байна. Айлын хаалгаар. Тэгэхээр бас бид бүхэн бас энэ хөгжлийн төлөвлөгөө, төлөвлөлтөө бас эргэж харж амьдралд нийцүүлж гэсэн ийм зүйлийг хэлье.

Тодорхой 2, 3 асуулт байна. Энэ Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх хэлэлцээр, онгоцны түлшний хэлэлцээр хоёр ер нь хаана явна? Энийгээ хурдан баталчих байсан юм. Бид хэд бас улс төржиж байгаад энийг батлаагүй. Одоо нөгөө хойд хөршийнхөө өөдөөс гаргаад барих цаас байхгүй. Тэр үед гэгээн минь бараг л Чингис хаан буудлаа алдлаа, Оросын хараат боллоо энэ тэр гээд л байсан. Одоо яг энэ ямар шатад явж байна? Энийг баталчихсан бол бид нар бас өнөөдөр ийм асуудал, үнийн асуудал энэ тэрд орохгүй. Төрийн нарийн бичгийн даргаас өнөөдөр Дорнод аймагт 1 литр дизель түлш ямар үнэтэй байгааг асууя. Мэдэж байгаа юу үнийг нь? Маргааш дахиад 650 төгрөгөөр дахиад нэмэгдэнэ гэхчхэн. Одоо тэнд бүүр бужигнаан болж байна. Хүмүүс сав савандаа түлш нөөцөлж авах гээд бужигнаан болж байна. Тэгэхээр энийгээ Үнийн зөвлөл дээрээ ер нь ярьсан юм уу? Тэгэхээр энэ талын асуултад хариулж өгөөч. Одоо энэ үнэ чинь ингээд өсчихөөр энэ хаврын тариалалт бид нар яах вэ? Эргээд энэ нөгөө бид нарын яг энэ дайн байлдаан, геополитикийн энэ цаг үед хамгийн их хэрэгтэй хүнсний асуудал чинь дахиад л хүндрээд явчихна. Улаан буудайн тариалалт тэгээд намрын хураалт энэ тэр гээд асуудал. Тэгэхээр энэ дээр дорвитой ярьж, гялс арга хэмжээ авмаар байна.

Хоёрдугаарт, энэ “Алт-3” хөтөлбөр юу болсон бэ? Дэлхий дээр алтны үнэ бүр рекорд тогтоогоод унц алт 6 мянга бараг 300 ч хүрлээ. Монгол төгрөгт шилжүүлэх юм бол 1 кг алт 700 сая төгрөг давлаа. Энийг бид нар ашиглаж чадсангүй. Уг нь бид нар уг нь энийгээ ашиглаад яг энэ цаг үед алтаа олборлоод энэ үнэтэй болж байх үед нь бас сууж байсан бол манай эдийн засагт маш том боломж байлаа. Тэгээд энэ маань ямар энэ хөгжлийн төлөвлөгөө ярьж байгаа энэ дотор орсон юм гэдгийг бас хэлье.

Дээрээс нь бид бүхэн энэ ерөнхийдөө энэ 2 хөрштэйгөө дэлхий ч бүүр цаашаа 2 хөрштэйгөө хийсэн хэлэлцээр, яриа, гэрээ энэ юм хумандаа бас сууж баймаар байна. Бид бүхэн нэг л тийм үгэндээ суудаггүй, барьцгүй тийм имиштэй болчихоод байна. Тэгэхээр энийгээ хэдүүлээ бас цааш цаашдаа анхаармаар байна.

Ерөнхий сайдаас 1 асуулт асууя. Энэ хүн болгон л хэмнэх, орон тоо цөөрөх гээд юм ярьж байна. Та бид хэдийн бас ярьж байсан асуудал энэ Цөмийн энергийн агентлагийг та цаашдаа Ерөнхий сайд болж байгаа юм чинь ямар байгуулах вэ, яах вэ гэдэг дээр тодорхой хариул.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал Ерөнхий сайд хариулья.

**Н.Учрал:** Тооцоо, судалгаагүй зүгээр төрийн албаны хэмнэлт хийнэ гэдэг нэр гоё юм шиг сонсогдоод жилийн төлөвлөгөө дээр 9 хувийн хэмнэнэ гэдгээ хар гайг бол бид нар сая амслаа л даа. Зүгээр цаг уурын хэлтэс 2-хон байсан цаг уурчаа хэмнэж хаячхаад ард нь жолооч нь, туслах нь өөр юу билээ мэргэжилтэн ингээд үлдчихсэн. Мэргэжлийн хүмүүсээ цомхотгоод хаячихсан. Орон нутагт очихоор амьдрал их өөр байгаа. Тэгээд бүх шатад 9 хувь хэмнэнэ гэхчихсэн. Яг тантай яг таны ярьж байгаатай адил.

Гэтэл зарим боомт дээр хүн нэмэх шаардлага байгаад байгаа шүү дээ. Хэмнэлт гээд л ингээд л гоё үг сонсогдоод л ингээд л зүгээр хавтгайгаар. Энийг манай гишүүд ярьдаг манай төрд ажиллаж байсан Их Хурлын гишүүд сайн мэднэ. Зарим газар хүн, хүч хэрэгтэй байгаад байдаг, зарим газрыг бүүр татан буулгамаар байдаг. Тэгэхээр Хэрэг эрхлэх дээр ажиллаж байхад чиг үүргийн шинжилгээ хийж байсан. Би одоо энэ ажил руугаа өнөөдрөөс орсон. 14 хоногийн дотор гэхэд би бүтэн чиг үүргийн шинжилгээгээ дуусгаад би нээлттэй хэлнэ. Зарим нь нэммээр байна. Зарим нь хасмаар байна. Одоо энэ Цөмийн энергийн агентлагийг бүүр байгуулах ёстой юм. Одоо жоохон үнэнээ ярихгүй бол энэ Цөмийн энергийн агентлаг чинь олон улсад харилцдаг байгууллага байхгүй юу. Нөгөө “Орано Майнинг”-тай хийж байхад Туваан сайд энийг ярьж байсан. Тэгээд л тэр хууль дагуулж орж ирсэн.

Сүүлдээ агентлаг нэмнэ, нэмэхгүй гэж байгаад батлагдаагүй болохоос биш Цөмийн энергийн агентлаг байх ёстой шүү. Энэ чинь тусгаар улс шүү дээ. Төслүүд нь яваад байдаг. Хяналт тавих хэн нь мэдэгддэггүй. Тэр зарим агентлаг, хэрэггүй агентлаг байж болно. Зарим нь бүүр хэрэгцээтэй байгаад байгаа.

Жишээ нь өчигдөр бас ярьж байсан Хууль тогтоомжийн агентлаг байгуулах байгуулах ёстой гээд. Яг энэ агентлагийг байгуулъя гэхээр өө та одоо шинэ агентлаг нэмээд байна шүү дээ гээд эхэлдэг. Зовлон байгаа юм. Тийм болохоор үнэнээ ярина. Тэгэхдээ ингээд нөгөө камерын өмнө гарч ирэхээрээ л би бүгдийг нь хэмнээд л ер нь бужигнуулаад хаячихъя гэж ярих амархан. Гэхдээ амьдрал дээр их өөр юм.

Тийм учраас чиг үүргийн шинжилгээ хийгээд тооцоо судалгаатай явуулна. Тэрнээс биш одоо ингээд маргааш би орж ирээд энэ яамыг 50 хувь болгох гэж байна гээд л ингээд сүртэй юм орж ирээд 2 хоног алга ташуулж бас болно. Гэхдээ үүний цаана түүнийг далимдуулж нөгөө хэлмэгдэл явагдана. Бүүр зүв зүгээр төрийн ажил хийж байсан хүнийг нөгөө төрийн захиргаа гэдэг нэрийг нь стратеги төлөвлөлт болгож өөрчилчхөөд л ажлаас нь чөлөөлөөд хаячихдаг.

Тэгэхээр үүнийг ингэж цогцоор нь харах, дээрээс нь төсвийн тодотгол хийж байвал жилийн төлөвлөгөөгөө өөрчлөх, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө өөрчлөх. Одоо яг нөхцөл байдал дээр нөгөө гүйцэтгэлээ 6 сард харахгүй бол орлого тасрах эсэх нь одоо бол шууд тооцоолох хэцүү байгаа байхгүй юу. Гэтэл сар болгон оруулж ирээд л тодотгол хийгээд л, бүтэц өөрчилж байна гэж тодотгол хийгээд л 14 хоногийн дараа орлого тасарч байна гэж тодотгол хийгээд л ингээд үзээд байвал энэ явахгүй л болов уу гэж би бодож байгаа юм.

Тийм учраас би Цөмийн энергийн агентлаг байх ёстой гэж үздэг. Би ч юу байх вэ энийг угаасаа олон улс шаардаж байгаа юм л даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номер.

**Б.Дашпүрэв:** Туваан гишүүний асуултад хариулъя. Эхнийх нь шатахууны асуудал. Хуучин бол 3450 төгрөгөөр зарагдаж байсан бол Үнийн зөвлөл хуралдаад 300-350 төгрөгөөр Монгол Улсын хэмжээнд нэмэгдэх ийм шийдвэр гаргасан. Тэгэхээр 3750 төгрөгөөр зарагдаад 3750-3800 төгрөгийн хооронд зарагдаад явж байгаа. Яг саяын таны хэлдэг энэ хаврын тариалалттай холбогдолтойгоор асуудал өндөр үнэтэй бүтээгдэхүүн буюу нэмэгдсэн үнэтэй бүтээгдэхүүнээрээ тариалалтаа эрхлээд явах юм бол нөгөө тариалангийн салбарт маань бас хүндрэл, чирэгдэл учруулаад талх, гурилын үнэд нөлөөлөөд ингээд инфляцад давхар нөлөөлөл үзүүлээд явна гэдэг ийм асуудал яригдсан. Энэ хүрээндээ газар тариалангийн салбарт эхний тариалалт дээр 7500 тонн дизель түлш хэрэгтэй. Ийм хэрэгцээ шаардлага байдаг. Үүнийг 100.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 минут.

**Б.Дашпүрэв:** 10 мянган тонн бүтээгдэхүүнийг 3400 төгрөгөөр шатахуун импортлогч компаниуд нийт аж ахуйн нэгжүүдэд өгнө гэдэг энэ асуудлыг ярьсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай энэ асуудлыг ярилцаад санамж бичиг байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуйн яаманд нийт 19 компанийн жагсаалтыг нийгмийн хариуцлагынхаа хүрээн дээр 3400 төгрөгөөрөө гаргаж өг өө гэдэг энэ шийдвэрийг гаргачихсан шууд хэрэгжилт нь хангагдаад эхэлсэн байгаа.

“Алт-3” хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн жил 16.3 тонн алт тушаагдсан. Энэ жил 20 тонн алт гэж үзэж байгаа. Гүйцэтгэл өнөөдрийн байдлаар 3.2 тонн буюу өнгөрсөн жилтэй харьцуулахад 46 хувийн нэмэлттэй ийм сайн тушаалтай явж байгаа.

Алт хөтөлбөрийн хүрээнд 2 зүйлийг хийж хэрэгжүүлж байна. Нэгдүгээрт нь маш богино хугацаанд аж ахуйн нэгжүүдийнхээ та мэдэж байгаа тайлан төлөвлөгөөг баталж өгөх асуудлуудыг хэлэлцүүлээд ингээд явж байна. Дараагийн нэг зүйл нь энэ урт нэртэй хуулийн буюу голын эх, ай сав.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Үнэхээр энэ 3400-гаар ядаж гэрээ хийгээд Хөдөө аж ахуйн яамтайгаа яриад шатахуун импортлогчидтойгоо ярьж чадсан бол бас баяр хүргэмээр байна. Энэ бол том ажил. Тэгэхгүй бол энэ асуудал чинь хүндэрнэ. Бүх шатахуун нэмэгдсэн үнээр орж ирээгүй байгаа тийм ээ? Тэгэхээр энийг бас яриарай.

Дээрээс нь энэ дахиад нэмэгдэх юм ярьж байна. Колонкууд тэгж ярьж байна. Тэр хэр бодитой мэдээлэл вэ? 650 төгрөгөөр нэмэгдэнэ гэсэн ийм зүйл ярьж байна. Тэгэхээр энэ асуудлыг та бас тодруулаад хэлээдхээч.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3 номер.

**Б.Дашпүрэв:** Ойрх дорнодын нөхцөл байдалтай холбогдуулаад брэнд газрын тосны бүтээгдэхүүний тосны үнэ бол 100-110 доллар болж нэмэгдсэнтэй

холбогдолтой. Оросын Холбооны Улсаас бид бүхэн бол плацын үнээр авдаг. Энэ үнээ нэмэгдэж орж ирсэн. Нийт бодит нөхцөл байдал бол 2150 төгрөгөөр нэмэгдэх ийм нөхцөлийг үүсгэсэн. Бид бүхэн 3 сарын буюу хямдхан үнэ дээр 300-350 төгрөгийг нэмэгдүүлээд явъя. Шинэ нэмэгдсэн үнэ орж ирсэн үед бас ахиад 400 төгрөг, 300 төгрөг гэдэг үе шат байж болно. Мөн гаалийн татварыг бууруулах, тэглэх гэдэг энэ асуудлыг бид бүхэн өргөн барьчихсан байгаа. Энэ бол 200-300 төгрөгийн нөлөөллийг үзүүлнэ.

Мөн дараа сарын үнэ хэрхэн тогтохтой холбогдолтой прогнозоо харж байгаад аж ахуйн нэгжтэйгээ ярилцъя гэдэг ийм зүйлийг ярьсан.

Онгоцны түлшний хэлэлцээрийн асуудал бид бүхэн өмнө нь Их Хурал дээр өргөн барьсантай холбогдолтойгоор.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Пүрэвжавын Сайнзориг.

**П.Сайнзориг:** Оройн мэнд. Уг нь чухал асуудал хэлэлцэж байгаа уг нь. Ер нь цаашдаа бас ямар асуудал дээрээ фокуслаж, ямар арга хэмжээ авах вэ гэдгээ ярих байтал бас энэ Засгийн газрын нөхцөл байдлаас болоод бас ийм завсар гарчихлаа. Уг нь төрийн үйл ажиллагаа 1 цаг 1 минут ч бас тасрах ёсгүй юм байгаа юм. Тэгэхээр бид хэд бас энэ дээрээс хууль эрх зүйн орчин дээрээ бас зарим зүйлүүдийг анхаарах ёстой юм байна л гэж бодож байна. Магадгүй шинээр Ерөнхий сайд томилогдож байгаа бол өмнөх сайдуудаа ядаж үүрэг гүйцэтгээд томилох энэ асуудал энэ тэрийг бас зохицуулаад өгөхгүй бол шинэ сайдаа томилох хүртэл хугацаанд бас ажил зогсож байгаа юм шиг, энэ сайдууд маань энд ажлаа тайлагнаж чадахгүй ийм байдалтай л гарчихлаа.

Яах вэ зүгээр эндэх асуудал яах вэ гэхэд цаана нь тэр аж ахуйн нэгж байгууллагуудын магадгүй яамны шийдвэрийг хүлээгээд явж байгаа хүмүүсийн ажлууд л бас цаг нартай ажлууд зогсох болов уу л гэж бас болгоомжлоод байна. Ялангуяа бараг энэ цаг үе дээр ингээд л Хөдөө аж ахуйн сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд ингээд л байнгын тасралтгүй ажиллаж байх ёстой шүү дээ. Тэгтэл одоо ингээд зогсож байна. Тэгэхээр энэ дээрээ бас цаашдаа анхаарах ёстой юм байна гэж бодож байна.

Тэгээд энэ 2, 3 зүйл бас бас тодруулъя. Энэ Хөгжлийн банк ер нь өнгөрсөн жил юу хийв ээ? Сүр дуулиантай 500 сая доллар ч билүү босгож ирлээ гээд дуулдсан. Тэгээд энэ 500 сая доллароор орж ирээд ямар ч төсөл, арга хэмжээг санхүүжүүлж чадаагүй ингээд байж байгаа юм байна лээ хий хүү төлөөд. Тэгэхээр энэ дээр ямар бүтээмжтэй ажиллав? Энэ алдагдлыг үүсгээд байгаа энэ асуудал дээр хэн цаашдаа хариуцлага хүлээх юм бэ? Тэгээд ингээд юмаа тодорхой төлөвлөж чадаагүй байсан бол яах гэж мөнгө босгож оруулж ирсэн юм бол?

Нөгөө талдаа ингээд яг энэ чинь өөрөө эдийн засаг буюу хувийн хэвшлийг дэмжихгүй саад болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Хөгжлийн банкны удирдлагууд хэн хариулах юм? Энэ дээрээс бас тодорхой бас хариулт өгөөч.

Хоёрдугаарт, засаглалтай холбоотой нэг зүйлийг бас Учрал Ерөнхий сайд маань бас мэдэж байгаа. Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль баталсан. Энэ хуулийн хэрэгжилтийг бас тодорхой хугацаанд хойшлуулах гэж байгаа юм байна.

Тэгэхээр хойшлууллаа гэхэд ер нь яах вэ эсвэл орон нутгийн хотуудаа түр хойшлуулж болох уу? Нийслэл дээр хэрэгжүүлж болох уу? Эсвэл бүүр нийслэлийнхээ Багануур, Налайх дээр ингээд хэрэгжүүлээд тодорхой хэсэгчилж хэрэгжүүлж үзээд үзээд үзвэл яадаг юм бэ? Та энэ дээр бас ямар байр суурь байна? Ингээд бас бие даах орон нутаг маань бие даах энд эрх мэдлийг цуглуулах биш, эсвэл нийслэлийн засаг дээр эрх мэдлийг цуглуулах биш уг нь ингэж л тарааж л ажлыг, бүтээмжийг сайжруулах энийгээ дагаад л асуудлуудаа шийддэг байх л зорилго байгаа юм л даа.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууя. Хэчнээн ажлын байр өнгөрсөн жил бүтээв, бий болгов оо? Үүний хэдэн хувийг нь хувийн хэвшил хийв ээ? Хувийн хэвшлийн хэчнээн аж ахуйн нэгж байгууллага шинээр өндийж жижгээс дунд руу шилжив? Энийг тоон статистикаар Батхүү дарга маань хариулаад өгөөч. Бүх юм сайхан болж байгаа гээд та бол хариулаад байгаа. Энэ дээр бас тоогоор бас дүгнээд хэлээд өгөөч гэж хүсэж байна.

Би тэгээд яг Учрал сайдын бас хэлж байгаа тэрийг хэрэгжүүлмээр байна. Учрал сайд аа тодотгол хийж байгаа дагаад яг Засгийн газрын бодлого нь энэ энийг царцаая ч гэдэг юм уу эсвэл хасаад яах вэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөсөө. Ядаж ингээд царцаах гэдэг юм уу иймэрхүү зүйлүүдээ байхгүй бол энд ингээд хий хий хоосон тайлагнаад тэгээд Засгийн газар тэрийг нөгөө дүгнээд үнэлгээ тавих ч хэцүү яах ч хэцүү гээд ийм сонин юм байдаг юм байна.

Тэгэхээр энийг Лука гишүүний боловсруулж байгаа тэр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуультайгаа уялдуулаад яах аргагүй ингээд тодотгол юм уу, эсвэл цаг үеийн нөхцөл байдал ийм ийм тохиолдлуудад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тодотгол заавал хийнэ гэдэг зүйлийг нь бас ингээд шийдэхгүй бол тэгээд хэрэгжүүлэх ч юм шиг, тэрийгээ бид хэд асуугаад л тэр сайдыг юм хийсэнгүй гээд байдаг. Өнөөдөр улсынхаа эдийн засгийн нөхцөл байдал, чадамжийг харахаар бас бүх зүйлийг нэг зэрэг хөдөлгөж чадахгүй шүү дээ.

Тэгэхээр одоо яг хөдөлчихсөн бөгөөд санхүүжилт нь босчихсон юмнуудаа үлдээгээд ер нь аль хэсгүүдээ ер нь зогсоох юм гэдгээ бас оруулж ирээд 1 удаадаа шийдчихвэл яадаг юм бэ гэдэг ийм. Таны бас хэлээд байгаа саналыг би дэм.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал, Ерөнхий Сайд.

**Н.Учрал:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлын хэсгийн ахлагч нь би байсан. Энэ Хот, тосгоны хуулийг сая Засгийн газар дээр Ерөнхий сайдын захирамжаар энэ Хууль зүйн сайд ахлаад ажлын хэсэг гаргасан юм байна лээ. Тэгээд 3 хувилбар танилцуулаад Засгийн газраас зарим зохицуулалтыг нь хойшлуулъя гэдэг ийм саналыг боловсруулаад Их Хурал руу өргөн барих гээд шийдсэн байна. Би энийг өөрөө судалъя. Энийг ярилцъя. Өөрөө бас энэ ажлын хэсгийг нь ахалсан хүн ажлын хэсгийн ахлагчийн хувьд зарим бас шинэчлэлүүд зайлшгүй хийгдэх ёстой хууль шүү. Бас бүхэлд нь хойшлуулаад байх нь бас зохимжтой биш. Тэгэхдээ төсөв, мөнгөтэй холбоотой асуудал мөн яригдаж байгаа юм. Тийм учраас нөгөө хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх хэрэгтэй гэж бодож байна.

Хоёрт, таны хэлж байгаа санал маш зөв. Одоо энэ Засгийн газрынхаа хуульд тодорхой өөрчлөлт оруулж цаашдаа ийм асуудал үүсвэл дараагийн Ерөнхий сайд томилогдсоноор Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ чөлөөлөгдөж байгаа сайд нар нь. Тэгэхээр тухайн ажлаа гүйцэтгэж байсан сайд нар нь үүрэг гүйцэтгэгчээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэхгүй бол хийсэн ажлынхаа гүйцэтгэлийг өөрөө тайлбарлаж чадахгүй ийм Дэгийн хуультай бид нар байж байна шүү дээ тээ? Тэгэхээр энийг бол зайлшгүй эргэж харах юм байна цаашдаа. Ер нь амьдрал өөрөө баян учраас ийм асуудлууд зайлшгүй гардаг шүү гэдгийг бас хэлье.

Тэр жилийн төлөвлөгөө ч бай, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр ч бай тодотголтой заавал хамт орж ирж ирж өөрчлөгдөж байх ёстой. Тэгэхгүй бол та нар ажил хийгээгүй гэвэл төсөв нь байхгүй юм чинь яаж ажил хийх юм бэ зарим газар дээр.

Тэгэхээр одоо Засгийн газрын түвшинд би ингэж бодож байна. Жишээ нь түрүүн хэлсэн. 2400 хүн сул орон тоо байгаа бол тэр цалин хөлсийг нь царцаана Засгийн газрын түвшинд. Заавал тэр Их Хурлаар орж ирэх хэрэггүй. Зарим төслүүд хойшлуулах гэж байгаа бол царцаана мөнгө төгрөгийг нь гаргахгүй. 5 сарын 31-нд нөгөө хуулиараа угаасаа тендер зарлагдаад эхлээгүй бол ингээд царцаана.

Ингээд үүний дараа орлого ямар байх вэ гэдгээс шалтгаалаад тодотголоо оруулж ирнэ. Тэгээд тодотголыг оруулж ирэхдээ жилийн төлөвлөгөөгөө өөрчилнө. Шаардлагатай бол 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөртөө дахиад өөрчлөлт хийнэ. Тэгэхээр маш зөв цаг байна одоо. Ингээд явъя. Тэгж байж цаашдаа дараа жилийн гүйцэтгэл ч гэсэн тодорхой байж явахгүй бол та нар жилийн төлөвлөгөөгөө өөрчлөөгүй шүү дээ 24 онд. Тэгээд тэрүүгээр чинь төсвийг нь та нар бас хасчихсан шүү дээ. Тэгчхээд бид нарыг яаж ажил хийгээд байгаа юм бэ гээд ингээд төрийн албан хаагч нар хэлээд байгаа нь бас буруу биш шүү тийм. Тэгэхээр бүгдээрээ энэ асуудал дээр онцгой анхаарч ажиллацгаая.

**Ж.Бат-Эрдэнэ:** Батхүү 3 номер.

**И.Батхүү:** Сайнзориг гишүүний асуултад. Сүүлийнхээс нь эхлээд хариулчихъя. Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээллээр 2024 онд аж ахуйн нэгжийн байгууллагын тоо 110 мянга 051 байсан бол 25 онд 116 мянган 820 болж нэмэгдсэн. Ажиллагсдын тоо сая 353 аравны 4 мянга байсан бол сая 383.6 мянга болж 2.2 хувиар буюу 30 мянга орчим ажлын байр бий болсон байна гэсэн албан ёсны тоо байна.

Хөгжлийн банкны хувьд нөхцөл байдал хүнд байгаа. Сая 3 сарын 13-ны байдлаар би танд бас нөхцөл байдлын мэдээллийг танилцуулъя. Хөгжлийн банкны 3 сарын 13-ны байдлаар нийт зээлийн 54.8 хувь нь чанаргүй болж үүнээсээ 76 хувьд нь эрсдэлийн сан байгуулах хэрэгцээ шаардлага үүссэн. Байгуулсан байна. Хуримтлагдсан алдагдлын хэмжээ 1 их наяд төгрөг болсон.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахиад 1 минут.

**И.Батхүү:** Өөрийн хөрөнгө нь 240 тэрбум төгрөг болсон байна. Орлого олдог активын дүн зардалтай пассиваасаа 550 тэрбумаар бага 10 төгрөгийн зардал гаргаад 9 төгрөг олж байгаа ийм ашигт үйл ажиллагаа нь алдагдсан ийм нөхцөл байдалтай байгаа. Яг энэ нөхцөл байдлыг засаж сайжруулах үүднээс Эдийн засаг, хөгжлийн яам, Хөгжлийн банкны шинэ гүйцэтгэх удирдлагын багийг томилоод нийт захирлуудын тоог, орон тоог нь бас 155-аас 99 болгож бууруулсан. Энэ дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Засгийн газарт танилцуулсан байгаа. 3 сарын 18-ны Засгийн газрын тогтоолоор өөрийн хөрөнгийг 1 их наяд орчим төгрөгөөр нэмэгдүүлэх арга хэмжээг албажуулаад шийдвэр нь гарчихсан байгаа. Эхний арга хэмжээ нь.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сайнзориг.

**П.Сайнзориг:** Тэгээд иймэрхүү л тоо статистикийг хэлэхээр байтугай аймаар санаа зовоод байгаа байхгүй юу. Хүнд байна гэдэг зүйлийг хэлээд байдаг. Мөнгө оруулж ирчхээд тэрийгээ зарцуулж чадахгүй. Наад хүмүүс чинь энэ Хөгжлийн банкны процессоо, шийдвэр гаргах процессоосоо ч болдог юм уу шийдвэр гаргаж зээлээ олгож чадахгүй байна шүү дээ. Бүгд нөгөө хууль шүүхийн байгууллагаар явчих ч юм болов уу гээд. Тэгэхээр анхнаасаа сайн төлөвлөмөөр байна. Ингээд өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ч гэдэг юм уу олж ирчхээд ингээд хий хоосон ингээд л төлөөд л байж байна л даа хүү та нар. Ийм нэг зүйл байна.

Хоёрдугаарт, Бат-Эрдэнэ дарга бас нэгэнт Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэж байгаа юм чинь энэ Улсын Их Хурлын Тамгын газар бас энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр хяналт шинжилгээ хийгээд үнэлгээ өгөөд байгаа юм аа. Дүгнэлт ч юм шиг. Энэ Улсын Их Хуралд тайлагнаж байгаа болохоос Улсын Их Хурлын Тамгын газар ч тайлагнаагүй байхгүй юу. Тэгэхээр бид хэдийн энэ бас их сонин тогтолцоо руу ороод байна шүү. Сүүлдээ эд нарынхаа үгээр асуудалд хандах ч юм шиг. Бид өөрсдөө бас ингээд бодож үзэх ч юм шиг ерөөсөө ийм юм юмыг л ингээд л хольж хутгаад бид нарын бас хууль, эрх зүйн орчин яваад байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дэгийн тухай хуульдаа өөрчлөлт оруулаад ер нь аудитынхаа байгууллага тэр тусмаа Улсын Их Хурлын дэргэдэх аудитынхаа байгууллагын гаргасан дүгнэлт дээр л түшиглэдэг. Тэрний гүйцэтгэл дээр хариуцлага тооцдог ийм л схем рүүгээ л ормоор байгаа юм даа.

Ерөнхий сайд.

**Н.Учрал:** Сайнаа гишүүн Гадаад зээлийн нөгөө ашиглалтын хуулийг өргөн мэдүүлчихсэн байгаа. Тийм. Тэгэхээр тэр хуулиа явуулах. Хоёрт Хөгжлийн банкнаас ер нь цаашдаа гадаад зээлийн эх үүсвэрийг дамжуулан явуулах ийм эрх зүйн орчин бүрдүүлээд өгчихмөөр байна бид нар. Тэгэхгүй бол нөгөө гадаад зээлээ ашиглаж чадахгүй нөхцөл байдалтай байгаа учраас. Ер нь бид эрх зүйн орчныг нь бүрдүүлээд Хөгжлийн банкнаас цаашдаа гадаад зээлийн эх үүсвэрийг дамжуулан явуулдаг байх, урт хугацааны зээлийг оруулахгүй бол төсөв дээр ингээд бичигдээд байхаар гадаад зээл тал нь байгаад байдаг ашиглаж чаддаггүй. Зарлага талдаа л ингээд бичигдээд ийм байдалтай байна. Тийм учраас ийм эрх

зүйн шинэчлэл хийе л гэж би зорьж байна. Тэгээд үүнийг Их Хурлын эрхэм гишүүд, Сайнзориг тэргүүтэй гишүүдийг дэмжихийг хүсэж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Банзрагчийн Түвшин гишүүн. Байхгүй байна уу? Ганзоригийн Лувсанжамц.

**Г.Лувсанжамц:** Сайн байцаана уу? Хоёр байгууллагаас асуулт асууна шүү. Эхнийх нь АТГ өнөөдөр ирсэн байна уу үгүй юү? Хоёрдугаарт нь Байгаль орчны яамнаас агаарын бохирдлын бууруулалттай холбоотойгоор зорилт болон хүрсэн үр дүнг асууна. Эхлээд та бүхэнд сая Сайнзориг гишүүн болон Ерөнхий сайдын хэлэлцэж байсан асуудлаар бас өөрийн ахалж байгаа ажлын хэсгийн ажлын явцын талаар нийт гишүүддээ уриалга хэлмээр байна. Манайх таван жилийн үндсэн чиглэлтэй. 4 жилийн хөтөлбөр, 1 жилийн төлөвлөгөө тэгээд төсөв байгаа. Энэ дөрвийг уг нь дөрвүүлэнг нь нийлүүлээд бид нар 1 л удаа тайланг энд ярьж байвал хамгийн оновчтой зөв шийдэл нь болно. Өнөөдөр бид нар 4 жилийн хөтөлбөрийнхөө 1 жилийг нь тэгээд 1 жилийн төлөвлөгөө гэсэн ийм зүйлийг ингээд хэлэлцээд сууж байгаа. Дахиад 4, 5 сараас төсвийн гүйцэтгэл гээд яриад эхэлнэ.

Тэгэхлээр Ерөнхий сайдын сая хэлж байгаа төсөв байхгүй юман дээр төлөвлөгөө дээр яаж үнэлгээ хийх юм бэ гэдэг яг зөв адилхан. Тэгэхлээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль дээр ажиллаж байгаа манай Эдийн засаг, хөгжлийн яамныхан дэмжиж ажиллаж байгаа. Өнгөрсөн 5 жилийн хугацаан дахь хуулийн үнэлгээний судалгааг нь хийлгэж байгаа. Зэрэгцээд бид нар хуулийн төслөө боловсруулаад явж байгаа учраас төрийн албан хаагчдадаа хандаж хэлье. Ямар хэрэгцээгүй тайлан байна аа? Давхардаад байгаа тайлан байна, хугацаа нь зөрөөд байдаг? Ийм саналуудаа та бүхэн манай ажлын хэсэгт хүргэж өгөхийг хүсэж байна.

Тэгээд энэ төрийн албан хаагчдынхаа болсон, болоогүй баахан тайлангаар дардаг, төлөвлөгөөгөөр дардаг энийгээ хэдүүлээ цэгцэлж аваад яг үр дүн гаргах боломжтой ажил дээрээ төвлөрөх боломжтой тийм хууль, эрх зүйн орчныг нь бий болгоё гээд ажиллаж байгаа шүү. Тэгээд дэмжиж өгөхийг хүсэж байна. Бусад гишүүд маань ч гэсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль дээр санал байвал эртхэн өгч байгаарай. Манай ажлын хэсэгт байгаа бусад намын гишүүддээ би тогтмол хэлж байгаа. Одоогийн байдлаар аль ч намаас 1 ч санал ирээгүй байгаа шүү.

Асуултдаа оръё. АТГ, нэгэнт бид нар хөгжлийн төлөвлөгөө ярьж байгаа. Гэхдээ төсвийг нь бас цугт нь заавал ярих ёстой. Төсвийн гүйцэтгэлээр ч гэсэн энэ адилхан асуултуудыг асуух учраас бусад төсвийн ерөнхийлөн захирагч маань ч гэсэн бэлэн байхыг хүсэж байна.

55 тэрбум төгрөг зарцуулна 2025 онд АТГ тийм байгаа. 4.3.1.1 хэдүүлээ ерөөсөө хөгжлийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл дандаа хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн үр дүнгийн хавсралтаа хараад л тэрийгээ л ярьцгаана. Өөр юм ерөөсөө ярьж болохгүй. Энэ дээр 4.3.1.1 дээр авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Зорилт нь авлигын төсөөллийн индексээрээ бид нар 121-д байсныг 118-д аваачна гэсэн. Бодит байдал дээр бид нар 2 оноо буураад 124 дүгээр байранд очоод ухарчихсан байна. Энэ юу ч биелээгүй.

Гэхдээ АТГ-аас шударга байдлын үнэлгээ гэдэг судалгааны тайлан гаргадаг. Энэ тайлан дээр болохлоор бид нар 2.3 хувиар ахиад олон улс бид нарыг авлигатайгаа тэмцэж чадахгүй байна гэж үнэлээд байдаг. АТГ-аас гаргаж байгаа судалгааны тайлан нь болохлоор 2.3 хувийн ахиц гарлаа бид нар гэж яриад байдаг. Чанартай КРІ буюу шалгуур үзүүлэлтээ бид нар ашиглаад явна. Энэ шударга байдлын үнэлгээ гэдэг судалгааны тайланг ямар аргачлалаар хийгээд олон улсын үнэлгээнээс юу нь өөр байгаа юм бэ гэдгийг тайлбарлах хэрэгтэй байна.

Дээрээс нь энэ тайланг гаргахад хэдий хэмжээний төсөв зарцуулдаг вэ? “Бодлогын шийдэл” гэдэг ТББ гүйцэтгэсэн байна гэж онлайнаар хайгаад оллоо.

Байгаль орчны яамнаас 261 тэрбум төгрөг 2025 онд байгаа. 2.3.1.19 дээр агаарын бохирдлыг бууруулах зорилтуудыг тавьж өгсөн. РМ 2.5 Улаанбаатар хотод 41 байгааг 31 болгож бууруулна. РМ 10-ын хувьд 82 байгааг 66 болгож бууруулна гэсэн юм. Төсвийн гүйцэтгэлээр дахиж асууна. Гэхдээ одоо байгаа та бүхэн, одоо байгаагаар та бүхэн энэ зорилт тань хэр их биелсэн бэ?

**Ж.Бат-Эрдэнэ:** АТГ-ынхан чинь байхгүй байх даа. Байгаа юу? Байхгүй байна уу? 4 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаарай.

**Ш.Батбаяр:** Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр байна. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороог байгуулж төлөвлөгөөг баталсан байгаа. Төлөвлөгөөний хүрээнд 21 аймаг өнгөрсөн жил 21 аймагт агаарын чанарын станцуудыг ашиглалтад оруулсан байгаа. Ингэснээр анх удаагаа 21 аймгийн агаарын чанарыг real time үзэх боломжтой болсон байгаа. Мөн нийслэл хот дахь нам даралтын зуухнуудыг хийн шатад шилжүүлэх ажлыг хийгдэж байна яг одоогийн байдлаар. Ингэснээр Улаанбаатар хотын агаарын бохирдлын суурийн эх үүсвэрийг 2.9 хувиар бууруулж, 10.7 хувьтай хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Энэ дээр бас төсвийн бас асуудлууд гарсан байгаа. Хэрэгжилтэд нөлөөлсөн.

Энэ жил 260 тэрбум төгрөг бол гишүүн ээ COP-17 хурлыг зохион байгуулахтай холбоотой зардал манай яаман дээр бүгдээрээ туссан байгаа. Эндээс холбогдох яамдын төсвүүд байгаа. Жишээ нь хууль зүйн, дотоод хэргийн яам байгаа. Мөн төрийн тусгай албадын COP-17 хурлыг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлын зардлууд манай яамны төсөв дээр тусгагдсан байгаа шүү. Тэгэхээр эндээс манай яг үндсэн чиг үүргийн ажилд зарцуулагдахгүй төсвүүд байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Лувсанжамц.

**Г.Лувсанжамц:** Энэ жилийн төлөвлөгөөг бид нар батлахдаа 3 засаглалынхаа КРІ-уудыг тавьж байгаа болохлоор уг нь 3 засаглалын бүх байгууллагууд энд байж байх ёстой. 36 төсвийн ерөнхийлөн захирагч нар байгаа. Эд нар маань бүгдээрээ байгаад энийгээ хариулах ёстой. Цаашдаа хууль дээр нь өөрчлөлтөөр оруулаад АТГ-ыг бас байлгая гэж бодож байна. Гэхдээ мэдээж төсвийн гүйцэтгэлтэйгээ хамтад нь хэлэлцээд явна.

Байгаль орчны яамнаас хэдүүлээ нөгөө 2 дугаар хавсралтаа л ярья гэж байгаа юм. Шалгуур үзүүлэлтээ л ярья. РМ 2.5 41 байсныг 31 болгоно гэж байгаа юм Улаанбаатар хотод. РМ10-ыг 82 байсныг 66 болгож бууруулна гэсэн зорилт тавьсан. Энэ үзүүлэлтүүд маань одоо хэд байгаа вэ?

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**Ш.Батбаяр:** Үзүүлэлтүүдийн талаар тодорхой мэдээлэл яг одоо алга байна. Би танд бичгээр хүргүүлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Лувсанжамц гишүүн тодруулъя.

**Г.Лувсанжамц:** Баярлалаа. Бичгээр хүргэнэ гэж байна. Хэдүүлээ гэхдээ дараа нь төсвийн гүйцэтгэл ярихдаа шалгуур үзүүлэлтийнхээ хавсралтыг барьж байгаад л хэдүүлээ хоорондоо ярьдаг болчихмоор байна. Хэдэн төгрөг зарцуулсан юм, ямар суурь түвшинтэй байсан юм, зорилтот түвшин нь хэд байсан юм байна, хүрч чадсан, чадаагүй гэдгийгээ хэдүүлээ тэрийгээ хараад л ярьдаг байя. Тэгвэл илүү бодлогын мэтгэлцээнтэй болно. Төсөв мөнгө нь хүрэлцээгүй ч байдаг юм уу, хөл төлөвлөгөө нь буруу байсан ч байдаг юм уу илүү нарийн зүйлүүдээ ярих боломж нь нээгдэх юм шүү.

Тэгэхлээр 2 дугаар хавсралт төсвийн 1 дүгээр хавсралт байгаа. Хөгжлийн төлөвлөгөө 2, төсвийн 1 дүгээр хавсралт эд нарыгаа харж байгаад л хэдүүлээ хоорондоо ярьцгааж байя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Мэндбаярын Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид нарт энэ тараагдаж ирсэн тайлантай танилцлаа. Тус бол тайлан ер нь яам, төсвийн ерөнхийлөн захирагч буюу сайд нарын тухайн жилийн дүнг тавьсан тайлан байх гэж бодож байна. Тэгэхээр энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол ер нь салбарын сайдын болон баг бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэл ялангуяа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 65 хувь гэж дүгнэгджээ.

Тэгэхээр энэ 65 хувь юу хэлж байна гэхлээр энэ иргэдийн өдөр тутмын амьдралын хүнс, хөнгөн үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйд тулгамдаж байгаа энэ иргэд, аж ахуйн нэгжүүдийн асуудлыг 65 хувьтай шийдвэрлэсэн гэж үзэж болох уу? Хэрэв тийм бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хувьд хамгийн өндөр татаас урамшуулал авдаг яам байгаа. Хэрэв тийм юм бол өнөөдрийн махны үнийн өсөлт, экспортын гарц, хүнсний өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, нийлүүлэлт нэмэгдэж үнийн өсөлт тогтвортой болж, импортын хамаарал буурсан гэж ойлгогдохоор байна энэ тайлангаар.

Гэтэл энэ дүгнэлттэй харамсалтай нь би бол ерөөсөө санал нийлэхгүй байна. Тухайлбал, жилийн өмнөх үхрийн цул махны үнэ 22 мянгатай байсан бол одоо 30 мянга болсон. Хонины мах 17 мянгатай байсан бол өнөөдөр 22 мянгатай байна. Сүү жилийн өмнө 3500 төгрөгтэй байсан бол 4500 болж өсжээ. Үйлдвэрлэл, нийлүүлэлт нэмэгдээгүй байна. Би том дүнгээрээ ярьж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ үнэлгээ ер нь 65 хувь би худлаа үнэлгээ гэж хэлэх гээд байгаа юм. Хянан шалгалтын газар энэ энэнээс ч доогуур үнэлгээ авах ёстой. Тэгэхээр ер нь зүгээр яг үнэнээ хэлэхэд хэдүүлээ энд үнэлгээ хийсэн болоод энэ хувийг нь бид нар яриад ингэж ярих нь яг үнэнээ хэлэхэд бол шаардлага байгаа юм уу гэж шүүмжлэх гээд байгаа юм. Тэгэхээр үнэлж байгаа үнэлгээгээ бид нар бодитой иргэн, аж ахуйн нэгжийн амьдралд өөрөө тулгарч байгаа бодит асуудлыг шийдэж чадсан эсэхийг бодитоор хэмждэг ийм ярьдаг КРІ үзүүлэлтийг тийм л үзүүлэлттэй болмоор байна. Алдаа гаргах юм бол холбогдох сайд удирдлагууд нь хариуцлага тооцдог тийм механизмтай ийм КРІ үзүүлэлтүүдийг нэвтрүүлмээр байна. Тэгэхгүй бол үндсэндээ энэ үнэлгээнд би итгэхгүй. Энэ бол үр дүнгүй тайлагнал байна л гэж үзэж байна. Тэгэхээр бараг асуулт гэхээсээ илүү би зүгээр санал хэлээд үгээ дуусгачихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Даваасамбуугийн Ганбаа гишүүн.

**Д.Ганмаа:** Оройн мэнд. Энэ Монгол Улсын Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг харж байна. Эрүүл мэндтэй холбоотой асуудлууд дээр л ярья. Ер нь эрүүл мэндийн асуудалд нь “Human Development Index”-ээр л гол нь хэмжигдэж байгаа. Гэтэл энэ олон улсын үзүүлэлт дээр ч гэсэн яг үздэг бодитой тоо буюу эрүүл урт нас буюу дундаж наслалт нь 24 онд 72.7 байсан нь 71.7 болоод буучихсан байна.

Хоёрдугаарт, энэ эх нялхсын эндэгдэл буюу энэ чинь маш том ерөөсөө л эрүүл мэндийн системийн байгаа байдлыг харуулдаг гол бодит байдаг. Энэ дээр мөн л бас суурь түвшнээсээ буураад ороод ирчихсэн эндэгдэл өндөртэй гараад ирчихжээ. Ийм байдлаар ингээд хараад байх юм бол энэ хүснэгт 1 дээр байгаа үзүүлэлтийг 24 оноос 25 онтой харьцуулахаар эрүүл мэндийн гол салбар үзүүлэлтийг үзүүлэх ёстой энэ суурь үзүүлэлтээсээ бүүр дордуулаад сүүлдээ дараа нь хүрэлцэх түвшин дээрээ нэг мөсөн тэрнээсээ ингээд оноогоо ерөөсөө муужруулж бүүр оруулж ирдэг болж байгаа юм байна. Энийг шогоор хэлэх юм бол уул нь ч энэ чих шоглоод байх ч юм бага л юм. Тэгэхдээ таргалаад байнгуут размераа томруулаад л өмдөө өмсөөд байгаатай адилхан.

Тэгэхээр гайгүй харагдах гээд. Энэ асуудлуудыг эрүүл мэндийн салбарынхан маань энэ салбараа яаж дүгнэж байгаа юм бэ? Сайд нар чинь энэ жилийн хугацаанд хэр зэрэг сайн ажилласан гэж бодоод байгаа юм, яаж дүгнэж байгаа юм? Одоо энэ авлигын индекс АТГ, авлигын индексээр ч гэсэн эрүүл мэндийн салбар жилийн дотор Эрүүл мэндийн яамны шууд авлигал огцом нэмэгджээ гээд ингээд ороод ирэх юм. Энэ авлигын шууд тохиолдол, шууд бус тохиолдол тэгээд төсвийн зарцуулалт, ил тод байдал шууд тохиолдол нь бүүр -50 оноо 100-аас энэ чинь. Яаж явахаараа ч ийм болдог юм тээ? Тэгээд кармагаас гардаг зардал, иргэдээс гарч байгаа зардлын асуудал. Энийг бүүр урьд нь 25 хувьдаа барья. Сүүлдээ 49 хувь гэж маргадаг байсан. Одоо бүүр санаа амар тэгээд бүгд кармагаасаа мөнгөө төлөөд л эмнэлэгт хэвтдэг боллоо.

Гуравдугаарт, энэ архаг өвчлөлийг энэ хэвтэлтийг нь багасгачихсан. Хэвтэлтийг нь багасгачхангуут нас баралтууд өндөр, хүндрэлүүд энэ эмнэлгүүд чинь бүр аюултай нөхцөл байдалд орчхоод байгааг мэдээж салбарынхан мэдэж л байгаа байлгүй дээ энэ чинь надаар хэлүүлэлгүй. Өдөр, шөнийн эмнэлгүүдээр явахад бүгд л хэлж байна. Бүх эмч нар ил гарч байна. Энэ дээр дунд буюу богино

хугацааны бодлого чинь юу юм бэ? Эрүүл мэндийн салбар эцсийн зорилгодоо хүрч чадаж байна уу, үгүй юу? Энэ ажил дээр ямар арга хэмжээ авч үзүүлнэ гэж бодоод байгаа вэ? Одоо би энэ KPI яриад л, тоо яриад л нарийн юм ярьдаг байсан ч бүр больж байна даа. Энэ удирдах салбарын ажилтнууд дээр ч гэсэндээ юу яриад байгаа юм? Таван жилийн төлөвлөгөөг бид нар батлаад Улсын Их Хурлаар таван жилийнхээ чиглэлийг гаргаад ирсэн шүү дээ. Тэгсэн чинь өчигдөр юу танилцуулж байгаа юм? Зүгээр төсөл хэлбэрийнхээ юмыг танилцуулаад байх юм. Төсөл болчихсон, баталчихсан хоёр юмаа ялгадаггүй юм уу? Халдварт, халдварт бус өвчнийг чинь хооронд нь ялгаад тус бүрд нь KPI-г нь зоож өгөөд гаргасан шүү дээ. Аргаа ядахаараа энэ Учрал дарга энэ тэр рүү л би явуулах юм. Энэ салбарын нарийн юмыг чинь яах аргагүй эрүүл мэндийн салбар нь л ярьж мэдэж ойлгох ёстой юм байгаа биз дээ? Түүнээс Ерөнхий сайдад яриад, Улсын Их Хурлын даргад яриад яах ч юм билээ дээ тийм биз дээ? Тэгээд ингээд нарийн ширийн юмнуудаа ингээд цөмөөрөө ярихаар зэрэг халдварт бус өвчлөл гэдэг чинь одоо бас л гол манай чиглэл юм байгаа юм. Халдварт бус өвчлөлийн суурь түвшнийг бас л бууруулаад ороод ирчхэж. 72.7-гоос 71.7 нас болж энэ насыг нь бүүр бууруулаад архаг өвчлөл, осол гэмтэл, нас баралт, эх нялхсын эндэгдэл бүгдээрээ дандаа муужруулсан дозоор ингэж оруулж ирээд байх юм. Энэ дээр бодлогоо сонсчихмоор байна. Маш яаралтайгаар дараагийн 3 сард.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат.

**Д.Очирбат:** Ганмаа гишүүний асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат хариулж байна. Түрүүн хэлсэн эрүүл мэндийн дундаж наслалтын үзүүлэлтүүд, асуудлууд хэлэлцэгдлээ. Манай салбар дээр бас дундаж үзүүлэлтийн асуудал олон шалтгаантай, бусад салбаруудаас бусад яамнуудаас шалтгаалсан олон нөхцөлүүд байдаг. Бид энэ дээр бас үнэлэлт, дүгнэлтийг сая удирдах ажилтны зөвлөгөөн дээрээ бас ярилцсан. Энэ сүүлийн харин 4 жилдээ эрэгтэйчүүдийн нас баралт, эмэгтэйчүүдийн нас баралтаасаа 4 дахин илүү тоо гараад байгаа.

Өөрөөр хэлбэл, 35-аас 65 насны эрэгтэйчүүд маань, эмэгтэйчүүд энэ насны эмэгтэйчүүдэд 4 дахин илүү нас баралттай. Энэ үзүүлэлт ч бас их нөлөөлж байгаа. Эх нялхсын эндэгдлийн бууралт эх нялхсын асуудлууд дээр бас яам, холбогдох байгууллага, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв үндэсний зөвлөлүүдтэйгээ удаа дараа хурлуудыг хийсэн. Бууралтын талаарх өсөлт энэ тал дээр арга хэмжээ авч байгаа гэж байна. Хэвтэн эмчлэх асуудлууд дээр Эрүүл мэндийн даатгалын сангаас хэвтэн эмчлүүлэх асуудал дээр Эрүүл мэндийн даатгалын сангаа бүтэн жилийн хугацаандаа эмнэлгүүддээ хүргэхийн тулд Эрүүл мэндийн даатгалаас бодлогын 3 асуудлыг авч хэрэгжүүлж байгаа.

Энэ бол нэгдүгээрт нь цочмог архаг өвчлөлийг нэн тэргүүнд 80 хувьтай санхүүжүүлэх, төлөвлөгөөт мэс засал, төлөвлөгөөт хагалгааг 60 хувьтай санхүүжүүлэх, архаг өвчлөлүүдийг хойшлуулж болох магадгүй сараар юм уу, 7 хоногоор хойшлуулж өгөх өвчлөлийгөө эхний удаадаа бас 60 хувиар санхүүжилтийг нь зарцаасан тохиолдлууд байгаа.

Тэгэхдээ энийг цаашаа яах вэ гэж бас асууж байна. Энэ өвчлөлийн сая Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 03, 04 дүгээр тогтоол батлагдсан.

Энэ тогтоол дээрээ бид Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлөөс Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгүүд дээр олгож байгаа санхүүжилтийн энэ саяын архаг, төлөвлөгөөт, цочмог өвчлөлүүдийг хязгаарыг авч хаяж байгаа. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн байгууллагууд тодорхой хэмжээнд өөрийн ашигтай үйл ажиллагааны коэффициент тэр цэг дээрээ хүрэх хүртэл нь Эрүүл мэндийн даатгалаасаа ямар нэгэн хязгаарлалтгүйгээр санхүүжүүлэх энэ шийдвэрийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 03, 04 дүгээр тогтоол дээрээ тусгаж өгч байгаа.

Халдварт бус өвчний талаар түрүүн бас асуулт асуулаа. Сая Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлагдан гарсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндэсний төв, Үндэсний зөвлөл бас Засгийн газрын хуралдаанаар орж шийдэгдсэн байгаа. 5 сарын 1-ндээ бид олон улсын хэмжээний өвчнөөс хяналт сэргийлэх урьдчилан сэргийлэх төвийг байгуулж дуусна. Шийдвэрийн төслүүд нь бэлэн болчихсон. Дараа нь шатлал шатлалаар аймаг, орон нутагтаа энэ халдварт болон халдварт бус өвчлөлийн.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал Ерөнхий сайд.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганмаа гишүүн надад бас мэдээллүүдийг өгөөд байгаа. Тэгээд Эрүүл мэндийн яамныхан бас хариуцлагатай ажиллах хэрэгтэй. Тэгээд яг нөхцөл байдал яг дүгнээд үзэхэд тийм биш байгаа юм байна лээ шүү. Тийм учраас би эрүүл мэндийн салбарт онцгой анхаарна. Одоо ер нь бүгдээрээ энэ хайрцагаасаа гарч сэтгэх хэрэгтэй шүү. Тэгэхгүй бол энэ Засгийн газрын ер нь үе үеийн Засгийн газрын үйл ажиллагаа иргэдэд үнэлэгдэж байгаа үнэлэмж бол энэ эрүүл мэнд, боловсролын салбар. Айл болгоны өрх болгоноор орж эрүүл мэнд, боловсролын салбар үе үеийн Засгийн газрын ажлын үр дүн. Энэ 2 салбараар хэмжигдээд байгаа юм.

Тийм ч учраас Их Хурал дээр энэ ажлын хэсэг Ганмаа гишүүнээр ахлуулж бас байгуулсан шүү дээ. Тэгэхээр энэ ажлын хэсгийнхээ үр дүнг би бас хүлээж авч ажиллана.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ганмаа гишүүн тодруулъя.

**Д.Бат-Эрдэнэ:** Энэ ер нь бид нар ингээд санхүүжилтээрээ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эсвэл хүргэх аргаа санхүүжилттэй хамаараад санхүүжилтээр удирдуулаад яваад байх ямар ч боломж байдаггүй. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх буюу үзүүлэх байгууллагын өөрийнх нь “Service Delivery Certifications” гээд бүүр тодорхойлолт байдаг. Тэр тодорхойлолтын үр дүнд бодит хэрэгцээнд суурилсан иргэдийнхээ эрүүл мэндийн асуудлыг авах учраас мөнгө төгрөгөөсөө болохгүй. Санхүүжилтээсээ ч болоод байгаа юм байхгүй. Сүүлийн 4 жил санхүүжилтийг 1.5-аас 4.6 дахин нэмэгдчихсэн лавлагаа шатлал дээр ч, анхан шатлал дээр ч. Сая Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын экспортууд хүрч ирээд энэ санхүүжилтээр хийсэн ажил чинь зөв байна. Санхүүжилтээр хийсэн энэ өөрчлөлтүүд дээрээ дагаж энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ёстой, товчхондоо Эрүүл мэндийн яам ажлаа хийхгүй байна, бодлогоо гаргахгүй байна, тусламж үйлчилгээнийхээ моделио бодит.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Санал хэллээ. Жанчивын Галбадрах.

**Ж.Галбадрах:** Оройн мэнд. Тайлан гэдэг хариуцлага тооцох бид нарын гол механизм гэж үзэж байгаа. Тэгээд энэ тайлангаас харахад салбар салбарын үр дүн их тааруу гарсан байна. Энэ үр дүнд үндэслээд ямар хариуцлагын тогтолцоо байдаг вэ? Ямар хариуцлага тооцож байна вэ Ерөнхий сайд аа гэж асуумаар байна. Ер нь гүйцэтгэлийн хариуцлага бид нарт ингэж тооцож явж чадахгүй л бол ажил маань сайжрахгүй, урагшаа явахгүй гэдгийг хэлье. Тэгээд энэ 2 индексийн холбоотой асуулт асууя. Хүний хөгжлийн индекс 193 орноос 96-д байсанг 95-д орно гэж зорилго тавьсан ч 104-д орсон байна.

Гэхдээ ингээд байр хойшлоод байхад хүний хөгжлийн арга хэмжээ авсны үр дүнд эерэг үр нөлөө гарлаа гээд бичээд сууж байгаа нь ямар зүйл вэ? Энэнээс ичихгүй юу гэж бас асуумаар байна. Тэр нь эерэг гэдгээ больё гэхэд ямар асуудлаас болов гэдэг тайлбарыг тавьчихвал болмоор байгаа юм. Энд жишээлбэл саяын яриад байгаа дундаж наслалттай холбоотой асуудал. Түүрүүн нэг гишүүн хэлж байна л байна лээ энэ бол гэмт хэрэг шүү гээд. Сая Ганмаа гишүүн асуучихсан учраас би бол орхиё.

Чанартай боловсрол гэсэн дараагийн нэг индекс байсан. Энэ индекс дээр 14.5-аас 13.6 болж бас буурсан. Үүний яг гол шалтгааныг яах в. ингээд үзэхээр байлаа л даа. Тэгэхдээ би Төрийн нарийн бичгийн, Боловсролын Төрийн нарийн бичгийн даргаас бас гол шалтгааныг та яг юу гэж үзэж байна вэ гэдгийг тайлбарыг бас сонсьё гэж бодож байна.

Би шинэ Засгийн газар бай байгуулагдаж байгаа учраас цаашид авах авах арга хэмжээтэй холбоотой бодит нэг ийм асуулт асууя гэж бодож байна. 2024 оны 10 сарын байдлаар 4200 багш дутагдалтай гэж зарлаад тэр нь 25 ондоо буурах биш тэр хэмжээндээ бараг 5000 багш дутагдалтай гэсэн энэ тоо явж байна.

Ер нь багшгүй болох бодитой аюул нүүрлэсэн. Багш нар ажлаасаа их хурдтай гарч байгаа. Багш нарын ажлаас гардаг хурд нэмэгдчихсэн гэдэг судалгаа байгаа. Тэгээд энд бодлогын ямар арга хэмжээ авч байна вэ? Би өөрөө ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд судлаачдаар хийлгэхээр 2030 онд хүртэл яг энэ шинжээрээ ийм арга хэмжээ авахгүй бол 19 мянган багшийн дутагдалд орох гээд байна. Бид нар ч угаасаа сургууль шинээр барих зорилтууд тавьчихсан байж байгаа. Нөгөө хүртээмжийг нь юуг нь дээшлүүлэхийн тулд. Ийм тооцоо 19 мянгыг багшийг бид нар зөвхөн тоогоор бүрдүүлэхгүй чанарын хувьд бүрдүүлэх гэдэг ийм шаардлага байгаа юм.

Тэгээд би ажлын хэсгийнхээ ахлагчийн хувиар саяхан 24 онд гишүүн болоод өөрийн биеэр яаман дээр, Боловсролын яаман дээр очиж энэ хомсдолын энэ талаар хэлээд бас бодлогын 4 арга хэмжээ аваач гэдэг санал болгосон. Үнэндээ Боловсролын яам энэ талаар бас дорвитой ямар ч арга хэмжээ аваагүй. Ер нь хуруугаа ч хөдөлгөөгүй гэж үзэж болохоор байгаа. Ирэх жил яах вэ гэдгийг бас Төрийн нарийн бичгээсээ асууя.

Би саяхан Эдийн засаг хөгжлийн яаманд 27 оны жилийн ажлын төлөвлөгөө, хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэгдэж байгаа учраас багшийн хомсдолын тоон болон чанарыг арилгах бодлого гэсэн тооцооллоо би 3 хуудсанд бичээд бүүр тайлбартай

нь, төсөл, хөтөлбөртэй нь ингээд явуулсан байгаа. Тэгээд энэ бичгийг Батхүү Төрийн нарийн бичгийн дарга хүлээж авсан уу? Тэгээд энд авсан бол та бүхэн энэ тал дээр бид нартай бас энэ тооцоолол хийж байгаа хүмүүстэй уулзаад ярих энэ талын арга хэмжээг бас тодруулж асууя. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал сайд.

**Н.Учрал:** Тэр үнэлгээ хийх журам байдаг бодлогын баримт бичгүүдэд. Үр дүнгүй хэрэгжүүлсэн зөвлөмжийг хэрэгжээгүй байгууллага албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг дээд шатны байгууллага албан тушаалтанд хүргүүлж хяналт тавьдаг. Хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ хариуцаж байгаа учраас Тэргүүн Шадар сайд үүнд хяналт тавьдаг. Тэгээд хяналт хэрэгжихгүй л байна.

Гэхдээ хяналт хэрэгжье гэхээр түрүүн миний хэлсэн тэр жилийн төлөвлөгөө 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр хэт олон мөрөөдлийн жагсаалт байна. Одоо 5 сарын 1-нд төсвийн хүрээ, ирэх жилийн төлөвлөгөө орж ирнэ. Би бас эрхэм гишүүддээ эртнээс хэлчихье. Би бас тоонуудтай танилцсан. Гайхамшиг бол бүтээхгүй. Би тийм гоё сайхан юм ярихгүй. Би бодит үнэнийг яриад хэмжиж болохуйц, хүрч болохуйц, цаг хугацаатай смарт гэж ярьдаг тийм л төлөвлөгөө оруулж ирнэ. Тэнд гоё сайхан юм сонсогдохгүй байж магадгүй. Гэхдээ хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх хэрэгтэй. Ийм л юм, ийм л нөхцөл байдал байгаа. Тэрнээс биш тийм гоё сайхан юм хийж чадахгүй юм байна лээ. Нөхцөл байдлаа та нар бас үнэнээр нь л ярих хэрэгтэй. Энэ манай энэ төрийн албан хаагч нар. Тэрнээс биш олон мөрөөдлийн жагсаалт биччихээд дараа нь хүрч чадахгүй ингээд сууж байх хэрэггүй шүү дээ.

Дээрээс нь Их Хурлын гишүүдээсээ бас нэг зүйлийг хүснэ. Нөгөө жилийн төлөвлөгөө орж ирэхээр ажлын хэсэг байгуулагдаж байна гэж хэлээд түрүүн Бат-Эрдэнэ даргын хэлдгээр нөгөө тойргуудынхаа ажлуудыг суулгадаг, бүсийн асуудлыг суулгачихдаг. Тэгээд нөгөөдөх нь батлагдахаар танихын аргагүй юм болчихдог. 5 жилийн чиглэл дээр ч тэр, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч тэр нөгөө Их Хурлын ажлын хэсэг ажиллаж байгаад танихын аргагүй юм болчихоор нөгөөдхөө хэрэгжүүлж чадахгүй байдалд хүрдэг учраас нэлээн ийм цомхон, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, цаг хугацаатай ийм л төлөвлөгөө оруулж ирье. Төсвийн хүрээгээ ч тэгж оруулж ирье. Тэгээд үнэнээ ярья. Үүн дээр нь янз бүрийн юм нэмэхгүй байж байгаад энэ хүндрэлтэй саадуудыг хамтдаа даваад гаръя.

Тэгэхээр Галаа багш маань энэ боловсролын салбарт багш хүний сэтгэлээр хандаж ирсэн. Түүнийг нь бид нар бас тэр талаас нь харж ажлуудаа эрэмбэлж явахгүй бол болохгүй байгаа юм. Тийм учраас дахин сургууль бариад багш олдохгүй. Орон нутагт сургууль бариад тэр орон нутгийнх нь нэмэгдлийг нь тэр өгөөд ч тийшээ багш сайн багш очдоггүй. Тэгэхээр одоо бид нар цэцэрлэгийг шийдсэн шиг бага сургуулийг шийдэхээс өөр арга зам бас үлдээгүй юм билээ. Тийм учраас би цогц төлөвлөгөөгөө танилцуулна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Бидний хувьд бас энэ чуулганы завсарлагаагаар эргэх холбоо хөтөлбөрийн хүрээнд бас тойргоороо нэлээн ажилладаг. Энэ үеэр бас иргэд олон

нийтээс маш олон асуултууд асуудаг. Үнэндээ заримд нь үнэндээ хариулж чадахгүй байгаа юм. Би яг хариулах ёстой хүмүүс нь энд хүрээд ирчихсэн учраас тэр асуултаас эхэлье гэж ингэж бодож байгаа.

Энэ төрийн албан хаагчдын цомхотголын асуудал 9 хувийн асуудал яригдаад аль өнгөрсөн онд яригдаад маш бүдүүлэг юм болж байна шүү төрийн албаны түүхэнд гээд би хэлж байсан. Тэгсэн дахиж ингэхгүй ээ энэ жоохон бидний алдаа гарлаа л гэж хэлсэн. Гэтэл сая явахад энэ маань үргэлжлэх байтугай бүүр эрүүл мэндийн салбар руу орчихсон байна. Эрүүл мэндийн салбар руу. Тэгээд өнөөдөр ингээд энэ тайлангаас аваад үзэхээр эрүүл мэндийн салбар дээр нялхсын эндэгдэл 2 промилоор өсчихсөн гээд ингээд ийм харамсалтай дүн мэдээтэй ингээд сууж байгаа.

Цааш нь дэлгэрүүлээд уншихаар Эрүүл мэндийн даатгалын сангийн хуулиа өөрчлөх ямар ч алхам хийгээгүй байна гэсэн ийм зүйл энэ тайлан дээр тусгагдчихсан байгаа. Өнөөдөр Эрүүл мэндийн яамныхан гарч ирээд ямар зовлон ярьж байна гэхээр Эрүүл мэндийн даатгалын санд их учир байна. Тэгсэн хэр нь тэр учир байгаа юмныхаа хуулийг өөрчлөхгүй ингээд яваад байдаг чинь ямар учиртай юм бэ? Энэ дээр Төрийн нарийн бичгийн дарга та тодорхой хариулна уу надаа.

Дээрээс нь энэ орон тооны цомхотголтой холбогдуулаад Эрүүл мэндийн төвүүд сумдын. Энэ төвүүд чинь магадлан итгэмжлэлийн шалгалтад тэнцэхгүй. Яагаад гэвэл норм норматив нь зөрчигдчихсэн ийм байдал руу орж байна гэж байгаа юм. Тэгээд эд нар чинь бүгдээрээ магадлан итгэмжлэл авч чадахгүй байвал тэгээд эрүүл мэндийн салбар яг яах юм? Тэгэхээр норм нормативаа шинэчлээгүй, яг хуучнаар нь явж байгаа, магадлалынх нь яг тэрүүгээр нь шалгах гээд байдаг.

Тэгсэн хэр нь хүнээ хал гэдэг. Төрийн нарийн бичгийн дарга та бол видео хурал хийгээд маш хатуу үүрэг өгсөн байна лээ шүү дээ. Тэгээд надад сумд явж байгаад асуулт асуусан би үнэндээ хариулж чадаагүй. Одоо тэрийг та хариул өөрөө. Нэг сумын Эрүүл мэндийн төвийн жолооч, үйлчлэгч, лаборант гурвын аль нэгийг нь сонгож халах ёстой болсон байна. Ажиллуулахаар цалин байхгүй. Энэ дээр надаас асуусан. Би хариулж чадаагүй шүү. Одоо а надад хариулж. Та өөрөө ийм үүрэг өгсөн байна лээ. Энэ гурвын аль нь хэрэггүй юм бэ? Энийгээ тодорхой хэлчих. Тэгээд ямар ч тийм чиглэл байхгүй хүн хал гэдэг. Халж чадахгүй болохоор цалинг нь хасаад хаячихдаг. Тэнд энэ 330 сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нар тэнд бүлтэлзээд сууж байгаа шүү. Энэ дээр та маш тодорхой хариулаарай.

Дараа нь энэ боловсролын салбартаа энэ цалин цагааных нь асуудал тэгээд ийм өнөөдөр нэг ийм учраа олж байгаа юм шиг юм сошиалаар яваад эхэлж байна. Тэгээд нэг юм болж байгаа юм байлгүй дээ. Заримдаа ер нь тэр энэ асуудлуудыг яриад тайлбарлаад зогсох нь битгий хэл нөгөө ширээн доогуураа орчихмоор нүүр халуун юмтай олон тулсан шүү.

Тэгэхээр энэ боловсролын салбарынхны нэг яриад байгаа зүйл энэ бас ямар ч тийм бодлого байхгүй. 2011 оны Засгийн газрын тогтоолоор дотоод хяналтын ажилтан авч ажиллуул гээд тогтоолтой гэж байгаа. Тэрийг нь авч ажиллуулаад 20 хувийн урамшуулал өгөхөөр аудит нь ирээд торгочихдог гээд

байгаа юм. Акт тавьчихдаг гээд байгаа юм. Тэгэхээр энийг ер нь яг яах ёстой юм? Тэгээд шалгалт ирэхээрээ танай дотоод аудитын ажилтан аль вэ? Энэ аудитын ажилтан ер нь юу хийсэн, санхүүгийн аудит хийсэн үү, хяналт тавьсан уу, боловсон хүчин, хоол унд бүх юмыг нь шалгадаг гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө захирлууд тэрийг ажиллуулъя гэхээр ажиллуулж болдоггүй, байя гэхээр байж болдоггүй. Аргалаад нэг юм ажиллуулчихаар аудит акт тавьчихдаг.

Тэгэхээр энэ ингээд энэ дээр энэ төрийн байгууллагын яг төрийн захиргааны алба хаагчид та нар сууж байгаа учраас яг бас яг яах ёстой юм бэ? Тэгээд энэнээс чинь болоод саяын энэ боловсролын салбарт боловсон хүчний асуудал эд нар гэж чи бас

**Ж.Бат-Эрдэнэ:** Хариулъя Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Дараа нь боловсролынх тээ. 4 номерын микрофон.

**Д.Очирбат:** Монгол Улсын Засгийн газраас 9 хувийн цомхотгол буюу хэмнэлтийн эрх зүйн зохицуулалт гарсан. Энэтэйгээ холбогдуулаад манай эрүүл мэндийн салбарт нийтдээ 39 мянган ажилтан ажиллагсдын 9 хувь буюу 2400 цомхотголд орох, чөлөөтэй болон орж ирсэн, ажлаас чөлөө аваад гарсан улсуудыг дахиж ажилд нь оруулахад нь бас царцаах, тэгэхдээ чиглэлээр Засгийн газрын тогтоолгох чиглэлээр нь яг эмч, эмнэлгийн сувилагч, яг хүн дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг энэ ажилтан дээр цомхотгол явуулахгүй гэж зааж өгсөн.

Тэгээд бид өнөөдрийн байдлаар түрүүн таны хэлсэнчлэн бүх орон нутаг эрүүл мэндийн нэгж байгууллагуудаа энэ шинэчлэл чиглэлүүдийг өгсөн байгаа. Энэ дээрээсээ манайх өнөөдрийн байдлаар 1200 хүний орон тооны цомхотгол, дээрээс нь илүү нэмэгдэл ажлууд, дээрээс нь сая КОВИД-ын үед нэлээн орон тоонууд нэмэгдсэн. Жишээлбэл, эрүүл мэндийн эмнэлгийн дарга нар ажлын албатай болсон байна, зөвлөхүүд ихтэй болсон байна. Тэр чиглэлүүдийг эмч, эмнэлгийн ажилд сувилагчдаас бусад цомхотголууд дээр түлхүү анхаарч ажиллаж байгаа.

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг түрүүн хэлсэн. Бид хууль, эрх зүйн зохицуулалт дээр хуулийн төсөл маань Улсын Их Хуралд өргөн барихад бэлэн болсон. Ажлын хэсэг дээрээ хэлэлцэгдсэн. Хэд хэдэн удаа хэлэлцэгдсэн. Их Хурлын гишүүдтэйгээ уулзаж ярилцаж байгаа. Хамгийн түрүүнд Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, гүйцэтгэл, санхүүжилт, 1 иргэний санхүүжилтээ нэмэгдүүлэх тал дээр бодлогын чанартай олон асуудлуудыг авч хэрэгжүүлж байна.

Бид сүүлийн 4 жилдээ өрхийн эрүүл мэндийн байгууллагууддаа 1 иргэнээс санхүүжих санхүүжилтийг ерөөсөө 1 ч төгрөг ч нэмээгүй байсан. Өнөөдөр энэ жил бид нар 54 тэрбум төгрөгөөр 1 иргэнээс санхүүжих санхүүжилтийг нэмж өгч байгаа.

Мөн дээрээс нь Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг орж ирсэн сангийнхаа хэмжээндээ, сангийнхаа зохицуулалтдаа бид сар сард нь хуваарилуулаад тэгээд гүйцэтгэл нь хүрэхгүй болонгуут нь сүүлийнхээ 12, 11 дэх саруудаасаа урагш нь татаж санхүүждэг, урагш нь татаж хойд хормойгоор урд

хормойгоо нөхдөг байсан. Энэ жилийн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартайгаа бид нар сая ЭМДҮЗ-ийн тогтоол гаргуулаад, бүх саруудынхаа хуваарийг гаргуулаад эмнэлгийн байгууллага нь яг ашигтай ажиллах тэр түвшин, ашигтай ажиллах, алдагдалгүй ажиллах тэр хугарлын цэг дээр нь очих хүртэл Эрүүл мэндийн даатгалын сангаас ямар нэгэн хязгаарлалт тогтоохгүйгээр санхүүжүүлэх шийдвэрээ гаргаж өгөөд ажиллуулж байгаа. Анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудаа бас эмч нар.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал ерөнхий сайд.

**Н.Учрал:** Тэр эрүүл мэндийн салбар дахь 9 хувийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд бол эрүүл мэндийн салбар, боловсролын салбар хамаарахгүй гээд шийдсэн тээ? Уул нь тэгсэн. Тэгээд яагаад ийм байдалтай байгаа юм?

Хоёрт, тэр Хэрэг эрхлэх дээр чиглэл өгдөг. Түүнийг нь орон нутаг хэрэгжүүлэх гээд зорихоор аудит ирээд акт тавьчихдаг. Энэ хоорондоо холбогдохгүй юмаа хэзээ болих юм бэ? Магнайсүрэн дарга дараа нь бас тайлбар хэлэх хэрэгтэй. Хэрэг эрхлэх дээр ингээд чиглэл өгөөд 9 хувь хэмнэхгүй гэхээр орон нутагт тэр акт тавьчихаар бид яах юм бэ? Ийм л байна. Тэгээд эрүүл мэндийн салбар, боловсролын салбарт 9 хувийн хэмнэлт байхгүй шүү. Хэмнэх бол өөр газраасаа хэмнээрэй. Би боловсрол, эрүүл мэнд дээр хэмнэлт хийлгэхгүй шүү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Та нөгөө ухна ишигний зовлонг мэдэхгүй гэдэг шиг хариулт өгөөд байна л даа. Би танаас тодорхой асуусан шүү дээ. Таны салбарын сумын Эрүүл мэндийн төвд жолооч нь хэрэггүй юм уу, үйлчлэгч нь хэрэггүй юм уу, лаборант нь хэрэггүй юм уу? Та нар цомхотгол гэхээсээ илүүтэй эхлээд нормативаа ярих ёстой байсан юм биш үү? Дараа нь магадлалд очихоор яах вэ? Магадлалынх юм хөдөө орон нутгийн зовлон мэддэггүй үүдэнд нь нэг мод байхад магадлалаас нь хасаад хаячихдаг гэж байгаа шүү дээ. Тийм зовлон бас ярьж байна лээ.

Тэгээд орон нутгийн зовлон мэдэхгүй, өөрсдөө явахгүй, танай сайд бол Хэнтий аймгийг тойроод давхиад байна лээ. Сайхан инээсэн зураг авхуулаад л байна лээ. Надтай мэдэхгүй эрүүл мэндийн салбарт инээгээд уулзаж байгаа хүн уулзаагүй шүү. Эрүүл мэндийн салбарт үйлчлүүлээд инээгээд гарч байгаа хүн их олон таараагүй шүү. Зарим сумдын эмнэлгүүд бараг бараг нөгөө үзэх хүнээ үзчихээд бараг хаалгаа хаачих хэмжээнд оччихсон байна гэдэг юм ярьж байна лээ шүү. Тэгээд та бол энд гоё юм яриад байна. Тэр хууль, эрх зүйн юм чинь огт хөдлөөгүй байна гэж энэ дээр байгаа учраас би асуугаад байгаа юм. Тэр аудитынхан энд бас хариулах хэрэгтэй.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4 номер.

**С.Магнайсүрэн:** Идэрбат гишүүний асуултад хариульъя. Ер нь санхүүгийн аудит цаглаварт хугацааныхаа дагуу яваад энэ 24 сарын 26-нд бүх төсвийн ерөнхийлөн захирагч болоод төвлөрүүлэн захирагчдынх дуусна. Ингээд санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бид нар нэгтгэж Их Хуралдаа өргөж ингэж хэлэлцүүлнэ.

Өнөөдрийн байдлаар яг ийм тодорхой тохиолдол надад одоогоор мэдээлэл байхгүй байгаа. Ер нь акт тавих ёсгүй. Саяынх дээр акт тавихгүй. Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн бол анхны тохиолдолд бид нар албан шаардлага өгнө. Дараагийн удаа бол акт гээд ингээд шат ахиад явах ёстой. Хэрвээ ийм тохиолдлууд байвал би одоо анхааралдаа авъя. Одоо манайх 9 хувийг яаж хэрэгжүүлж вэ гэдэг судалгааг тусгайлан нэгтгэж авч байгаа. Энэ дээр тодорхой аудитын шийдлийг гаргасан байх ёсгүй. Хэрвээ тийм тохиолдлууд байвал би энэ дээр бас холбогдох арга хэмжээг аваад явж болно.

Яагаад гэвэл аймаг орон нутагт өөр өөрөөр хэрэгжсэн тохиолдолд бид нар нэг мөр шийд.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Ерөнхий сайд бас энэ дээр боловсролын, эрүүл мэндийн салбар дээр энэ 9 хувийн цомхотголыг эргээд харна гэж байгаад бас туйлын баяртай байгаа. Тэгэхгүй энэ салбар 2 салбарын чанар, хүртээмжийн асуудлууд ч гэсэн энд их нэлээн хурцаар яригдаж байгаа юм байна лээ.

Нөгөө талдаа энэ саяын жишээ бол олон жил явж ирсэн жишээ байхгүй юу. Орон нутагт ажиллаж байхад ийм зовлон маш их байдаг. Хэдэн төрийн байгууллагууд нь хоорондоо уялдаагүй. Тэгээд доошоогоо л бөөн ташуур буулгаад байдаг. Тэгээд яг энэ шиг ийм жишээ нь тэр албан хэрэг хөтлөлтийн сая улсын үзлэг болсон юм байна лээ шүү дээ. Бас сум тэр сургууль тийм ажилтан байхгүй. Тэгсэн хэр нь маш нарийн шалгаад байна гээд байгаа. Энэнээс болоод хүн ажлаас хална гэсэн гэж байгаа юм.

Тэгэхээр ер нь энэ төрийн энэ шалгалт байдаг юм уу энэ юмаа бас нэлээн тийм уялдаатай, ойлгомжтой байхгүй бол Genz үеийнхэн энэ төрийн албанд ороод ирсэн. Ийм утгагүй юмыг сонсоод ер нь уур нь хүрээд нөгөө хаалга саваад гарна гэдэг чинь болж байна гэсэн шүү. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Чинбатын Номин гишүүн.

**Ч.Номин:** Та бүхэндээ энэ оройн мэндийг хүргэе. Өмнөх Засгийн газар буюу Занданшатар Ерөнхий сайдын Засгийн газар ажлаа аваад бас ажил үүргээ гүйцэтгээд бараг жил орчим болж байна. Бид өнөөдөр хийсэн ажлыг нь дүгнээд тайлангаа хэлэлцэж байгаа. Уг нь ажлаа өгч байгаа, үргэлжлүүлээд цаашаагаа Засгийн газрын гишүүнээр үлдэх гэж байгаа сайд нар маань ажлаа хариуцлагатайгаар тайлагнаад цаашаа үргэлжилсэн бол илүү ажил хэрэгч байх байсан болов уу гэж бодож байна.

Нөгөө талдаа Занданшатар Ерөнхий сайдын ийн төсөв батлуулах гэж байх үед буюу 2026 оны төсвийн үеэр бид нар бас яг энэ талаар ярьж би бас энэ асуудлыг тавьж байсан. Яг тухайн үед 21 мянган аж ахуйн нэгж татвар болон нийгмийн даатгалаас шалтгаалаад дансаа хаалгачихсан, үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэхэд маш хүндрэлтэй болчихсон байна гэдэг ийм тоон мэд ил байсан.

Өнөөдрийн байдлаар энэ тоо 30 орчим мянга болсон байна гээд гарч ирж байна. Бид нар өнөөдөр валютын нөөц 7 тэрбумд хүрлээ, эдийн засгийн өсөлт 6.7 хувь боллоо гээд хэчнээн ийм сайхан статистик ярьж болно. Учрал Ерөнхий сайд аа яг өнөөдөр эдийн засаг ийм хүндэрч байгаа үед аж ахуйн нэгжүүд маань хаалгаа барьж цаашаа үйл ажиллагаа явуулахад хүндэрч байна.

Энэ нөгөө талдаа процессын ийм хүндрэл байгаа. Тэгэхээр та чөлөөлье гэдэг ийм аян явуулж байгаа. Тэгээд энэ ч утгаараа энэ аж ахуйн нэгжүүд, нэн ялангуяа энэ эдийн засгийг нуруун дээрээ үүрээд явж байгаа аж ахуйн нэгжүүдээ дэмжсэн бодлогыг цааш нь хэрэгжүүлж авч яваач гэж хэлмээр байна. Бодлого байхаасаа гадна цаашлаад үргэлжлээд энэ Сангийн яам, Сангийн яамны харьяа агентлагууд дээр энэ процессын нөхцөл байдал дээр анхаармаар байна.

Тэгэхгүй бол аж ахуйн нэгжүүд маань хаалгаа бариад, цаашлаад энэ эдийн засагт үүсэж байгаа үнийн өсөлтүүдээс болоод цалингаа тавих, үргэлжлээд бүүр ямар нэгэн байдлаар татвар төлөх нь битгий хэл үйл ажиллагаагаа явуулахгүй ийм боломж, нөхцөл үүсэж байна шүү гэдгийг бас анхааруулмаар байна.

Би үргэлжлүүлээд аялал жуулчлалын асуудлаар асуулт асууя гэж бодож байна. Миний хувьд бас энэ асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн байсан. 1 жилийн хугацаанд ажлаа хийх боломж олгоё гэж бодоод ямар нэгэн асуудал тавиагүй. Өнөөдөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбараар тодорхойлсон. Энэ ч утгаараа 3.3.5-д 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ гэж заасан. Энэ хүрээнд Учрал сайд бас өөрөө энэ Засгийн газарт байх хугацаанд 2025 оны 5 дугаар сарын 21-ний 255 дугаар тогтоолоор 6 хувийн хүүтэй 6 жилийн хугацаатай аялал жуулчлалын салбарыг дэмжих зээл батлуулсан. Энэ зээлийн хүрээнд 2025 онд ойролцоогоор 110 сая гаруй, 110 тэрбум гаруй төгрөгийн зээл гарах боломж, энэ жил мөн ялгаагүй ийм хэмжээний төсөв тавигдсан байгаа.

Яг өнөөдрийн байдлаар аялал жуулчлалын байгууллагуудаас надтай холбогдож байна. Энэхүү зээл 1 ч төгрөг гараагүй байгаа гэдэг ийм зүйл яригдаж байна. Би аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Төрийн нарийн байх шиг байсан. Өнөөдрийн байдлаар хэдэн төгрөгийн зээл гарсан байгаа вэ гэдэг асуулт тавимаар байна.

Яагаад энэ чухал вэ гэхээр бид нар өнөөдөр энэ хөрөнгө оруулалтыг оруулж байж жуулчдыг ирэхэд бид нар аятай, тухтай орчныг бий болгоно. Нөгөө зам дагуу байгаа ариун цэврийн байгууламжтай төвүүдийг бий болгоно. Нөгөө хэлээд байгаа өвлийн улиралд аялал жуулчлалын хүлээж авах боломжуудыг бий болгоно. Жуулчдын тоог нэмэгдүүлэгч нь үүснэ. Тэгэхээр яг өнөөдрийн байдлаар хэдэн төгрөгийн зээлийг хэдэн байгууллагуудад өгчихсөн байгаа бөгөөд үүний үр дүнд хэдэн дэд бүтцүүдийг бий болгож байгаа вэ гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт мөн энэ, үүнтэй зэрэгцээд агаарын тээврийн нөхцөл дээр илүү давуу талуудыг бий болгоно. Нэг ёсондоо олон газар луу нислэг бий болгоно. Цаашлаад визний нөхцөлүүдийг хөнгөвчилнэ өө гэсэн зүйлүүд байгаа. Энэ дээр хэдэн улсад визний нөхцөлийг хөнгөвчилсэн бэ? Хэдэн улсад шинэ нислэг бий.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайд.

**Н.Учрал:** Газрын тосны бүтээгдэхүүний үнэ өсөж байна. Түлш шатахууны үнэ өсөж байна. Энэ Ойрх дорнодын дайн, мөргөлдөөн чинь манайд асар хүчтэйгээр нөлөөлнө шүү дээ. Ийм үед хувийн хэвшил, баялаг бүтээгчид, бизнесийнхэнд тус болж чаддаггүй юм гэхэд ус болохгүй байх ёстой. Тийм учраас би энэ Номин гишүүний хэлж байгаа санааг дэмжиж байгаа юм. Намайг Ерөнхий сайдаар ажиллах хугацаанд хувийн хэвшлийн, бизнесийнхний, баялаг бүтээгч нарын үйл ажиллагаанд саад тотгор болж байгаа янз бүрийн ашиг сонирхлын зөрчил гаргаж байгаа хэнтэй ч би ойлголцож цаашдаа ажиллах бололцоогүй шүү. Тийм учраас төрд байгаа албан хаагч нарт хэлэхэд, бүх шатынханд би хэлэхэд хийе бүтээе, хөдөлмөрлөө гэсэн хэн бүрийг дэмжинэ. Өрхийн орлогоо нэмэгдүүлье гэсэн ямар ч санал санаачилга гаргасан хэн бүрийг дэмжинэ. Тийм учраас хүнд суртал үүсгэхгүй. Тэр эдийн засгийн эрх чөлөө гэж ярилаа. Үүнийг ажил болгоно. Бид төрийн зүгээс давхар давхар шалгалт явуулахыг би хориглоно. Улаан канттай тамгатай хүмүүс холхон байна шүү бизнесийнхнээс гэдгийг хэлмээр байна.

Тийм учраас нийслэл, аймаг, орон нутаг, бүх түвшинд Зөвшөөрлийн хуульд зааснаас өөр төрлийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх ёстой. Саад битгий болоод бай. Тийм учраас манай Засгийн газар бизнесийнхнийг дэмждэг, гадаадын хөрөнгө оруулагч нараа дэмждэг, баялаг бүтээгч нараа дэмждэг хүссэнээрээ сайхан амьдрах бололцоог бий болгох Засгийн газар байна. Тийм учраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ёстой. Ерөөсөө саад болж болохгүй. Шалгалт ч гэсэн хянан шалгах гэхээсээ илүүтэйгээр тэр зөвлөн туслах ёстой гэж бид хэдэн жил ярив. Одоо зөвлөн туслах зорилгоор л тэр шалгалт хийгдэнэ. Ард иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгох зорилгоор хяналт, шалгалт хийгддэг болохоос биш очиж хяналт, шалгалт хийж зүв зүгээр үйл ажиллагаа явуулж байгаа компани, аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаанд нь саад тотгор учруулахыг хориглоно шүү.

Тэгэхээр ийм ашиг сонирхол гаргаж байгаа янз бүрийн үйлдэл тогтоогдох юм бол надад бүх талаар хэлээрэй. Янз бүрийн набор чихэр нэхээд хоол унданд оръё гээд байгаа нөхдүүд байвал над руу хэлээрэй. Би хариуцлага тооцно. Одоо ийм цаг үед тус болохгүй юм бол ус битгий гэдгийг бүх шатныханд хэлж байна. Шалгалтыг нэг мөр болгоно. Зөвшөөрлийг зөвхөн цахимаар олгоно. Хаврын чуулганаар энэ Энхтүвшин гишүүний ахалж байгаа хуулийг батлаад тэрнээс хойш би өөрөө нийслэлээр, дүүргүүдээр явж шалгана гэдгийг бас хариуцлагатай хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Аялал жуулчлалын яам 4 номер

**Б.Бат-Эрдэнэ:** Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Бат-Эрдэнэ. Номин гишүүний асуултад хариулья.

2025 оны 5 сард Засгийн газрын 255 дугаар тогтоолоор аялал жуулчлалыг дэмжих ингээд хөнгөлөлттэй зээлийг төлөвлөсөн. 2026 онд яг энэ зээлийг одоогийн байдлаар ерөнхий гэрээг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам гуравласан гэрээ хийгээд арилжааны банкнуудтайгаа нийлээд 2 долоо хоногийн өмнө ерөнхий гэрээ зурагдсан. Тус гэрээний нөхцөл бол өмнөх 23 онд тавигдаж байсан аялал жуулчлалыг дэмжих

зээлээс нөхцөл нь илүү хөнгөрсөн. 6 жилийн хугацаатай 6 хувийн хүүгийн татаастай ийм зээл байгаа.

Ирэх долоо хоногт яг ерөнхий гэрээ зурагдсантай холбоотой арилжааны банкнууд дээр Монголбанкнаас аль банк нь арилжааны 10 банк байгаа. 10 банканд энэ 250 тэрбум төгрөгийг хуваарилах тэр мэргэжлийн индексүүд дээрээ хуваарилалт хийгээд арилжааны банкнууд дээр ирэх долоо хоног гэхэд гарч эхэлнэ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Номин гишүүн тодруулъя. Нислэг, визтэй холбоотой хэн тодруулах вэ?

**Ч.Номин:** Виз Хууль зүйн яам, нислэг Зам, тээврийн яам.

**Ж.Бат-Эрдэнэ:** Өөрийгөө танилцуулаарай 4 Номер.

**Б.Болор-Эрдэнэ:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2025 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт агаарын тээврээр зорчигчдын тоо 10 хувиар өсөж, 2 сая 400 мянгад хүрсэн байгаа. Нислэгийн тоо 18 хувиар нэмэгдсэн. Хамгийн өндөр хувиар нэмэгдэж байгаа манай тээврийн салбарын нэг байгаа. Шинээр Сингапур, Шанхай руу тогтмол нислэгүүд хийж эхэлсэн боловч агаарын хөлгийн түлшний үнэ огцом нэмэгдсэнээс шалтгаалаад эдгээр нислэгүүд бас түр зуур одоогоор зогссон байдалтай байна.

Аялал жуулчлалыг дэмжих хүрээнд орон нутгийн нисэх буудлуудыг шинэчлэх, сайжруулах үйл ажиллагаануудыг авч явууллаа. Өнгөрсөн жил Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлын нисэх зурвасыг шинэчлэн ашиглалтад оруулсан байгаа. Одоо Хэнтий аймгийн Дадал сумд нисэх буудлын цогцолбор.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 минут нэмье.

**Б.Болор-Эрдэнэ:** Энэ оны хувьд Ховд, Мөрөн, Чойбалсан, Гурвансайхан буудлууд дээр олон улсын нислэгийг авч Улаанбаатар хотоор дамжихгүйгээр шууд олон улсын нислэгүүдийг дээрх бүс нутгийн нисэх буудлууд дээр авах бэлтгэл ажлыг хангаад явж байна. Энэ нь бас гадаадаас шууд ирэх зорчигчдын зардлыг бууруулах, аялал жуулчлалын бүс нутгуудыг хөгжүүлэхэд тодорхой чиглэл болно гэж төлөвлөж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болсон уу? Хууль зүйн яам визийн талаар 4 номер

**Н.Мягмар:** Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Номин гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс визийн шаардлагаас харилцан татгалзах гэрээтэй улс орнуудаас бусад улс дээр визийг цахимаар мэдүүлэх бүрэн бололцоог олгочихсон. Тийм учраас суугаа улс орны Элчин сайдын яамнаас очиж хамааралгүйгээр цахимаар виз мэдүүлээд хил дээр ирээд визээ аваад ингээд орж ирэх цахим ийм систем нэвтэрчихсэн байж байгаа.

Бусад визийн шаардлагаас чөлөөлөгддөг улс орнууд бол визгүй ингэж орж ирэх боломж нь Гадаадын иргэн, харьяатын газраас үзүүлж байгаа гэдгийг хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Номин гишүүн тодруулъя.

**Ч.Номин:** Баярлалаа. Уг нь энэ визийг заавал янз бүрийн ачаалалгүйгээр олгоод явж байх юм бол жуулчид, нэн ялангуяа Азийн бүсэд байгаа жуулчид шийдвэрээ маш богинохон хугацаанд гаргадаг хүмүүс байдаг. Тэгэхээр богино хугацааны шийдвэр гаргаж байгаа хүмүүст хөнгөлөлттэй виз гэхээсээ илүү орж ирэх боломжийг илүү болгосон бол илүү дээр байх байсан гэж харж байна.

Хоёрдугаарт, энэ хил орчмын аялал жуулчлал энэ дээр тулгуурлаад гацаад байгаа үүнийгээ энэ 3 яам шийдэх ёстой Хууль зүйн яам, Гадаад харилцааны яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам шийдэх ёстой шүү. Энэ дээр анхаарч ажиллаарай гэж сануулмаар байна.

Хоёрдугаарт, аялал жуулчлалын асуудалтай холбогдолтой маш дутагдалтай ажилласан байна гэж үзэж байна. Залуучууд аа, Бат-Эрдэнэ Төрийн нарийн аа энд тэнд очиж ямар нэгэн зүйлийг нээх юм уу эсвэл очиж соёл урлагийн байгууллагуудын нээлтэд очих аялал жуулчлалыг хөгжүүлэхгүй. Аялал жуулчлал бол зөвхөн хувийн хэвшил дээрээ тулгуурлаж явдаг. Хувийн хэвшлүүд аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Тэгэхээр.../минут дуусав./

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 минут сунгая.

**Ч.Номин:** Төрөөс бодлогоор зөвхөн энэ хувийн хэвшлийг дэмжсэн бодлогуудыг явуулах ёстой. Энэ 6 хувийн хүүтэй 6 жилийн хугацаатай зээл бол хөнгөвчилсэн term гараагүй. 255 дугаар тогтоолоороо л 6 хувийн хүүтэй 6 жилийн хугацаатай зээл байсан. Энэ зээл 1 жил гараагүйгээсээ болж 1 тэрбум долларын орлого Монголд орж ирэх боломжийг алдагдуулж байгаа шүү. Энийгээ та бүхэн анхаарах ёстой. Цаашдаа энэ гарахгүй байх өдөр болгон манай улс алдагдсан боломжтой бий болж байгаа гэдгийг анхаарч ажиллаарай. Тэгээд энэ зээлийг маш яаралтай гаргах хэрэгтэй. Монголбанктай тохирчихсон байсан, арилжааны банкнуудтай тохирчихсон байсан. Надад ийм илүү тайлбар хийхийг буруу гэж үзэж байна би.

Тэгэхээр энэ зээлээ яаралтай гарга, хувийн хэвшлээ дэмж, бэлэн санхүү чинь төсөв чинь байгаа. Тэгэхээр энэ дээрээ анхаарч ажиллаарай. Дараа дараагийн ажил авах гэж байгаа сайд нь энэ дээрээ анхаараарай гэж хэлмээр байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцлээ.

Нийт 21 гишүүн үг хэлж, асуулт асууж, хариулт авлаа. Идэвхтэй оролцсон гишүүддээ талархал илэрхийлье. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

19.50 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*